



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-8</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>9-80</i>
<hr/>	
<i>1. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/</i>	<i>11-11</i>
<hr/>	
<i>2. “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/</i>	<i>11-12</i>
<hr/>	
<i>3. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/</i>	<i>12-54</i>
<hr/>	
<i>4. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/</i>	<i>54-55</i>
<hr/>	
<i>5. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>55-58</i>
<hr/>	
<i>6. Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан асуулгын хариу сонсох</i>	<i>58-77</i>
<hr/>	
<i>7. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох</i>	<i>77-80</i>
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 15 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

*Томилолттой: Т.Аубакир, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, Л.Энх-Амгалан;*

*Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн  
Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр;*

*Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужин, Ш.Раднаасэд;*

*Тасалсан: Ш.Адъяа, А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Д.Батлут, С.Ганбаатар,  
Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир;*

*Хоцорсон: С.Амарсайхан-08 минут, С.Батболд-1 цаг 52 минут, Э.Батиугар-41  
минут, Б.Баярсайхан-43 минут, Х.Болорчулуун-1 цаг 24 минут, Г.Дамдинням-01 минут,  
Б.Жавхлан-3 цаг 04 минут, Ц.Мөнх-Оргил-18 минут, Г.Мөнхцэцэг-02 минут, Н.Учрал-07  
минут, Ч.Хүрэлбаатар-18 минут, Д.Цогтбаатар-36 минут, Б.Чойжилсүрэн-02 минут,  
Б.Энх-Амгалан-10 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

**Нэг. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ нар байлцав.

**Г.Занданшатар:** “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 15

Бүгд: 42

64.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ нар байлцав.

**Г.Занданшатар:** “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 14  
Бүгд: 43  
67.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, “Эрдэнэс Монгол” Хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, “Эрдэнэс Тавантолгой” Хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын ахлах менежер Б.Гэрэлээ, Хөрөнгө, оруулалтын газрын дарга Г.Гантулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт Д.Нямдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Х.Баделхан, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн, Т.Доржханд, Ц.Туваан, Э.Батшугар, Ж.Батжаргал, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, “Эрдэнэс Монгол” Хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс Тавантолгой” Хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Б.Баттөмөр нар үг хэлэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 21  
Бүгд: 42  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 19  
Бүгд: 41  
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 19  
Бүгд: 41  
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл өмнөх завсарлагаа сунгаж, ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 3 өдрийн завсарлага өгөв./13:25/

***Тав.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Үдийн завсарлагааны цаг болсон тул санал хураалтыг хойшлуулав./13:35/

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 20 минут үргэлжилж, 13 цаг 35 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 07 минутад эхлэв.*

***Зургаа.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан асуулгын хариу сонсох***

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Нийслэлийн ерөнхий архитектор, Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Д.Хан-Уул, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Д.Авирмэд, Нийслэлийн Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын дарга Г.Баттулга, мөн газрын Ерөнхий инженер Г.Одончойжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Хангай нар байлцав.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 14 цаг 12 минутаас хуралдааныг даргалав.*

Асуулгын хариуг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн танилцуулав.

Асуулгын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Баттөмөр, Э.Батшугар, М.Оюунчимэг, Ж.Батсуурь, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, “Нийслэлийн орон сууцны корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг “Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг хэлэлцлээ.

*Уг асуудлыг 15 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

***Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох***

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар дараах хууль, Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль; /15:18/

***Дагалдан гарсан:***

2.Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:19/

3.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /15:19/

4.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:19/

5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:19/

6.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:20/

7.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:20/

8.Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /15:20/

9.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:20/

10.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:20/



11.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:21/

12.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:21/

13.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:21/

14.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:21/

15.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:21/

16.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:22/

17.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:22/

18.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль; /15:22/

19.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:22/

20.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:22/

21.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:23/

22.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:23/

23.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:23/

24.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:23/

25.“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоол; /15:23/

26.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /15:23/

27.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:24/

***Дагалдан гарсан:***

28.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:24/

29.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:24/

30.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /15:24/



31.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /15:24/

32.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол; /15:25/

33.“Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /15:25/

34.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /15:25/

35.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль./15:25/

Улсын Их Хурлын гишүүдээс хууль, тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хууль, тогтоолуудын эцсийн найруулгатай танилцлаа.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын 9, 13 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын урилгаар Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн Волейболын ангийн багш, сурагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн урилгаар Хан-Уул дүүргийн 6, 7 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 38 минут үргэлжилж, 72 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 73.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 25 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 15 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Өглөөний амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Ирц бүрдсэн байна.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх 8 асуудал байна.

1 дүгээрт, “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилээр зориулсан Хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан хамрах хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

2-т “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл үргэлжлүүлж хэлэлцэнэ.

3 дугаарт ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

4 дүгээрт “Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тов зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

5 дугаарт, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Монгол Улсын ерөнхий сайдад хандан гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар тавьсан асуулгын хариуг сонсгоно. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Сая хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах үндэслэл бүхий саналаа Норовын Алтанхуяг гишүүн ирүүлсэн байна. 3 цаг 42 минут. Ингээд Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

**Н.Алтанхуяг:** Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Өнөөдөр өдөр шөнө тэнцдэг өдөр биш. Өнөөдөр хамгийн урт шөнө.

1 дүгээрт өчигдөр та хэд маань ярьж ярьж байгаад сонгуулийнхаа тойргийг баталчих шиг боллоо. Томсгосон байдалтай. Томсгож байгаа нь бүс нутгаа ч бодож байна уу, ялахаа ч бодож байна уу би мэдэхгүй. Нарийн нандин ухаанаар л хийсэн байх. Би тэр тухай ярихгүй ээ. Би 3 зүйл энэ сонгуультай холбоотой асуудал хэлье гэсэн юм.

1 дүгээрт нь сонгуулийг ямар ч юмаар явдаг байсан шударга явуулмаар байна. Хар машинаар тоолмооргүй байна. Тэгэхдээ техник хэрэгсэл ашигламаар байна. Тэр нь камер ашиглаад тэр гадна талд нь байж байгаа хүмүүс ч гэсэн давхар тоолохоор нэг ийм хониоортой юм хийчхэж болохгүй юм уу. Энэ намууд нийлж байгаад. Хэрэгтэй, хэрэггүй юман дээр намын дарга нар гарч зогсоод байх юм. Энэ улс орноо жаахан шударга явуулаад

ядаж энэ сонгуулиа нэг шударга явуулдаг дээр намууд нэгдчихэж болохгүй юм уу. *Маш тодорхой санал би хэлж байна.*

2 дахь нь мөнгө. та нарын мөнгө энэ томсгосон тойрог дээр нийлбэл яг хүчээ нэгтгэнэ дээ. Дийлдэхгүй дээ. Тийм учраас би 200 хүн хүртэл нэг ухуулагчид цалинжуулж ажиллуулдаг энийг хасаад өгөөч. Та нар маань бас энэ дээр нэг яриад хасаач. Энэ бол маш их мөнгө гардаг байхгүй юу. Ерөнхийлөгчийн сонгуульд 200 хүртэл сонгогчид 1 ухуулагч ажиллуулахаар 1 сая доллар гардаг байхгүй юу. 1 сая 200 мянган хүн санал өгнө гэвэл. Тэгэхээр энийг хасаад өгөөч ээ. Би тодорхой санал хэлж байна. юм жаахан шударга болгомоор байна. Тэгээд мөнгөтэй хүний эсрэг мөнгөгүй хүн, 65-ын эсрэг 10 хүн үзнэ энэ тэр бол тэнцвэргүй тулалдаан байхгүй юу. Нүүрсний мөнгө та нар нуучаад байгаа болохоос биш. Тэгээд сурталчилгааны материал хэвлүүлэхээсээ эхлүүлээд хязгаарлалт тавьчихмаар байна. Сумын төв дээр нэг самбар босгоод тэр хэдэн хүнийхээ зургийг тавьчихъя болоо. яах юм бэ. Энэ сонгуулиар чинь зардал гаргахаар гарч ирээд л хусдаг л энэ систем чинь яваад байна шүү дээ. Та нар эсэргүүцэхгүй тайван сонс.

3 дугаарт нь яагаад би ийм юм яриад байгаа вэ гэхээр би 1996 онд анх удаа Их Хуралд нэр дэвшиж байсан. Ийм их мөнгө гаргаж байгаагүй. Тэгэхээр энэ залууст боломж олгомоор байна. Би 1996 онд залуу, залуувтар байж. Тэгэхээр энэ залуучууддаа боломж олгоё л доо. ингээд л түрүүлж гарч ирээд л, атамандаад л, тэгээд төрөөс баахан мөнгө хусаад л, нүүрс, алт зэсээ хүртэл идээд л. Тэгээд үүгээрээ тойргоо томсгож аваад үзнэ гэвэл буруу.

Төгсгөлд нь нэг юм хэлчихье. Энэ Монголын нийгэмд үг хэлдэг хүмүүсийг ингээж хавчиж, шахаж, шоронжуулж дээрэлхдэгээ болимоор байгаа юм. Би тодорхой жишигээг хэлэх гэж байна. Би 1990 онд гарч ирэхдээ энэ их олон эрх

чөлөө дотроос үг хэлэх эрх чөлөөний төлөө үхэн үхтлээ тэмцэнэ гэж гарч ирсэн. Өнөөдөр тэгээд яаж байгаа юм. Монголын нийгэмд ялзарчихсан байгаа юмыг чинь ялзарсан гээд хэлэхээр нь аваачаад шоронд хийдэг болж байна. Тэр Мөнх-Эрдэнийг гаргаач. Магадлангийн хугацаа нь болчихсон юм байна лээ. Та нар шоронд хүнийг яаж яргалдгийг мэдэхгүй. Би олон хүнээ шоронд хийлгэсэн учраас мэдэж байна. Магадлангийн хугацаа болохынхоо өмнө нэг шалтаг олж байгаад, нэг зөрчил илрүүлчхээд магадлангаар орох боломжгүй байна. Чи ийм ийм зөрчил гаргасан. Шоронд байгаа хүний зөрчил гэж юу байдаг юм. Шоронд байгаа хүнийг чинь зөрчил гаргасан болгодог байхгүй юу. Тийм учраас энийг та нар анхаараад өг л дөө. Та нар 65-уулаа байгаа шүү дээ. Битгий ингээж шударга юм хэлсэн хүнийг шоронд хийдгээ больчих. Тэр Өнөрцэцэгийг гаргаач дээ. Яаж байгаа юм дээ эмэгтэй хүнийг, сэтгүүлчийг. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг яаж шоронд хийж байгаа юм. Өнөөдөр та нар хэдэн хүн шоронд хийгээрэй. Маргааш өөрсдөө бүгдээрээ шоронд орно. Потенциалын гэмт хэрэгтнүүд байгаа шүү дээ. Нүүрсээр чинь аваад үзэх юм бол.

Би та нарт 2 үг хэлж өгье. Сталины үед гаргасан үг байдаг юм. Хүн нь байвал хэрэг нь олдоно. Тэр мууг шоронд хий. Яаж. Үгүй ээ, яаж ч хамаагүй. Чи ямар нэгэн юм ол угаасаа хүнд юм байхгүй ч гэсэн гаргадаг байхгүй юу. Би өөрөө 5, 6 жил ээрэгдэж авлигалтай тэмцэхэд шалгагдаж явсны хувьд мэдэж байна. Ямар ч байхгүй юмыг л юм болгодог л байхгүй юу. Тийм учраас та нар энийгээ анхаараад өг. Хүн байвал хэрэг нь олдож байна. Ямар ч хэрэг тохдог. Энийг бол боль. Үгэнд ор, үгэнд орохгүй бол шоронд ор. Хэн нэг амьтны үгэнд орохгүй бол шоронд ордог ийм нийгмийн төлөө би лав яваагүй шүү. Ингээж хүмүүсийг хэлмэгдүүлэхээ боль. Би энэ эрх чөлөөтэй Монгол улсад дураараа үгээ хэлдэг тийм нийгэмд

амьдармаар байна. Бид нарын үр хүүхэд энэ залуучууд бас тийм нийгэмд амьдармаар байна. Энийг дэмжээд өгөөрэй манай хүчээ нэгтгэсэн нөхдүүд. харин томсгосон тойрог дээр хүчээ нэгтгээд, мөнгөө нэгтгээд тэгээд шударга бус юм хийв. Би үнэхээр тэрэнд их.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшиний урилгаар Дорноговь аймгийн Сайншианд сумын 13 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Манай Норовын Алтанхуяг гишүүн зарим талаар их зүйтэй юм ярьж байна. Гэхдээ энэ хулгай луйвар нэг өдөр бий болоогүй ээ. 30 жилийн энэ бугшсан хулгай, луйвар, баялгийн хулгайг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, энэ Улсын Их Хурлын реформын үр дүнд энэ нээлттэй сонсгол нийгмийн шаардлагаар илрүүлж тэмцэж байгаа. 30 жил бугшчихсан, хав дарагдсан, хадлагдсан бүх хэргүүд ил тод болж байгаа. Хулгай нэг өдөр бий болчихоогүй. Ийм учраас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө л үр дүнтэй хэрэгжүүлж, сонсгол энэ тэрээ үр дүнтэй зохион байгуулахад бид анхаарах ёстой гэдгийг хэлээд, хэлэлцэх асуудалдаа оръё.

**“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.**

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт

асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Туваан гишүүн суудалдаа суу. Санал хураалт 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд хүний эрх, үг хэлэх эрх чөлөө ярьж ярьчаад энэ эрүүдэн шүүхийн эсрэг, хүний эрх, эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх чөлөөг хангах тухай тогтоол батлагдаж байхад гараад явчих юм. Зарим нэг гишүүд. Ам ажлын зөрөө гэж л энэ байгаа юм. эрүүдэн шүүх механизмыг тусдаа болгоно. Энэ бас их чухал тогтоол батлагдаж байгаа шүү.

10.24 цаг.

**Дараагийн асуудалд оръё.**  
**“Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.**

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. санал хураалт явуулна. 5 дахь өдрийн өглөө ингээд санал хураагаад, бусад хэлэлцүүлгийг бол өмнө нь явуулчихдаг ийм шинэ дэг бас хийж байгаа шүү.

Байнгын хорооны саналаар “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал



хураалт явуулна. Санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.25 цаг.

**Дараагийн асуудалд орно. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Нэн яаралтай горимоор Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Ажлын хэсгийг оруулъя.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан танилцуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд, Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

**С.Амарсайхан:** Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолоор Тавантолгойн нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, “Эрдэнэс Тавантолгой” компанийг байгуулж, тус компанийн хувьцааны 20%-ийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн билээ. Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт хувьцааны 18,4%-ийг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн 2,5 сая иргэн эзэмшиж байна.

Тус компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Засгийн газар өнгөрсөн оны 10 дугаар сард “Эрдэнэс Тавантолгой” компанид онцгой дэглэм тогтоож, компанийн үндсэн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, төлбөр тооцоог сайжруулж, орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан. Улмаар онцгой дэглэм тогтоосноос хойш компанийн санхүүгийн үзүүлэлт, орлого

эрс сайжирч, өр төлбөрийн хэмжээ үнэмлэхүй хэмжээгээр буураад байна.

Улсын Их Хурлын 2023 оны 8 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж танилцуулах, 2021, 2022 онуудад 1072 хувьцааг ноогдол ашгаа авч чадаагүй иргэдэд хувьцааны ноогдол ашгийг нөхөн олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэхийг Засгийн газарт даалгасан.

Иймд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Тогтоолын төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 34%-ийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд шинээр эзэмшүүлэхээр, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд компанийн хувьцааг эзэмшүүлж байхаар, өмнө нь компанийн хувьцааг эзэмшиж байгаад зарим хэсгийг эсхүл бүхэлд нь худалдсан, суутган тооцуулсан Монгол Улсын иргэд хүсэлт гаргасан тохиолдолд нэрлэсэн үнээр буюу 933 төгрөгөөр буцаан худалдан авах боломжийг олгох, иргэн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдаж байх зэрэг асуудлыг тус тус тусгасан.

Тогтоолын төслийн дагуу 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төрсөн иргэдэд компанийн хувьцааг шинээр эзэмшүүлснээр компанийн нийт

хувьцааны 27,6%-ийг Монгол Улсын иргэнд эзэмшүүлэх урьдчилсан тооцоолол гарч байна. Цаашид компанийн нийт хувьцааны 34 хувьд багтаан 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр төрсөн Монгол Улсын иргэн бүрд хувьцааг эзэмшүүлж байхаар төлөвлөсөн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах, үр өгөөжийг иргэддээ хүртээх зарчмыг шинэчлэн тодорхойлж, байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэж хуульчилсан.

Иймд “Эрдэнэс Тавантолгой” компанийн 34%-ийг Монгол Улсын иргэн бүрд үе шаттай эзэмшүүлснээр байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэн бүрд тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбатын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын спортын сургуулийн волейболын ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт тамирчин сурагч, хүүхдүүддээ сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Ирээдүйд Монголынхоо нэрийг дурсгасан их сайн тамирчид болцгоогоорой.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Асуулт асууж,

үг хэлэх. Асуулт, үг хамт явж байгаа. Ингээд тасаллаа. Баттөмөр гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ургамлын Бямбасүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Баттулгын Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Жаргалсайханы Мөнх-Оргил, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Эрдэнийн Түвшинжаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Балжиннямын Гэрлээ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Галбадрахын Гантулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт Дамбын Нямдэлгэр. Ажлын хэсгийг танилцууллаа.

хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулсан. төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна.

**Д.Өнөрболор:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо

2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн байгалийн баялгийн үр өгөөжийг иргэн бүрд тэгш хүртээх боломжийг олгох зорилгоор 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн болон Монгол Улсын харьяат болсон иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх, мөн түүнчлэн иргэн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдаж байх, тус компанийн хувьцааны 1072 хувьцааг эзэмшиж байгаад хувьцаагаа худалдсан, суутган тооцуулсан иргэд хүсэлт гаргаж, хувьцаагаа буцаан худалдан авч болох асуудлыг шийдвэрлэх замаар тус компанийн нийт хувьцааны 34%-ийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан агуулга бүхий Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүлсэн байна.

Тогтоолын төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр баялгийн менежментийг зөв хийж, тус компанийн үйл ажиллагааг нээлттэй болгон иргэдийн хяналтад оруулах талаар, энэ тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдийн өргөн мэдүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны 40%-ийг иргэдэд эзэмшүүлэх тогтоолын төсөлтэй нэгтгэн хэлэлцэх боломжтой эсэх талаар, 2013 оны хувьцааны болон өнөөдрийн хувьцааны үнэ цэн өөр байгаа тул компанийн үнэлгээ хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн хэдэн хүүхэд байгаа, бүх иргэнд хувьцаа

эзэмшүүлэхэд нийт хувьцааны хэдэн хувь болох талаар, цаашид Хөтлийн цемент шохойн болон Дарханы төмөрлөгийн үйлдвэр Тавантолгой ХК гэх мэт төрийн өмчит компаниудыг олон нийтийн компани болгох чиглэлээр ямар бодлого баримталж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал иргэд компанийн хувьцааны 34%-аар дамжуулан хяналт тавих боломжгүй тул хувьцааг 49% болгох, компанийн үйл ажиллагааны талаар иргэдэд бодит мэдээлэл өгдөг байх, Улсын Их Хурлын гишүүн Адышаагаас өргөн мэдүүлсэн Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй хамтатган хэлэлцэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр цаашид баялгийн менежмент, нүүрс тээвэрлэлт, компанийн засаглалыг сайжруулах асуудлуудыг зөв оновчтой хийх, Иргэдийн ашиг орлогыг нэмэгдүүлж, ядуурлаас гаргах, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлогоор шаардлагагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, хувьцааг иргэдэд эзэмшүүлэх замаар тэдний хяналтад оруула, 2020-2023 онуудын хувьцааны ашигийг тараах, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани өнгөрсөн онуудад ашигтай ажилласан тул иргэдэд ноогдол ашиг тараах, компанийн засаглалыг сайжруулах ажлын хүрээнд иргэдийг хувьцааны 34 хувиараа дамжуулж, ТУЗ-д оролцуулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг уг тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулах, ажлын хэсэг дээр компанийн засаглалын талаар хувьцаа эзэмшигч нь хувьцааны ашиг тараах эсхэд санал өгч оролцдог байх, хувьцаа эзэмшигч нь нас барсан тохиолдолд хувьцааг төр авдаг байх



зохицуулалтыг Иргэний хууль болон Компанийн тухай хуулийн зохицуулалттай нийцүүлэх зэрэг саналууд хэллээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** гишүүд асуултаа асууна. Дамдинням гишүүн асуухгүй гэж байна. Хасчих. Дамдинням гишүүнийг хасчих. Дэгээрээ явж байна. Байнгын хорооны дүгнэлт санал, дүгнэлттэй холбогдуулж асууж асуух хүн л нэмэгдэнэ. Сандагийн Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Энэ маш чухал асуудал орж ирж байгаа юм. 2020-2024 оны Загийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үндсэн хуулийн нэг чухал заалт амилах гэж байгаа юм.

Монгол Улсын үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн

баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж Үндсэн хуульд бид нар 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Маш чухал ерөөсөө олон жил байгалийн баялагтай холбоотой үр өгөөж хүртэхтэй холбоотой хэл ам дагуулсан асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар ингэж цэгцэлсэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 3.2.9-д Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уур уурхайгаас олох үр шимийг баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ хэмээн заасан байж байгаа.

Тийм болохоор бидэнд цаашдаа нэг хийх ёстой юм бол Баялгийн сангийн хууль байж байгаа. Баялгийн сангаасаа өнөөдөр ирэгддээ тэгш шударга хүртээх, ирээдүй хойч үедээ өвлүүлж үлдээх мөн бас шаардлагатай тохиолдолд Монгол Улсын эдийн засгийн томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ийм бас зориулалтаар зарцуулах ёстой. Тийм болохоор Баялгийн сангийн хуулийг бас хэзээ оруулж ирэх бол энэ дээр манай “Эрдэнэс Монгол” компани ажиллаж байгаа байх. Өөр бас ажиллаж байгаа ажлын хэсгийнхэн хариулж өгөөч. Энийг дагаад бид энд Улсын Их Хурлын тогтоолыг дагаад Баялгийн сангийн хуулиар оруулж ирэх ёстой энэ хэзээ орж ирэх бол. 1 дүгээрт нь асуух асуулт.

2 дугаарт нь энэ тогтоол батлагдсанаараа 2012 оноос хойш төрсөн хүүхдүүд “Эрдэнэс Тавантолгой” хувьцааг эзэмшдэг болох гэж байгаа. Энэ

маш том боломж. Мөн бас урьд нь хувьцаагаа зарчихсан иргэд маань хувьцаа буцаагаад тодорхой хувиар худалдаад авах, нэрлэсэн үнээр худалдаж авах боломж бий болох гэж байгаа. Энэ бол иргэдийн тавьдаг хүсэлт. Энийг Засгийн газар шийдэх гэж байгаа.

Дараагийн нэг чухал асуудал бол хувьцааны ноогдол ашиг авдаг болох гэж байгаа. “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааны ноогдол ашиг. Ноогдол ашигт ер нь хэдий хэр мөнгө иргэддээ хуваарилах вэ. 1 хүнд хэдэн төгрөг ноогдох вэ энэ талаар бас иргэдэд тодорхой мэдээлэл өгөөч ээ.

Мөн бас иргэд зарим хэсэг нь мэдээж ноогдол ашгаа аваад, өдөр тутмын ажил амьдралаа залгуулах, талх, махаа авахад зарцуулах байх. Нэг хэсэг нь бол ЭМД-ынхаа шимтгэл шимтгэлийг төлчихье. Нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлчихье, хүүхдийнхээ сургалтын төлбөрт нь суутгуулчихъя гэдэг хүсэлтэй сонирхолтой хүмүүс гарах байх. Нэг хэсэг нь бол бас хадгалуулья. Энийг хадгалуулж байгаад хүүхдээ насанд хүрэхээр нь үр хүүхдэдээ ноогдол ашгийг нь томоохон ажил амьдралынх нь орон сууц, байр байшин, асуудал шийдэхэд нь тэр болтол хадгалъя гэсэн ийм хүсэлтүүд гарах байх. Энэ бүхэн дээр бол уян хатан байдаг баймаар байгаа юм. Энэ тал дээр бас бид цаашид яах ёстой вэ. Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Яагаад гэвэл өнөөдөр аль болох хуримтлалын санд хадгалуулаад, ноогдол ашгаа авахгүй, тэр нь хуримтлагдаад бас тодорхой хүүгээр өсөж, үржиж, арвижаад тэгж байгаад нэн тулгамдсан амьдралынхаа өмнө тулгамдсан томоохон асуудлуудаа сургалтын төлбөр төлөх, машин тэрэг, орон сууц, байр авах, ипотекийн зээлийн төлбөр суутгуулах гэх мэтийн ийм асуудал зарцуулчихвал бол их зөв байгаа юм л даа. Тэгэхгүй бол өнөөдөр аваад л идчихдэг, маргааш аваад л хэрэглэчихдэг, тэгээд л жил болгон ноогдол ашгаа хараад, шууд

үрчихдэг байлмааргүй байгаа юм. Тэгэхээр энэ дээр л хэдүүлээ тэр иргэдийнхээ хувьцааны ноогдол ашгийг хуримтлуулаад, хадгалаад өсгөж үржүүлж, арвижуулаад тулгамдсан томоохон асуудлаа ЭМД-аа төлөх, НДШ-ээ төлөх, ипотекийн зээл.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 80. Санжаагийн Наранцогт. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал.

**С.Наранцогт:** Бямбацогт гишүүний асуултад хариулья. Баялгийн сангийн хуулийг хэзээ оруулж ирэх вэ гээд Баялгийн сангийн хуулийн төсөл эцэслэгдэж байгаа. Ер нь бол эцэслэгдсэн. Энийг Засгийн газраас бас ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсгийн ахлагчаар би ажиллаж байгаа. Тэгээд холбогдох төрийн яамд, байгууллагууд, хуульчид, бас гаднын экспертүүд орсон ийм ажлын хэсэг ажиллаад Баялгийн сангийн хуулийн төслийг бэлэн болгосон. Ерөнхий сайдад бас танилцуулсан. Ойрын хугацаанд кабинетын түвшинд энэ энэ хуулийн концепт дээр санал нэгдээд ингээд Засгийн газрын хурлаар хэлэлцээд ингээд өргөн барина гэсэн ийм хүлээлттэй байна. Энэ хуулийн концептод таны сүүлийн асуулт болох энэ газрын баялгаас, эрдэс баялгаас, нийт ард иргэдэд одоо ба ирээдүйн иргэдэд тэгш шударга хуваарилах энэ концепт яг Үндсэн хуулийн 6.2-т орсон энэ агуулгаар илүү ч үгүй, утуу ч үгүй орж байгаа юм. Гэхдээ бас энэ хуримтлалыг аль болох бэлэн мөнгө тараахгүй байх, хуримтлалыг дэмжих, хуримтлалын сангаар дамжуулж хүний үндсэн хэрэгцээ болох боловсрол, эрүүл мэнд, орон сууц авах. Хэрэв зараагүй тохиолдолд бас энэ хуримтлал нь өөрөө бас өсөж үржих ийм боломжийг хангах чиглэлээр хуулийн төсөл бол боловсруулагдсан.

Ноогдол ашгийн хувьд бол ноогдол ашгийг тараах тухай Компанийн тухай хуульд их тодорхой заасан байдаг. Тэр

компанийн тухай хуульд заасан хууль, тогтоомжийнхоо хүрээнд компанийн ТУЗ оны эцсийн аудитын тайлан баланс гарсны дараа ноогдол ашиг хуваарилах хэдэн төгрөг хуваарилах гэдэг асуудлыг бол шийднэ. Ингээж ойлгож байгаа. Сүүлийн хуримтлал дээр бол би танд хэлсэн Баялгийн сангийн хууль дээр явж байгаа. Яг энэ “Эрдэнэс Тавантолгой” энэ тогтоолын хүрээнд бол гол нь энэ оны Их Хурлын 8 дугаар тогтоол дээр энэ 2012 оноос хойш төрсөн хүмүүсийг болоод энэ сайн хувьцаагаар хувьцаагаа зарчихсан хүмүүс бас буцаж хувьцаа авах хүсэлт гаргаж байгаа энэ хүмүүсийн хувьцааг буцаж олгох гол агуулгаар энэ орж ирж байгаа юм.

**Г.Занданшатар:** Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ.

**Х.Баделхан:** Баярлалаа. Тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Ер нь “Эрдэнэс Тавантолгой” ажил бол сүүлийн үед их сайжирч байгаа. Ашиг орлого нь нэмэгдэж байгаа, үйл ажиллагаа нь ил тод болж байгаа. Энэ бол сайн хэрэг. Иргэдэд хувцсаа өгөх нь бол 2 талын ашигтай.

1 дүгээрт иргэд байгалийн баялгаасаа хишиг хүртэж байгаа.

2 дахь нь тухайн компанийн үйл ажиллагаанд оролцож хяналт тавих ёстой. Нэг ёсондоо ТУЗ-өөр удирдлагад оролцоод хяналт тавих ёстой. Тэгэхээр өнөөдрийн байдлаар яах вэ 27 хүртэл хувийг иргэдэд эзэмшүүлж байгаа юм байна л даа. Хувьцаа олгож байгаа юм байна. Тэгэхээр тэр хэмжээгээрээ бол иргэдийн төлөөлөл ТУЗ-д суух ёстой. Тэгэхээр өнөөдрийн байдлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөл, хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн төлөөлөл хэдэн хүн байна гэсэн 1 дүгээр асуулт.

2 дахь нь энэ яг өнөөгийн нөхцөл бол эндээс “Эрдэнэс Тавантолгой” хишиг хүртье, ноогдол ашгаа авъя гэсэн иргэд бол байнга ярьж байгаа, байнга

шаардаж байгаа. Тэгэхээр энэ ноогдол ашгаа яг хэзээ олгох юм бэ. Хэзээ олгох бодолтой байна.

3 дахь нь 2016 оны сонгуулийн өмнө Сайханбилиг Ерөнхий сайд бас нэг хувьцаа тарааж байсан шүү дээ. Хувьцаа олголоо. Хувьцааг мөнгөөр тараасан байсан. Одоо энэ тараасан хувьцаа бол иргэдийн нэр дээр хувьцаа хэвээрээ байна уу эсвэл хувьцаагаа зарчихсан тэр иргэд хувьцаагүй байна уу, энийг ер нь цаашидаа яах бодолтой байна гэсэн 3 асуулт байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ. Сайнбуянгийн Амарсайхан Шадар сайд хариулъя.

**С.Амарсайхан:** Нүүрсний экспорт тээвэрлэлттэй холбоотой ерөнхий сонсголын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлаас зарим авах арга хэмжээг Засгийн газарт даалгасан. Энэ 1 дүгээрт 2012 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш төрсөн иргэдэд Тавантолгойн хувьцааг эзэмшүүлэх асуудлыг 1 дүгээрт судалж танилцуулах,

2 дугаарт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд 2021, 2022 онд иргэдэд ноогдол ашиг хуваарилагдаагүй байгаа, авч чадаагүй байгаа иргэдэд хуваарилах асуудлыг судалж танилцуулах,

3 дугаарт 1072 хувьцаатай холбоотой нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг Улсын Их Хуралд танилцуулах гэсэн ийм 3 чиглэлийн үүрэг даалгаврыг өгсний хүрээнд өнөөдөр энэ 2021, 2022 онд ноогдол ашгаа аваагүй байгаа иргэдийн ноогдол ашгийг хуваарилах тухай асуудлыг судалж бас энэ чиглэлийн арга хэмжээнүүдийг Засгийн газар авахаар бэлтгэл ажлаа хангаж байгаа.

2 дугаарт нь 2012 оноос хойш төрсөн иргэд мөн 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш төрсөн иргэдэд хувьцаа

эзэмшүүлэх асуудлыг өөрөөр хэлэх юм бол өнөөдөр 2012 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө төрсөн нийт 2,5 сая иргэн Тавантолгой ХК-ийн хувьцааг эзэмшиж байна. Гэтэл өнөөдөр Монгол Улсын хүн амын 3,5 сая хүн ам буюу 1 орчим сая хүн хувьцаа эзэмшээгүй байгаа юм. Тэгэхээр эдгээр иргэдэд болон цаашид шинээр төрөх иргэдэд хувьцааг байнга эзэмшүүлэх буюу нийт энэ компанийн 34%-ийг ижил тэнцүү хэмжээгээр Монгол Улсын иргэдэд ирээдүйд эзэмшүүлж явах тухай асуудлыг ингэж оруулж шийдвэрлэж байгаа. Тэгэхээр энэ хувьцааны ноогдол ашгийн асуудал бол 2023 ондоо үндсэндээ бэлтгэл ажил нь хангагдаад 2024 ондоо шийдэгдэж олгогдоно гэж ойлгох хэрэгтэй.

2 дугаарт “Тавантолгой” ХК-ийн нийт 34%-ийг цаашид Монгол Улсын иргэн бүр Монгол Улсын харьяат хүн бүр эзэмших боломж нөхцөлийг олоход чиглэж энэ тогтоол орж ирж байгаа.

3 дугаарт түрүүн Бямбацогт сайдын ярьсан тэр Үндэсний баялгийн сангийн тухай хууль бас удаан хугацаанд судлагдаж, хуулийн төсөл бэлтгэгдсэн. Тогтворжуулалтын хууль тэгээд Ирээдүйн өв сан зэрэг энэ сангуудаас бүрдсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг удахгүй Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** “Эрдэнэс Тавантолгой” 34%-ийг ард иргэддээ өгье гэж. Ер нь энэ компанийн явсан түүхийг хэдүүлээ маш сайн нягталж байж энэ асуудлаа ярихгүй бол үнэхээр Монголын ард түмэнд чихэр долоолгосоор байгаад өнөөдрийг хүрчихсэн. 1072 хувьцаат иргэд маань энэ компанийн асуудалд оролцдоггүй. Энэ компани Монголын ард түмэнд төрийн өмч дээр ямар хулгай байдгийг үлгэр жишээ харуулсан. Тэнд яаж нууцаар гэрээ байгуулж болдгийг харуулсан, яаж түүнийг тойрсон

тээврийн хулгай байдгийг харуулсан. Өнөөдөр энэ нүүрсний сонсголын хамгийн цөм нь бол “Эрдэнэс Тавантолгой” байх ёстой л доо. Төрийн өмчийн энэ луйвар хулгайн асуудал. Тэгээд харамсалтай нь сонсгол маань бас арай өөр тийшээ л яваад байх шиг байгаа юм. Хэдүүлээ яг бодит үнэнийг ард иргэддээ хэлэх ёстой. Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” нийтдээ яг хэдэн их наядын оффтейк гэрээ байгуулчихсан юм бэ. Энийг би асуучихъя. Энэ оффтейк гэрээнүүд нь хэдээс хэдэн онд хийгдсэн юм бэ. 2020-2024 онд хэдэн оффтейк гэрээ хийгдсэн юм. Өнөөдрийн Засгийн газар бас хийсэн юм уу, үгүй юм уу. Энэ дээр нийт хэдэн төгрөгийн үнийн дүнтэй юм бэ та бүхэн бас тодорхой хэлээд өгөөрэй. Энэ компани өнөөдрийн байдлаар хэдэн төгрөгийн өртэй юм бэ. Ирээдүйд төлөх мөнгө нь хэд юм бэ. Энэ болгоноо хэдүүлээ эхлээд тодорхой болгоё. Өнөөдөр Монголын ард түмэн бас ухаантай. Баахан хувьцаа авах гэж байна гээд баярлаад байдаг цаана нь баахан өр аваад үлдчих вий дээ. Энийгээ хэдүүлээ бас ярилцъя. Ер нь 34%-аар бол засаглалыг нь хянаж болно гээд уг нь ярьдаг л даа. Тэгэхдээ өнөөдрийн “Эрдэнэс Тавантолгой” шиг төрийн өмч давамгайлсан энэ компани дээр бол 34% ард түмэнд хангалтгүй байгаа юм. Хамгийн багадаа 49%-аараа хянамаар байна. Одоо байгаа 1072 хувьцаа эзэмшигч нарыг төлөөлөөд ТУЗ-д ер нь ямар хүмүүс суудаг юм. Тэд нар ямар шийдвэр гаргаж байсан юм. Энийг бас сонсчихъё. Энэ шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлж байсан юм. Энийг бас сонсчихъё. Ингэж байж бид нар өнөөдрийнхөө энэ ярих юмнуудаа ярья. Тэгээд одоо та хэд маань бас энэ жил бараг ашигтай гарсан тухай юм ярих гээд л байх шиг байх юм. Тэрийг чинь бас сонсчихъё. Үнэхээр ашигтай гарах гээд байгаа юм уу энэ компани.

2-т нь хэрвээ ямар нэгэн улс төрийн шоу болох гэж байгаа бол энийг ард иргэд хүсэхгүй байгаа шүү. Сонгууль болгоны өмнө нэг ингээд “Эрдэнэс



Тавантолгой” гээд Монголын ард түмний энэ стратегийн ордыг сонгуулийн нэг шоуны хэсэг болгоод ард түмнээ хуурдаг энэ байдлаас гаръя. Ард иргэд юу хүсэж байна вэ гэхээрээ энэ хувьцаа нь баталгаажсаад, мөнгөжөөд ингээд жил болгон ноогдол ашгаа авдаг ийм л хувьцааг хүсэж байгаа. Тэрнээс нэг удаагийн олгодог, нэг удаа иргэдийнхээ мэдээлэл дутуу дээр иргэдийнхээ санхүүгийн боломж дутуу дээр нь хэдэн төгрөг тараагаад санал худалдаж авдаг ийм компани болгомооргүй байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань миний түрүүний асуусан асуултуудад нэг тодорхой хариулт авмаар байна 1 дүгээрт.

2-т нь тэр иргэддээ буцаагаад хувьцааг нь буцаан олгох талаар бас оруулж ирсэн байна л даа. Тогтоолын юун дээр. Энэ дээр өмнө нь бас АН-ын бүлгийн гишүүн Адьяа гишүүн бас энэ асуудлыг оруулж ирсэн юм. Тэрийг бас хамтатгаад ингээд явбал Адьяа гишүүнийх илүү бас бодитой байх шиг байна лээ шүү дээ. Тэгэхээр энийг бас та бүхэн эргэж хараарай. Тэгээд эхлээд асуултдаа нэг хариултууд аваадахъя.

**Г.Занданшатар:** 82. Жигжидийн Ганбат.

**Ж.Ганбат:** Ганибал гишүүний асуултад хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” Компани дээр оффтейк гэрээ өмнө нь бол байгуулагдсан гэрээнүүд бол Тавантолгой Гашуунсухайт төмөр замтай холбоотой 27 гэрээ байсан. Богд хаан төмөр замтай холбоотой 9 гэрээ, Нүүрс баяжуулах үйлдвэртэй холбоотой 1 гэрээ, Газрын тосны үйлдвэртэй холбоотой буюу газрын тосны дамжуулах хоолойтой холбоотой 1 гэрээ гээд нийтдээ 4 төсөлтэй холбоотой 38 дэд гэрээ байсан. Үүнийг 2023 оны 12 сарын 1-ний байдлаар Тавантолгой Гашуунсухайт төмөр зам дээр 27 гэрээ байсныг 1 гэрээ болгож ингэж бууруулаад, одоо 1 гэрээ л байгаа. Нүүрс баяжуулах үйлдвэртэй

холбоотой 1 гэрээ, Газрын тосны дамжуулах хоолойтой холбоотой 1 гэрээ гээд нийтдээ 4 төсөлтэй холбоотой 38 дэд оффтейк гэрээ байсныг 3 гэрээ л үлдсэн. Богд хаан төмөр замтай холбоотой гэрээг бол бүрэн зогсоосон. Ийм байдалтайгаар бол байгаа. Энэ Тавантолгой Гашуунсухайт төмөр замын үлдсэн нэг гэрээнийх нь хугацаа бол 2024 оны 12 сарын 31-нд дуусна. Үүнийг бол бид аль болох ингэнэ. Шинээр ямар нэгэн оффтейк гэрээ бол “Эрдэнэс Тавантолгой” компани дээр онцгой дэглэм тогтоосноос хойшоо бол шинээр огт байгуулаагүй. Ийм байдалтай байгаа. Компанийн ашгийн санхүүгийн үзүүлэлт бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,3 их наяд төгрөгийн ашигтай ажилласан. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 2,7 их наяд төгрөгийн ашигтай ажилласан. Энэ жилийн эцсээр санхүүгийн тайлан нь ирэх оны 2 сарын 10-нд гараад, аудит ороод энэ тоо эцэслээд хэд гарахыг нь бол урьдчилж хэлэх боломжгүй байна. Өр төлбөрийн хувьд бол “Эрдэнэс Тавантолгой” компани дээр нийтдээ 4,3 их наяд төгрөгийн өр төлбөр байсан. Энийг бол 1 их наяд гаруй төгрөгөөр бууруулсан. Нөгөө талдаа энэ дотор ингээд урьдчилж мөнгийг нь авчхаад, дараа нь нүүрсийг нь ачуулдаг байсан 603 сая ам.доллар байсан. Үүнийг сая энэ 2023 оны 9 сард энэ төлбөрийг бол бүрэн төлж дуусгасан. Тэгэхээр бид нарын борлуулж байгаа нүүрс бол төлбөр нь 100 хувь энэ 2023 оны 9 сараас хойшоо бол мөнгөөрөө бол 100 хувь орж ирдэг болгосон.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн урилгаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн 7 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хан-Уулчууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

80. Санжаагийн Наранцогт  
гүйцэтгэх захирал.

**С.Наранцогт:** Ганибал гишүүний энэ ТУЗ-ийн удирдлагатай холбоотой асуултад хариулъя. Иргэдийн төлөөллийг бол хараат бус гишүүний ТУЗ-ийн гишүүдээр дамжуулж хэрэгжүүлж байгаа юм. Тэгэхээр өмнө нь ТУЗ-ийн хараат бус гишүүн 11 ТУЗ-ийн гишүүний 3-4 гишүүн нь төлөөлдөг байсан юм. Тэгээд 2022 оноос эхлээд энэ “Эрдэнэс Монгол” нэгдлийн хүрээний засаглалын шинэчлэлийг бид нар нэлээд хийж байгаа. Тэгээд ер нь засаглалыг сайжруулах хүрээнд энэ хараат бус гишүүд иргэдийн төлөөллийг хараат бус нэртэй хараат биш, яг жинхэнэ нийгэмд бас хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн болоод энэ компанийн засаглалын талаар туршилагатай ийм хүмүүсийг олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулсан. Нээлттэй сонгон шалгаруулаад 49%-ийг нь хараат бус гишүүн болгосон байгаа. Одоо 11 гишүүнийг 9 болгосон “Эрдэнэс Тавантолгой” -н ТУЗ-д 9 гишүүн ажиллаж байна. Тэрний 4 нь хараат бус өөрөөр хэлбэл иргэдийг төлөөлсөн олон нийтээс сонгогдон ажиллаж байгаа. Олон нийтэд нээлттэй зарлагдаад ингэж сонгогдсон 4 гишүүн, 5 нь бол төрийн төлөөлөл ингээд ажиллаж байгаа. Яг хувь хэмжээгээрээ биш. Тэгэхээр бол сайн засаглалын хувьд бол энэ нэлээдгүй сайжирч байгаа гэж ингэж үзэж болно. ТУЗ-ийн гишүүдийн эрх үүрэг ямар байдаг вэ гэхээр хараат бус гишүүд бол хараат бус иргэдийн төлөөллийг хэрэгжүүлж ажиллах бүрэн боломжтой байгаа. Гэхдээ энэ төрийн төлөөллүүд бол ер нь тодорхой яамнуудын төлөөлөл, яамдынхаа бодлого чиглэлийг хариуцах чиглэлээр ер нь байдаг. Гэхдээ нэг ийм зүйл. Компанийн тухай хуульд өөрт нь Компанийн тухай хуулийн 2.6.13-д төр болон бусад хуулийн этгээд аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхийг хэрэгжүүлэхээр дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээр томилсон төлөөлөгчөөр дамжуулан

төлөөллөө хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төлөөлөгч нь уг төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий этгээдийн өгсөн удирдамжийг үндэслэх бөгөөд энэхүү удирдамжаас өөрөөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэс болно гэсэн нэг ийм хуулийн хязгаарлалттай тийм учраас үндсэндээ бол энд ялангуяа төрийн төлөөлөл их бол энэ компанийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчийн ирсэн удирдамжийг ер нь хэрэгжүүлдэг, ийм бас хязгаарлалттай, ийм эрхтэй. Тэгэхээр ТУЗ-ийн гишүүд бас тэр болгон бие дааж хэдийгээр бас нэлээн оролцож байгаа ч гэсэн яг зарчмын асуудал дээр бас ийм хязгаарлалттай байгаа гэдгийг тодотгож хэлье.

Түүнээс гадна таны хэлж байгаагаар ер нь энэ “Эрдэнэс Тавантолгой”-н.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Сайнбуянгийн Амарсайхан сайд хариулъя. Нэмэлт асуулт байхгүй.

**С.Амарсайхан:** Ганибал гишүүн маш чухал асуулт асууж байна. “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа эзэмшигч нийт иргэд жил болгон хувьцаагаа авдаг болмоор байна. Компанийн засаглал ил тод, нээлттэй байдлыг яаж хангах юм бэ гэдэг ийм асууялт. Энэ бол яг энэ асуудлыг шийдвэрлэж тогтвортой ийм тогтолцоог хангахын тулд л өнөөдрийн энэ асуудал орж ирж байгаа юм. “Эрдэнэс Тавантолгой” компанийн засаглалыг ил тод нээлттэй, олон нийтийн шууд хяналт доор гэхдээ олон улсын жишигээр явуулдаг байх. Дээрээс нь нийт хувьцаа эзэмшигч иргэд байж байгаад 1 хувьцаа авдаг, эсвэл авахгүй байдаг ийм тогтворгүй жишигтэй явж ирсэн бол ер нь байнга хувьцаагаа авдаг байх, хувьцааныхаа ноогдол ашгийг шууд хүртдэг байх ийм боломжийг л нээхийн тулд өнөөдрийн энэ тогтоолын төсөл

орж ирж байгаа юм. Тэгээд өнөөдөр бол “Эрдэнэс Монгол” компанийн нийт 81,5%-ийг төрийн эзэмшил, 18,4%-ийг 2,5 сая иргэн эзэмшиж байгаа. 0,06%-ийг 486 орчим аж ахуйн нэгжүүд эзэмшиж байгаа юм. Тэгэхээр цаашидаа 2012 оноос хойш төрсөн, тэгээд 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш төрсөн нийт иргэн энэ 36% дотроо ижил тэнцүү хувьцаа эзэмшээд энэ хувьцааныхаа ноогдол ашгийг жил бүр хүртдэг байх. Тэр хүртсэн ноогдол ашгаа хэн өөрөө юунд зарцуулах нь иргэдийн өөрсдийнх нь эрх, үүргийн асуудал байх хэмжээнд л оруулж ирж байгаа юм. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол Тавантолгой ХК-ийн үйл ажиллагааг сайжруулснаар нийт 2023 оны 12 сарын байдлаар бол нийт улсын экспортын бараг 41,7%-ийг эзэлж байна. Өөрөөр хэлэх юм бол энэ нээлттэй, ил тод байлгаад, дээрээс нь Засгийн газар бүрэн эрхт томилж ажилласны үр дүнд санхүүгийн алдагдал буурсан, өр төлбөрийн хэмжээ буурсан, нийтдээ бараг 4,3 их наядын өртэй байсан бол өнөөдөр түүнийг барагдуулаад л 1,9 их наядад хүргэсэн. Дээрээс нь нийт экспортод 25,7 сая тонн нүүрсийг экспортолсон байгаа. Энэ хэмжээгээрээ орлого нэмэгдэж, алдагдал буурч, ашиг нэмэгдсэнээр иргэдийн ноогдол ашигаа хүртэх мөнгөний хэмжээ нэмэгдэнэ гэсэн үг.

**Г.Занданшатар:** Ганибал гишүүн тодорхой асуугаарай.

**Н.Ганибал:** Яг иргэдийн 1072-ын өмнөөс ТУЗ-д ажиллаж байгаа хүмүүс маань ямар ч мэдээлэлгүй байдаг юм биш үү. Бид нар нууц гэрээ байгуулсан, төрийн нууцад оруулаад оффтейк гэрээ байгуулсан асуудлыг чинь ард түмэн гэнэтхэн нэг л өдөр бөөнөөрөө мэдсэн биз дээ. Тийм ээ. Тэгэхээр энэ асуудлуудыг бид нар тэр хувьцаа эзэмшигчдийн төлөөлж байгаа хүмүүс юу ч мэдэхгүй байгаа байхгүй юу даа. Тийм учраас миний яриад байгаа нь 49% болго. Тэгэхгүй зүгээр өнөөдөр Засгийн газар нь нийт 70 хувь, түүнээс дээш хувь

эзэмшиж байгаа тохиолдолд бол ямар ч хамаагүй гэрээг тэр хувьцаа эзэмшигчид нь хэлэхгүйгээр хийгээд байна шүү дээ. Тийм учраас энийг 49% болго, 34 хувийг нь нийт иргэддээ өгвөл үлдсэн 15 хувийг нь аж ахуйн нэгжүүд дээ өгчих л дөө. Ингээж байж бас яг ийм хариуцлагатай хүмүүсээр энэ хяналтаа тавиулахгүй бол зүгээр Засгийн газар өөрөө төлөөлсөн хүн аваачиж тавиад ингээд л хулгай хийгээд байгаа байхгүй юу. Энийг л засъя. Ингээж байж жил болгон хувьцаа.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Асуулт биш, үг хэлчихлээ тийм үү. 49% болгоё гэж. Тэгээд ер нь энэ тогтоолын хувьд энэ Түвшинжаргал хариулах юм уу. 85. Өмчийн эрх зүй, Компанийн эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүй бүх хүрээндээ энэ их зөрчилтэй асуудал болчихоод байна л даа. Өмч гэдэг чинь захиран зарцуулах, эзэмших, ашиглах бүрэн эрхийн асуудал. Тэгтэл энэ хувьцааны эрх зүйн хувьд энэ хувьцаа эзэмших, захиран зарцуулах, тэр удирдлагын эрхэд ороод байгаа энэ компанийн засаглал энд оролцох эрх нь чөлөөтэй болоогүй байхад тэгээд ирээдүйд өмч гэдэг чинь энэ чинь хувьцаа эзэмшигчээс асуухгүйгээр дараагийн ирээдүйд төрөх хэн нэгэн иргэнд эзэмшүүлнэ гэхээр тэр хувьцааны үнэлгээ өмч гэдэг чинь өөрөө үнэлгээтэй байна гэж байгаа юм бас. Салиггүй хэсэг нь. Тэгээд тэрнээсээ ингээд хоргодно. 1072 хувьцаа нь хэд ч болох юм. Тэгэхээр энийг өмчийн эзнээс асуухгүйгээр би чиний хувьцааг бууруулчихлаа, үнэлгээг бууруулчихлаа, тоог бууруулчихлаа. Ингээд төгсгөлгүй хязгааргүй үргэлжлэх. Тэгтэл энэ Ирээдүй өв сангийн хуулийн концепц ирээдүйд төрөх иргэдэд Үндэсний баялгийн сангийн хууль, Үндэсний баялгийн сангийн концепцтой бүгд уялдаж байж энэ асуудал чинь ирэхгүй бол ингээд хэсэгчлээд тэгээд л ахиад л 2 дахь зах зээлд зарагддаггүй, ноогдол ашиг авдаг ч юм шиг, авдаггүй ч юм шиг нэг ийм сонгодог хэлбэртэй хувьцаа ч биш ч юм шиг, сонгодог хувьцаат компани мөн ч юм шиг биш ч



юм шиг ийм эрлийз байдлаа нэг мөр цэгцлэхгүйгээр ингээд ахиад л ийм үл ойлгогдох байдал үүсгээд л ингээд байх чинь ер нь эдийн засгийн агуулгаараа ч тэр эрх зүйн агуулгаараа ч гэсэн тэр болж байгаа юм уу. Хуульч хүний хувьд Түвшинжаргал юу гэж бодож байна. Компанийн эрх зүй байна. Энгийн болон давуу эрхт хувьцааны ойлголт байна. 85.

**Э.Түвшинжаргал:** Их хурлын даргын асуултад хариулъя. Ер нь бол яах вэ, энэ тогтоолын төслийг боловсруулахад ажлын хэсэг дээр энэ асуудлыг бол нэлээн сайн ярилцсан. Тэгээд ер нь бол Баялгийн сангийн хуультайгаа бас нийцүүлж шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалтай бас хамтатгаад боловсруулах шатад бол нэлээн яригдаж байгаа. Энэ зохицуулалттай холбоотойгоор хууль, хуулийн өөрчлөлтүүдийг бас хамтатгаж өргөн барихаар боловсруулагдаад бол явж байгаа.

**Г.Занданшатар:** Тэгээд үнэт цаасны тухай хууль энэ бусад хуультай уялдах хэрэгтэй болно. Тогтоол дагаж хууль гарна гэж байхгүй шүү дээ. Хуулиа дагуулж л тогтоол гаргадаг болохоос биш чи Их Хуралд ажиллаж байсан хүн. Түвшинжаргал аа 85. Тогтоол дагуулж Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлах гээд байгаа юм уу тэгээд. Дондогмаа 81. Үнэт цаасны хуульгүйгээр энийг яаж хэрэгжүүлэх юм энэ тогтоолыг.

**Ч.Дондогмаа:** 1072 хувьцааг анх бол иргэдэд төрөөс байгалийн баялгийн үр ашгийг хүртээх зорилгоор үнэ төлбөргүйгээр энгийн хувьцаа хэлбэрээр эзэмшүүлсэн байгаа. Тэгээд энэ бол өөрөө шилжих захиран зарцуулах эрх нь бас хязгаартай байгаа хувьцаа. Тийм учраас бол одоо энийг хувьцаа эзэмшигчийн бүртгэлээр нь шийдвэрлэе гэсэн байдлаар шаардлагатай бол ажлын хэсэг дээр ярилцаад Үнэт цаасны хуулийн бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийг хийе гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

**Г.Занданшатар:** Бүртгэлээр зохицуулдаг юм уу. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Энэ бол Үндсэн хуулийн зөрчилтэй л болох юм байна.

**О.Цогтгэрэл:** Энэ үнэхээр бас нэг ийм саяын хэлэгддэг Үндсэн хуулийн байж болох ийм олон зөрчлүүдтэй ийм зохицуулалт орж ирж байна л даа. Үндсэн хуульд заахдаа байгалийн баялгийн үр өгөөжийг дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэсэн. Үндсэн хуульд 2019 оны Үндсэн хуульд хуулиар тогтооно гэсэн. Тэгэхээр энэ чинь одоо яг ямар эрх зүйн ямар харилцаа орж ирээд байгаа юм бэ. Тогтоолын төслөөр орж ирэх нь ээ. 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ тогтоолын төслийн хамгийн эхний өгүүлбэр нь байгаа. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 34%-ийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлнэ. Хувьцааг эзэмшүүлнэ гэдэг яг ямар ойлголт байдаг юм. Эзэмших гэдэг чинь өөрөө төрөөс тодорхой цаг хугацаатай, тодорхой нөхцөлтэйгөөр буцах эрхтэйгээр байгаа тэр харилцааг эзэмших гэдэг байх. Энэ хувьцааг хэзээ нэгэн цагт буцаагаад авчих юм уу. Энэ чинь өмчлөх биш өмч биш юм уу. Өнгөрсөн хугацаанд яг л нэг хиймлээр 2011 оноос эхэлж байсан. Зүгээр л нэг чихэр долоолгодог сонгуулийн өмнө нэг данс дээр бичилт хийдэг үүнийхээ дагуу данс руу нь мөнгө хийдэг зүгээр л 10 хэдэн жилийн өмнөх Монгол төрийн энэ завхралаасаа бид нар сургамж аваагүй нэг ийм тогтоолын төсөл л орж ирж байна шүү дээ. Зүгээр л бараг хэтрүүлэн хэлэхэд залилан. Үндсэн хууль дээр хуулиар энэ харилцааг зохицуул, Баялгийн сангийн хуулиа оруулж ир гээд заачихсан байхад энд эзэмшүүлнэ. Ямарваа нэгэн бирж нээлттэй болох энэ өмч болох, арилждаг болох, өвлөдөг, залгамжилдаг болох энэ бүх харилцаа юу ч энэ тогтоол дээр нь ямар ч зүйл заалт байхгүй. Тэгээд хувьцааг эзэмшүүл. Эзэмшлийн хувьцаа гэдэг яг ямар ойлголт байдгийг энэ

хуульчид нь бас тайлбарлаж өгөөч. Энэ чинь зүгээр нэг бүртгэл юм биш үү. Юу юм энэ бүү мэд. Зүгээр нэг ийм улс төрийн шинжтэй. Удахгүй мэдэж л байна л даа хаврын чуулганаар бүгдээрээ 34% эзэмшдэг болсон, ноогдол ашиг өгнө гэнэ. Үгүй ээ, энэ чинь тэгээд яг л нөгөө 12 жилийн өмнө болсон тэр түүхийг л давчихсан, тэрнээс ямарваа нэгэн бид нар нэг сургамж аваагүй. Үнэхээр яг энэ тогтоол энэ чинь тогтоол юм байна. Уг нь тэр Баялгийн сангийн тухай хууль орж ирээд, баялгийн сан дээр чинь зөвхөн “Эрдэнэс Тавантолгой” биш төрийн өмчит болоод ашигт малтмалтай холбоотой аж ахуйн нэгжүүд эндээс олох орлогыг хэрхэн нэгтгэх юм. Дахиад дээрээс нь энд хэрхэн яаж менежмент хийх юм. Энэ чинь зүгээр нэг данс биш баялгийн сан гэдэг чинь. Жишээ нь Сангийн яам дээр аль нэг газар Монголбанканд байгаа нэг дансанд байж байгаад хуваагаад биччихдэг данс биш. Баялгийн сан гэдэг чинь менежмент хийх ёстой. Үүгээр ороод ирээдүйд тэр өрөө өвөө бид нар удирдах ёстой. Иргэдээ өгөөжөө авдаг байх ёстой. Өмчтэй болох ёстой. Энэ бүх харилцаа аль нь ч байхгүй. Тэгээд өнгөрсөн хугацаанд бид нар АН-ын хэсэг гишүүд нэгдэж Баялгийн сангийн тухай хуулийг өргөн барьсан. Одоо хууль байхгүй юм шиг яриад байна. Уг нь бол ингээд бэлээхэн хуулийн төсөл энэ бүх харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг тэр Эрдэнэтийг яах юм. Энэ бүх хуулийн нэгтгэсэн асуудлаар нь ингэж өм цөм биш бид нар хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа. Энийг хэлэлцэхгүйгээр яг ингээд бүр Үндсэн хуулийн зөрчилтэй ийм асуудлыг оруулж ирж байна. Энэ бол үнэхээр энэ үнэхээр цааш цаашид явахад хэцүү. Зөвхөн л сонгуульд бэлдсэн хаврын чуулганаар ноогдол ашиг нэртэй хэдэн төгрөг данс руу нь хийх гэж байгаа нэг ийм л харилцаа. Зүгээр л молиго. Яг үнэндээ энэ компани чинь ноогдол ашиг олох хэмжээний ч биш. Өнөөдөр түрүүн бас хэлж байна. 3 их наяд ч байна уу, 4 их наяд ч байна уу өртэй, алдагдалтай,

өртэй явж байгаа л компани шүү дээ. Юун ноогдол ашиг. Тэгээд л энэ яах вэ, одоо урьдчилсан борлуулалт гэнэ үү, оффтейк гэрээ гэнэ үү нэг юм хийж мөнгө авч зүгээр л сонгуулийн өмнө мөнгө л тараана шүү дээ. Зүгээр тэрэнд бэлдсэн л тогтоолын төсөл. Энд ямарваа нэгэн шийдэл, гарц гаргалгаа, ирээдүй рүү харсан, Үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн байгалийн баялагт менежмент хийсэн ямарваа нэгэн ийм үзэл санаагүй ийм л тогтоолын төсөл ингээд орж ирж байна. Тэрний зарим нэг асуултуудад нь хариулт өгөөч. Тэр хүнд эзэмшүүлдэг хуулиар, тогтоолоор эзэмшүүлдэг хувьцаа гэж яг ямар хувьцаа байдаг юм энэ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье. Наранцогт дарга.

**С.Наранцогт:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ энэ компанийн хувьцааг зүгээр үнэгүй тараадаг нь зарчмын хувьд бол засаглалын хувьд бол буруу зүйл. Харамсалтай нь бол 2010 оноос хойш Улсын Их Хурал, Засгийн газрын 16 тогтоол гарсан байгаа юм. Нэг үнэгүй тараагаад л, нэмээд л, буцааж худалдаж аваад л, тэгээд хамгийн сүүлд 2016 онд сайн хувьцаагаар болоод энэ буцаагаад 3 сая 500 иргэний мянга 1 сая 218 иргэн хувьцаагаа сайн хувьцаа болон бусад хэлбэрээр зарчихсан. Өөрөөр хэлбэл 1072 хувьцаагүй байгаа юм. Тэгээд энэ иргэд одоо бид нар 2 сарын 19-нд манай энд “Эрдэнэс Тавантолгой”-н ТУЗ хуралдаж хувьцаа, ноогдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргана. Гэтэл энэ иргэний хөдөлгөөн энэ 1072 хувьцаа гэсэн Төрийн бус байгууллага энэ тэр ямар асуудал тавьж явж байгаа вэ гэхээр энэ 1 сая 218 мянган иргэдийн төлөөлөл бид нарыг хулхидсан. Бид нарын хувьцааг ингэж буцааж дээрэмдэж авсан, энэ хувьцаагаа өг гэдэг асуудлыг их хүчтэй тавьж байгаа юм.

Баялгийн сангийн хуульд бол яаж байгаа вэ гэхээр төр болоод хувийн уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас одоогийн болоод ирээдүйн иргэдэд тэгш шударга хуваарилах яг концепц энэ бүх зүйл бол орчихсон явж байгаа юм. Гэтэл энэ Тавантолгойн хувьцааг 2010 оноос хойш 16 тогтоолоор ингээд янз бүр болгоод ингээд ийм зэрэмдэг болгоод хаячихсан учраас энэ Баялгийн сангийн хуулийг батлагдахаас өмнө эдний хувьцааны асуудлыг нэг мөр шийдээд, иргэд бүгд тэгш эрхтэй хувьцаатай болохоос өөр шийдэл гаргахгүй бол тэгээд цаашид Баялгийн сангийн хуулиар ер нь энэ газрын баялгийн үр ашгийг ард иргэдэд зүгээр хувьцаа үнэгүй тараах биш, яг өөр бодит байдлаар тараах энэ концепцоороо шийдээж явахгүй бол дараа дараагийн энэ компаниуддаа засаглалын хувьд бол маш их буруу ийм зүйлүүд бий болох гээд байгаа юм.

Тэгэхээр 2 сарын 19-ний өмнө бол бид ТУЗ-ийн хурал дээр ноогдол ашиг тараах шийдвэр гаргахаас өмнө “Эрдэнэс Тавантолгой” 1072 хувьцааг анх тэр баялгийн үр өгөөжийг ард иргэдэд түгээх зорилгоор л гаргасан юм шиг байгаа юм. Тэр агуулгад нь нийцүүлээд тэгш 1072 хувьцааг нь нэг мөр шийдэх байдлаар энэ тогтоолыг оруулж ирж байгаа гэж ингэж ойлгож болно. Зүгээр яг тэр хувьцаа, эзэмшлийн хувьцаа гэдэг асуудлыг Дондогмаа дарга хууль зүйн талаас нь хариулчих уу.

**Л.Мөнхбаатар:** Асуултад нэмж хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Дондогмаа дарга хариулъя.

**Ч.Дондогмаа:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Нэмэлтээр хариулъя. Улсын Их Хурлын 2023 оны 08 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолоор бол 2012 оны 4 дүгээр сарын 11-ээс хойш төрсөн иргэдэд хувьцаа эзэмшүүлэх асуудлыг оруулж ир, мөн энэ хувьцаагаа суутгасан болон худалдан авсан хүмүүст

буцаан авах боломжийг нь бүрдүүл, мөн ноогдол ашиг тараах асуудлыг шийдвэрлэ гэсэн үүрэг Засгийн газарт өгөгдсөний дагуу энэ тогтоол бас орж ирж байгаа. Хувьцаа эзэмшлийн хувьд бол 2010 оны 39 дүгээр тогтоолоор эзэмшүүлсэн. 20 хүртэлх хувийг. Эзэмшил нь бол өөрөө өмчлөлөөс ялгаатай байдал нь бол эзэмшилдээ байлгаж үр ашгийг нь хүртэх замаар энэ эзэмшилээ хэрэгжүүлэх арга зам байдаг. Өмчлөл бол захиран зарцуулах эрхтэй байдгаараа эзэмшилээс ялгаатай байдаг.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу та. Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Харин тийм ээ хариулт яг л ийм л байна л даа. Энэ чинь энэ бүх харилцаа, суурь асуудлууд, олон зүйлүүдийг энэ бүгдийг хуулиар, тэр тусмаа Баялгийн сангийн хуулиараа зохицуул гээд Үндсэн хуульд заачихсаныг одоо хүртэл орж ирээгүй. Энэ бүрэн эрх ингээд дуусаж байна. Гэтэл тогтоол гээд ингээд сэглэсэн яг улс төрийн зорилготой, зүгээр л улс төрийн зорилготой, сонгуулийн өмнөх амлалт биелүүлэх, мөнгө тараах зорилготой ийм л тогтоолын төсөл. Тэр хуульч нь ч гэсэн хэлж байх шиг байна. Ер нь хувьцааг хуулиар эзэмшүүлнэ гэж ямар ойлголт байдгийг би л лав мэдэхгүй байна. Та ч гэсэн би таныг хариулж чадсангүй, хариулсангүй гэж бодож байна. Эзэмшдэг хувь энэ чинь өмч биш байна шүү дээ. Өмч гэдэг чинь би арилждаг, өсдөг, буурдаг, үнэ цэн нь өөрчлөгддөг, би өвлөдөг, зардаг, борлуулж болдог энэ миний өмч. Гэтэл ард түмэнд эндээс сонсож байгаа ард түмэн үүнээс бас ойлгох ёстой шүү. Энэ танд зүгээр тэнд нэг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм уу. Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэрэнпунцаг нэмж хариулъя. Нэмэлт хариулт өгье.

**Ц.Цэрэнпунцаг:** Цогтгэрэл гишүүний өргөн барьсан Баялгийн сангийн хуулийг бол бид нар энэ Засгийн газраас бас энэ төсөл бэлэн болсон. Тэгээд Засгийн газраас өргөн барихаар энэ 2 хуулиа бид нар хооронд нь уялдаа холбоог нь хангаж хэлэлцэх эсэхээ хоёуланг нь шийдсэний дараа энийг хэлэлцээд цааш нь явъя гэх юм бол ажлын хэсгээ хамтатгаад, үзэл баримтлалын хувьд бол уялдаа холбоог нь хангаж ажлын хэсэг дээрээ ажиллаж явъя гээд ингээд хүлээгдэж байгаа шүү. Засгийн газрын Баялгийн сангийн хууль бол өнөө маргаашгүй өргөн барина гэж ойлгогдож байгаа.

**Л.Мөнхбаатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг чинь шийдэхэд зөвхөн хууль санаачлагчаас л асуулт асууж, хариулдаг юм шүү дээ. Тэрийгээ та бүхэн анхаараарай. Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой”-н асуудал бол чухал асуудал. Яагаад гэвэл өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” экспортын орлогын 60, 70%-ийг бүрдүүлж байна. 11 сарын байдлаар 7,8 тэрбум долларыг дангаараа оруулсан байна. Энэ нь манай валютын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийг 2 дахин сая тэлсэнд гол үүрэг гүйцэтгэж байна гэсэн үг шүү дээ. Хэрэв бид нар 2015 онд, 2016 онд “Эрдэнэс Тавантолгой” 49 хувийг Шинхуад хувьчилъя гээд 2 удаа орж ирэхэд хувьчилчихсан байсан бол өнөөдөр тал нь байхгүй болно л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр бид нар эргэж энэ түүхээ бас харах хэрэгтэй юм. Харин ч эхнийх дээр нь 3.Энхболд аварч үлдсэн. 2015 онд. 2 дахь дээр нь манай намын бүлэг дээр 2016 онд манай намын бүлэг дээр 2 хүний саналын илүүтэйгээр харин бас энэ “Эрдэнэс Тавантолгой” харьд очихгүй, аврагдаж үлдсэн байхгүй юу. Хэрвээ бид нар тэр үед хувьчилчихсан байсан бол өнөөдөр төсвөө 2 дахин нэмж, цалин, тэтгэврийг нэмэх ямар ч боломжгүй л болох байлаа. Тиймээс энэ “Эрдэнэс

Тавантолгой”, “Эрдэнэт” гэсэн энэ стратегийн ордуудыг хувь хүнд хувьчлах тухай асуудал бол байж болохгүй юм. Зүгээр иргэддээ хувьцаа эзэмшүүл. Тэр хувьцаа нь хаалттай, арилжааалагддаггүй ийм л байх ёстой. Зөвхөн ноогдол ашиг өгдөг. Энэ асуудлыг л сайн шийдэхгүй бол нөгөө орлого багатай иргэд маань явцдаа нөгөө хувьцаагаа зардаг ийм болгочих юм бол энэ стратегийн орд хэнд ч очиж мэдэх ийм л байдал руу очих юм байгаа юм.

Ер нь энэ манай оронд нэг өвөрмөц онцлог байгаа нь зах зээл нь өөрөө жижигхэн, бизнесийн орчин муу. Та нар гуанз, рестораныг харвал өдөртөө өдрийн цайгаар юм уу орой л хүн орж ирж байгаа шүү дээ. Тэгвэл зах зээл ихтэй оронд бол өдөржин бараг оройжингоо хүнээр пиг дүүрэн байгаа. Тэгээд энэ чинь өөрөө сонгомол утгаараа зах зээл хөгжих боломж мууг л харуулж харуулж байгаа юм. Тийм орнууд бол төрийн зохицуулалттай байдаг. Ялангуяа стратегийн гол орлого олж байгаа үйлдвэрүүд ордууд нь төрийн өмчдөө байдаг. Дани, Финлянд, Норвег, Чили гэсэн орнууд. Жишээлбэл хамгийн амжилттай бол энэ юу гэдэг юм. Корпорацын удирдлага буюу төрийн зохицуулалттай эдийн засгийг маш сайн хэрэгжүүлдэг. Бид бас л жижиг орон. Жижиг зах зээлтэй. Тийм учраас энэ чиглэлээр явах ёстой. Тэгэхээр энэ Тавантолгойн хувьчлалын асуудал дээр бол бид нар маш болгоомжтой хандаж байх ёстой зүйл. Эрдэнэтийн 49 хувиа бид нар алдчих дөхсөн шүү дээ. Тийм учраас “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” гэсэн улс орноо тэжээж байгаа энэ үйлдвэрүүдийн хувьчлалын асуудал дээр бид нар маш анхааралтай байх ёстой. Гэрэл цахилгааны мөнгийг тэр ковидын хүнд цар тахлын үед хэн төлсөн. Энэ төрийн өмчийн компаниуд л төлсөн шүү дээ. Тэгэхээр төрийн өмчийн энэ компаниуд байна гэдэг чинь менежментийг нь сайжруулаад явах юм бол олон түмэнд хэрэгтэй юм. Ийм хүнд цаг үед бол тэд нар л карманаасаа



мөнгөө гаргана. Гэтэл нөгөө үнэ цэнтэй аж ахуйн нэгжүүдийг хувьчилж авсан байсан нөхдүүд цар тахлын хүнд үед мөнгө гаргасан уу, гаргаагүй. Тийм учраас энэ Скандинавын орнууд чинь энэ стратегийн гол үйлдвэрүүдээ төрийн өмчдөө байлгаад байдаг байх нь байна шүү дээ. Яагаад гэвэл жижиг зах зээлтэй тэр Америк шиг, энэ Хятад шиг, Япон шиг тийм том зах зээл тэдэнд байхгүй. Тийм учраас зохицуулалттай төрийн эдийн засагтай байдаг. Энэ чиглэлээрээ бид нар хөгжих ёстой. Энэ чиглэлээрээ энэ үйлдвэр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн гишүүн хариулт авах юм уу. Ер нь бол яах вэ, гишүүдэд хэлэхэд хэлэлцэх эсэхийг шийдэж байгаа тохиолдолд хууль санаачлагчийн илтгэлээс асууж болно. Мөн байнгын хороогоор хэлэлцсэн учраас Байнгын хорооноос бас асуудаг дэгтэй. Аль аль дээрээс нь асуух боломжтой байгаа гэдгийг хэлье. Хэн хариулах вэ. Даваасүрэн гишүүн асуултад хэн хариулах юм. Монгол Улсын Шадар сайд Амарсайхан хариулъя.

**С.Амарсайхан:** Даваасүрэн гишүүний хэлж байгаа зөв. Ер нь зүгээр Баялгийн сан, хувьцаа эзэмшигчдийн асуудал гэдгийг бид бас ялгаж салгаж ойлгох ёстой юм байгаа юм. Энэ орж ирж байгаа асуудал бол яг хувьцаа эзэмшигч Монгол Улсын иргэдэд энэ баялгийг эрх тэгш үр өгөөжийг нь хүртээх тухай асуудал байгаад байгаа юм. Баялгийн сангийн хууль бол үндэсний хэмжээнд бусад аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, үйл ажиллагаатай уялдуулж үндэсний хэмжээний бүтээн байгуулалт энэ тогтвортой хөгжлийн хөрөнгө оруулалтын эрх ашгийг хамгаалах үүднээс бий болж байгаа ийм сангийн асуудал. Энэ хувьцаа эзэмшигч тэр дундаа Тавантолгой компанийн 34%-ийг нийт Монголын иргэн бүрд эзэмшүүлнэ гэдэг бол иргэн өөрөө эзэмшигчийнхээ хувьд, хувьцаа эзэмшиж байгаа хувьд ноогдол ашгаа хүртэх, түүнийгээ хэрхэн зарцуулах нь өөрийнх

нь эрхийн хэмжээний асуудал байх л ийм хууль эрх зүйн зохицуулалтыг оруулж өгч байгаа юм.

Сая Даваасүрэн гишүүн бас хэлж байна. Яалт ч үгүй энэ төрийн өмчид зарим стратегийн орд аж ахуйн нэгжүүд байж байж бид цаашид өөрсдөө энэ хөгжлийн бодлого, түүний төлөвлөлтөө бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, энэ эдийн засгийн аюулгүй байдлаа хангах, бүс нутгийн интеграцтай уялдуулж үндэсний хөгжлийн бодлогынхоо тогтолцоог тогтвортой хангаж явах ийм боломж нөхцөл бүрдэх юм байгаа юм. Тэгэхгүйгээр бүгдийг нь хувьчлаад эсвэл явах гэдэг асуудал бол бас бодох ёстой асуудал. Ер нь зүгээр энэ дээр нэмээд хэлэхэд Цогтгэрэл гишүүний хэлээд байгаа тэр өмчийн асуудал эзэмшигч гээд байгаа. Манай Цогтгэрэл гишүүн бол өөрөө аж ахуй эрхлэгч, бизнес эрхлэгч, өмч, хувьцаа эзэмшигч юу гэдгийг хамгийн сайн ойлгох хүн. Хүн өөрөө өмчөө эзэмшидэг. Эзэмшиж байгаа өмчөө хуулийн дагуу нийгмийн харилцаагаар дамжуулж баталгаажуулахын тулд өөрөө энийгээ эзэмшигч, хувьцаа эзэмшигч гэж явдаг. Хувийн компани ч бай, олон нийтийн компани ч бай. Тэгэхээр үүний ялгаа салгаа гэдэг асуудлыг бид нэг их тийм ойлгож ядаад байх зүйл ерөөсөө биш. Энэ хувьцаа эзэмшигч иргэдийн эрхийг хуулиар батлагдаж байгаа асуудал өөрөө хувьцаа эзэмшигчийн асуудал болж явж байгаа юм. Өмчийн эзэмшигч өмч хөрөнгийн асуудал бол тэр тусдаа асуудал.

**Л.Мөнхбаатар:** Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” гээд тогтоолын төслийг Засгийн газраас оруулж ирж байна. Тогтоолын төслийн хүрээнд өнөөдөр яах вэ, зүгээр Монгол

Улсын иргэн бүрд эзэмшүүлчихсэн байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн Тавантолгой ордын 18%-ийг 34% болгож иргэдэд эзэмшүүлэх хувь хувьцааг нэмэгдүүлэх гэж байгаа асуудлыг бол би зүгээр зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Зарчмын хувьд, агуулгынх нь хувьд, зорилгынх нь хувьд дэмжиж байна.

Шууд утгаараа өнөөдөр яг өнөөдөр үндсэндээ та бүхний эзэмшүүлэх гээд байгаа хувьцаа гэдэг зүйл чинь бас яг хувьцаа биш шүү. Энэ гишүүдийн хэлээд байгаа саналууд бас зарчмын хувьд зөв шүү. Үндсэндээ хувьцаа гэдэг чинь өөрөө юу юм бэ гэхээр энэ чинь өөрөө санхүүгийн зах зээл дээр арь арилжаалагддаг санхүүгийн л бүтээгдэхүүн байгаад байгаа юм. Тэр нь өөрөө үнэ цэн нь өсдөг, хөрөнгийн биржид арилжаалагддаг. Тэгэхээр өнөөдөр үндсэндээ бид нарын энэ оруулж ирж байгаа энэ зүйл чинь бол нэг талдаа бид нар зүгээр эрхийн бичгийн асуудал л байгаад байгаа байхгүй юу. Энэ компани чинь 2010 онд байгуулагдсан 2012 онд буруу санаагүй бол 2012 онд иргэдэд хувьцааг эзэмшүүлж эхэлсэн. Одоо ингээд үзэхээр тэр үед Монгол Улсын иргэн болоод хувьцаа авч байсан тэр хүүхдүүд өнөөдөр 13, 14 нас хүрчихлээ. Гэтэл 1072 хувьцаа нь өнөөдөр 1 сая төгрөгийнхөө үнэтэйд тухайн үед байсан 1 сая төгрөгийн үнэ цэн яг хэвээрээ л байгаад байгаа юм. 14 жилийн дараа энэ 14 жилийн хугацаанд бид нар 60 мянган төгрөгийн ноогдол ашиг өгсөн байхгүй юу. Тэгээд би юу хэлэх гээд байна вэ гэхээр ерөөсөө энэ агуулгын хувьд бүгд энэ тогтоолынх асуудлыг өөрчилье. Агуулгын хувьд. Олон нийтэд бид нар чинь хөрөнгийн биржид бүртгэлтэй олон нийтэд арилжаалагддаг хувьцаа гаргадаг компани болгох, хувиргах, өөрчлөх асуудал чинь номер 1 асуудал болчихоод байгаа байхгүй юу. Энийгээ л хийе үүгээрээ. Тэгэхгүй бол бид нар 2 дахь зах зээл дээр гардаггүй IPO хийдэггүй, хөрөнгийн зах зээл гардаггүй. Улсын Их Хурлаас удаа дараа тэр та

бүхний хэлээд байгаа 15, 16 тогтоол гарсны чинь дийлэнх дээр нь ерөөсөө олон нийтэд хувьцаат компани бол олон нийтэд хувьцаагаа гадаад, дотоодын хөрөнгийн биржээр гаргадаг, гарга гэдэг асуудлыг л тавьж хэлсэн шүү дээ. Тэгж байж энэ хувьцаа чинь өөрөө сая төгрөгийн хувьцаа өөрөө үнэ цэнтэй болж, 10 сая төгрөгийн үнэтэй, магадгүй жилдээ 2-3 сая төгрөгийн ноогдол ашиг өгдөг ч гэдэг юм уу ийм л үр өгөөжтэй, үнэ цэнтэй компани болох ёстой байхгүй юу. Энэ чинь л иргэдэд хэрэгтэй болчихоод байгаа юм.

Тэрнээс 14 жилд 1 удаа 60 мянган төгрөгийн ноогдол ашиг өгдөг ийм компани байвал энэ чинь өөрөө утгагүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хувьцааны үнэ цэн өөрөө утгагүй болоод тэгж хараад байгаа юм. Тэгэхээр бид нар нээлттэй ерөөсөө яаралтай энэ тогтоол дээр агуулгын хувьд гадаад, дотоодын тэр өмнөх тогтоолууд дээр байсан хөрөнгийн биржид гаргах хувьцааг нээлттэй арилжаалах энэ эрхийг нь нээж өгөөд, хугацааг нь тогтоож өгөөд хугацааг нь заагаад ингээд явуулаач ээ л гэдэг асуудлыг би хэлэх гээд байгаа юм. Хувьцаат компани болгоё. Олон нийтийн хоёрдогч зах зээл дээр гаргая. Ингээж байж өөрөө энэ олон нийтэд орно. Бүх мэдээлэл нь ил тод болно. Хулгай өөрөө цаашидаа байхгүй болно. Хамгийн сайн менежерүүд энэ компанийг чинь удирдаж авч явдаг болно. Бид нарын эрх ашгийн төлөө үнэ цэнийг нь өсгөхийн төлөө ч ажилладаг болох байхгүй юу. Тэгээд жилийнхээ эцэстээ магадгүй тэр ноогдол ашгаа хуваарилдаг ийм л зүйлийг л хийх гээд байгаа юм. Би тэгэхээр энийг яагаад та бүхэн хийхгүй байгаад байгаа юм бэ. Өмнөх 2010 оны 7 сарын тогтоол байна. 2018 оны 6 сарын 29-ний тогтоол байна. 2019 оны Засгийн газрын тогтоол байгаад байна. Энэ дээр юу гэхээр гадаад, дотоодын биржээр худалдаа шаардлагатай бол хөрөнгө оруулалтаа тат гэдэг асуудлыг тавиад байгаа юм. 30 хүртэл хувийг нь бүр өшөө бүр гарга гэсэн асуудлыг тавиад байгаа

юм. Энэ яагаад хэрэгжихгүй байгаад байгаа юм. Яагаад хувьцаа олон нийтэд биржийг нь гаргахгүй байгаад байгаа юм асуудлууд байгаа юм.

3 дугаарт би энэ тогтоолын чинь 4 дүгээр заалт болоод 2 дахь заалт нь ямар хэрэгтэй юм бэ. Энэ нөгөө 14 жилийн өмнө эзэмшүүлсэн 1072 хувьцаа чинь таных 933 төгрөг буюу нэгж үнэ нь нийтдээ таных сая төгрөг шүү л гэдэг чинь баталгаажуулж өгөөд байгаа юм уу. Тэгээд та шаардлагатай бол энийг чинь зарж үрж болно. Борлуулж, буцааж худалдаж авч болно гээд байгаа байхгүй юу. Ингэж болохгүй шүү дээ. Энэ хувьцаа чинь тэр иргэдэд байх ёстой байхгүй юу. Сая төгрөгөөрөө байж байж магадгүй 2, 3 жилийн дараа хөрөнгийн биржид гарсны дараа энэ чинь мөн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. 4 асуулт байх шиг байна. Наранцогт дарга хариулах уу. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**С.Наранцогт:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Энэ компанийн энэ тогтоолын яг агуулга нь нөгөө түрүүн хэлсэн анх энэ Баялгийн сангийн хууль байгаагүй. Тэгээд энэ ард иргэддээ “Тавантолгой” ХК ашигт малтмалаас ноогдол ашиг хуваарилах замаар үр өгөөжийг хүргэх зорилгоор ингээд ийм хаалттай хувьцаа ингэж гаргасан юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр 2010 оноос хойш 16 тогтоол нь ер нь л энэ хувьцааг л буцааж авсан, буцааж тараасан, нэмэгдүүлсэн ийм чиглэлээр яваад байсан. Яах вэ таны хэлж байгаа заалт 2, 3 тогтоол байгаа олон нийтэд. Ашигт малтмалын хуулиар стратегийн ач холбогдолтой энэ орд эзэмшигч 10 хувиа олон нийтэд болгосон хуулийн заалттай байгаа. Энийг бол хэрэгжүүлж ажиллах ёстой. Тэгэхээр энэ агуулгын хувьд бол 2 дахь зах зээл дээр арилжигддаг энгийн хувьцаа энэ нэгэнт 1072 гээд 2010 онд ингээд анх гаргаснаас хойш ингээд яваад байгаа хувьцааг бол

нэг мөр ингээд цэгцэлж авах зорилгоор оруулж ирж байгаа юм. Энийг нэг мөр цэгцэлж авахгүй бол угаасаа бид нар Баялгийн сангийн хууль дээр ард иргэддээ яг Үндсэн хуулийн 6.2-т заасан концепцоор асуудлуудыг оруулж ирж байгаа. Тэгэхдээ энэ 1072 хувьцааг “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг анхнаас нь ийм болгоод хаячихсан юмыг нэг цэгцэлж авахгүй бол 2016 оны 6 сард сайн хувьцаа гаргаад, буцааж худалдаж аваад ингээд одоо сая 218 мянган иргэн хувьцаагүй болчихоод байгаа юм. 1072 тэгэхээр энэ хувьцааг нь буцааж олгоод ер нь энийг 34 хувьд хүргэх энэ нэг юмаа цэгцэлж байж, дараагийн асуудал яригдахгүй бол олон нийтэд 10 хувийнхаа тэр нийтэд гаргах нь асуудал чинь ч гэсэн өөрөө бас хүндрэлтэй болж эхэлнэ. Тэгэхээр засаглалыг сайжруулах тухай олон гишүүд ярьж байгаа. Бид хууль, эрх зүйн хувьд баялгийн сан дээр энэ Үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлэгч төрийн өмчит оролцоотой болон төрийн өмч давамгайлсан компанийн засаглал, үйл ажиллагаа гээд бүхэл бүтэн бүлэг оруулж ирж байгаа. Яг энэ дээр бол энэ олон улсын компаниудад ямар засаглалтай явж байж энэ хулгай зэлгийгүй сайн ажилладаг сайн засаглал тогтох вэ, тэр концепцоо бол оруулчихсан явж байгаа. Тэгэхээр тэр бол хуулийнхаа хүрээнд явчихна. Энэ хуулиа бид нар хэлэлцэхээс өмнө 1072 хувьцааныхаа асуудлыг нэг мөр бүр анх тэр агуулсан хуваарийг нь гаргаад, тэгээд өмнөх гаргасан ер нь энэ тогтоолуудыг бүгдийг нь 1 тогтоол гарч аваад хүчингүй болгочихсон нь бараг шулуухан. Тэгээд Баялгийн сангийнхаа хуулийг аваад энэ уул уурхайн чиглэлээр ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмч давамгайлсан компаниудынхаа засаглал үйл ажиллагаа, ноогдол ашиг хуваарилах энэ асуудлуудаа нэг мөр ингээд цэгцлээд явчих нь зөв байх. Тийм учраас энэ нөгөө олон нийтийн 2 дахь зах.../минут дуусав/



**Л.Мөнхбаатар:** Яасан хариулж болсон уу. Гүйцээж хариулах юм уу, яах юм. Та тодруулах юм уу. Хариултыг нь дуусгачих уу. Ажлын хэсэг нэмээд хариулчихъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгөөрэй. Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Тийм. Тэгэхээр сүүлд нь нөгөө дүгнээд хэлэхэд энэ нөгөө тогтоолынх нь зорилго нь өөрөө ингээд анх гараад олон удаа явчихсан, тэгээд ингээд заримдаг болчихоод байгаа энэ асуудлаа нэг мөр л цэгцэлж яг нийт иргэддээ энэ 1072 хувьцааг нь жигд өгөөд тэгээд энэнийхээ зохицуулалтыг ажлын хэсэг дээр нарийвчилж ярих нөгөө гишүүдийн ярьж байгаа энэ үнэт цаастай холбоотой эзэмшүүлэх юм уу ингэх юм уу өмчлөх гээд иймэрхүү асуудлыг бол ажлын хэсгийн хүрээнд энэ ажлын хэсгээс СЗХ-ны хүмүүс ч орно. Холбогдох хуульчид нь орж байгаад ажлын хэсгийнхээ хүрээнд тогтоолынхоо зүйл заалт, үг үсэг дээр өөрчлөлт заалт нэмж хасах тухай асуудлыг бол жич ярья гэсэн юм. Энэ асуудал нэлээн яригдсан юм. Гол агуулга нь бол энэ нөгөө олон нийтэд 2 дахь зах зээл дээр гаргаж байгаа нээлттэй хувьцаа биш. Анхнаасаа ингээд иргэдэд олгочихсон 1072 хувьцааныхаа асуудлыг л нэг мөр цэгцэлж авах гэж л оруулж ирж байгаа юм. Тэгэхгүй бол одоо энэ 2 дугаар сарын 19-нд ТУЗ-ийн хурал болоод компани бол сайн ажиллаад ноогдол ашиг тарааж бас болохуйц байдалтай байгаа гэхээр энэ үнийн өмнө энэ асуудлаа цэгцлэхгүй бол болж өгөхгүй байгаа юм. Мэдээж бас хууль бол давхар явах байх. Тэгэхдээ 2 сарын 19-өөс өмнө амжих эсэх нь бас тодорхойгүй байгаа. Тийм зорилгоор оруулж ирж байгаа гэдгийг л тодотгож хэлэх гэсэн юм.

**Л.Мөнхбаатар:** Тэмүүлэн дарга тодруулж асуух уу. Тэмүүлэн дарга тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** Үгүй ээ, би яг тодорхой зүйл асуугаад байгаа шүү дээ.

Би зүгээр 1 дүгээрт яагаад энэ 13, 14 жилийн дараа энэ компанийн чинь хувьцааных нь үнэлгээ нь сая төгрөг байсан бол яг яагаад хэвээрээ байгаад байгаа юм бэ. Бид нар энэ дээр чинь магадгүй шаардлагатай бол олон улсын үнэлгээ оруулаад яг бодит компанийнх нь үнэ цэнийг нь тогтоомоор байна шүү дээ. Нэг ч хувьцааных нь үнэ цэнийг тогтоомоор байна шүү дээ. Яагаад та нар энийг хэлэхгүй байгаад байгаа юм.

Хоёрдугаарх нь хэзээ IPO хийх гээд байгаа юм бэ гэдэг асуудлыг би асуугаад байгаа шүү дээ. Улсын Их Хурал, Засгийн газрын хэд хэдэн тогтоолууд гарчихсан. Хамгийн сүүлийнх нь 2018 онд Улсын Их Хурал та бүхнийг гадаад, дотоодын хөрөнгийн бирж дээр энэ хувьцаагаа гарга гээд чиглэл өгчихсөн шүү дээ. 30 хүртэл хувийг нь гээд Засгийн газраас тогтоол гарчихсан шүү дээ. Энэ хэзээ хэрэгжих юм. Тэрнээс хойш 6 жил болчихсон байгаад байдаг. Бид нарын хүсээд байгаа юу вэ гэхээр энэ бид нарын Монголын ард түмэн 2,3 сая иргэн эзэмшиж байгаа энэ компани компанийн сайн засаглалтай байгаасай, ашигийн төлөө ажилладаг байгаасай, бизнесийн төлөө байгаасай, хараат бус байгаасай, улс төрөөс ангид байгаасай гэж хараад байгаа шүү дээ. Хамгийн сайн менежерүүд энд байдаг байгаасай. Бид нарын үнэ үнэ цэнийг өсөхийн төлөө ажилладаг байгаасай гэж хараад байгаа юм. Тэрнээс юу гэдэг юм энэ компани нэг их төрийн албан хаагч нараар дүүрээд байх шаардлага байхгүй шүү дээ.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгөөрэй. Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Би таны тэр олон нийтэд нээлттэй болоод хувьцааны үнэ бенчмарк хийгддэг. Ингээж явахдаа бол 100% санал нэг байна. Гэхдээ та өөрөө мэдээж байгаа бас ажиллаж байсан. Энэ 2019 онд олон нийтэд IPO гаргана гээд л, үнэлгээ хийгдэнэ гээд бөөн юм болсон.

Тэгээд баахан мөнгө төгрөг үрэгдээд амжилтгүй болсон шүү дээ. Тэгээд үүнээс хойш ингээд энэ компани дээр нэлээдгүй олон асуудал үүслээ. Ингээд энийг цэгцлэх ажил л явж байгаа юм. Энэ цэгцлэх ажлын нэг хэсэг нь бол 1072 хувьцааг нь цэгцэлж авъя. Дараа нь засаглалыг болоод энэ ноогдол ашиг хуваарилах иргэд эндээс яаж хуваарилагдах асуудлыг бол энэ Баялгийн сангийн хууль дээр тодорхой концепт нь орчихсон явж байгаа.

2 дугаарт Ашигт малтмалын хуулийн тэр уул уурхайн стратегийн орд эзэмшигчийн 10 хувийг олон нийтэд гаргана гэсэн хуулийн заалт байгаа шүү дээ. Тэр хэрэгжих ёстой. Гэхдээ шинэ хуулийн төсөл бас дахиад өргөн баригдаж байгаа учраас энэ хууль бас эцэслээд тэр заалтыг нь ямархуу хэлбэрээр өөрчлөгдөх юм уу, хэвээрээ орж ирэх юм уу. Энэ бүхнийгээ эцэслэх хооронд бид энэ компанийн үйл ажиллагаа, засаглалыг бол энэ дүрмийнхээ хүрээнд тэрэндээ л цэгцлээд л таны хэлдэг сайн менежерүүд хөндлөнгийн хараат бус нь 49 дээр сайн хүмүүс орж ирэх энэ байгаа боломжоо ашиглаад тэрэндээ сайжруулаад явж байгаа. Тэгээд энэ хуулиуд ингээд эцэслээд гараад ирэхээр энэ асуудал аяндаа хийгдээд явна. Тэгээд тэр компанийн удирдлага нь энэ хувьцааныхаа үнийн өсөлтөөр цалин урамшууллаа аваад явдаг ч тогтолцоо нь өөрөө бас мотивац болоод явна. Энэ компанийн ТУЗ, удирдлагын сонгон шалгаруулалт энэ тэрийн асуудал бүгдээрээ баялгийн сангийн хууль дээр бид бол тодорхойлчихсон байгаа. Олон улсын сайн яг засаглалын стандартаар явах чиглэлээр тогтоочихсон байгаа. Тэгэхээр энэ ажил бол хийгдэх ёстой. Хийгдэнэ. Цаг хугацааны хувьд л бол ийм.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу та. Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Энэ нөгөө нүүрсний сонсгол хийгдэж байгаа яг ийм үед бас энэ тогтоол ороод ирлээ. Тэгээд ийм болохоороо бас энд онцгой ач холбогдол өгөх ёстой юм. Ер нь бол зарчмын хувьд бол “Эрдэнэс Тавантолгой” компани, “Эрдэнэт” компани, Монгол улсын төрийн өмчийн том компаниуд бүгдээрээ хувийн сектор луу л орох ёстой. Иргэд өмчилдөг байна уу. Хувийн сектор өмчилдөг байна уу. Дийлэнх хэсэг нь бол хувийн секторт байж байж наадах чинь бол авлига, хээл хахууль одоо яригдаад байгаа нүүрсний хулгай гэдэг юм чинь зогсоно. Үнэ цэн нь өснө. Тэгэхээр ийшийгээ явж байгаа хандлага юм байна гэж харж байна. 34 хувийг нь бол.

Одоо асуулт байна. За байз манай “Эрдэнэс Тавантолгой” компани чинь сая нүүрсний сонсохлоор 3,2 их наяд төгрөгийн өртэй. Өөртөө хамааралтай болон хамааралгүй элдэв төрлийн төслүүдийг санхүүжүүлчихсэн. Багануурыг, Шивээ-Овоог, нөгөөдөх нь бол хэзээ ч эргэж төлөгдөхгүй ийм байдалтай байгаад байгаа байхгүй юу. Сая 1 зарим улс төрчид хэлээд байна л даа. Ковидын үеэр бол эд нар л тус болсон гээд болно оо болно. Гэхдээ нөгөө талдаа энэ компани чинь ингээд ийм шинэ жилийн өвлийн өвгөн, Санта Клаус тэгээд ёлжын мод шиг ингээд л бүх юмыг ингээд санхүүжүүлж явсаар байгаад үр дүнд нь энэ чинь ямар ч үнэлгээгүй болчихоод шүү дээ. Тэгээд яаж хувьцаагаа үнэд оруулах гээд байгаа юм. Яаж ноогдол ашгаа тараах гээд байгаа юм бэ гэдэг ийм зовлон чинь дуусахгүй. Тэгэхээр асуулт нь юу юм бэ гэхээр энэ 3,2 их наяд төгрөгийнхөө өр авлагыг та нар хэзээ яаж балансаа цэвэрлэх гээд байгаа юм бэ. Хэзээ яг боломж нөхцөл нь хэзээ ингээд үр ашигтайгаар ажиллаж ноогдол ашгаа тараах гээд байгаа юм. 34 хувийг ингээд иргэд эзэмшинэ гээд орж ирж байна. Зарим хүмүүс нь бол мөнгө хэрэгтэй гээд авах байх л даа. Зарим нь бол хуримтлуулах сонирхол байж таарна шүү дээ. Тэгэхээр хуримтлуулах тэр

механизм оруулж ирж байгаа юу. Өөрөөр хэлэх юм бол Засгийн газрын дор хаяж үнэт цаасны хэмжээгээр бид нар өгөөж өгнө ч гэдэг юм уу, урт хугацаагаар өгөөж өгнө ч гэдэг юм уу. Ингээд хуримтлуулсан тохиолдолд тухайлбал нүүрсийг нь сонсголоор бүгдээрээ харсан шүү дээ.

Хамгийн хэрэгтэй байгаа юм бол Тавантолгой ДЦС. Ямар санхүүжилт хэрэгтэй юм 600 сая ам.доллар. Одоо тэгээд юу болж байгаа юм. Сүүлийн 10 жил байхгүй. Одоо 2 гүйцэтгэгч хоорондоо хэрэлдээд, шүүх дээр байгаад байгаа. Хэрвээ эрчим хүчний сайд нь бид нар та нартай гомдохгүй гэх юм бол нөгөө шүүх дээр ялаад нэг гүйцэтгэгчтэй болох юм байна лээ л дээ. Ингээд бөөн зодоон. Үгүй тохиолдолд дахиад станц байхгүй, цахилгаан байхгүй, монголчууд нөгөө тогоо таслуулсан хэвээрээ ийм л байдалтай байх гээд байна. Гэтэл хамгийн үр ашигтай төсөл бол энд явж байгаа байхгүй юу. Худалдан авагч нь “Оюутолгой”, “Эрдэнэс Тавантолгой” өөрөө өмнийн бүс тэгээд төвийн бүс гээд. Тэгээд эдний тооцоогоор юу вэ вэ гэхээр ердөө л 3, 4 жилийн дотор бол оруулсан зардлаа нөхчихнө. Тэгээд 2030 он хүртэл бол 200 сая доллар, 2033 оноос хойш 300 сая долларын ийм орлого тогтмол болдог. Тэгээд ашгийн түвшин болохоор үүнээс 180 сая доллароос дээш гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ, тэгвэл энийг санхүүжүүлмээр байна шүү дээ. Тийм биз дээ. Тэгэхээр ийм боломжийг та нар судалж үзсэн үү. Энэ дээр нэг хариулт авмаар байна.

2 дугаарт ноогдол ашиг тараах асуудал яригдах байх л даа. Тэгэхээр энэ маань нөгөө сонгуулийн дараа тараах гээд байна уу. Сонгуулийн өмнө тараах гээд байна уу. Хэрвээ сонгуулийн өмнө гэх юм бол энэ чинь зүгээр санал худалдан авалт болчихно. 10 жилийн өмнөх нөгөө Чалкогийн араас орчихлоо шүү дээ. 10 жилийн өмнөх Чалкогийн хамгийн муу жишээ. Хэрвээ яг бодитойгоор энийг ингээд зөв

засаглалтай сонгуулийн ард тараана гэх юм бол энэ бол дэмжиж болох шийдэл байхгүй юу. Тэгээд энэ дээр бол та бүгд тодорхой хариулт өгөөдхөөч. Эсвэл нөгөө ТУЗ шийднэ гээд ингээд битгий хаячхаарай. Яг санхүүгийнхээ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** “Эрдэнэс Монгол” компанийн захирал Наранцогт хариулъя.

**С.Наранцогт:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Эхлээд өр төлбөр “Эрдэнэс Тавантолгой” компани дээр Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч томилогдох үед бол хуримтлагдсан өр төлбөр 4,2 их наяд байсан. 1 жилийн хугацаанд ажиллаад хуримтлагдсан өр төлбөрийг 3,2 их наяд болголоо. Тэгэхээр яах вэ ийм байдлаар ингээд ажиллаад явах юм бол ингээд жилд 1 их наяд төгрөгөөр хуримтлагдсан өр төлбөрөө бууруулаад явах боломж байна гэж бид нар харж байгаа.

2 дугаарт том төслүүдийн асуудал байгаа юм. Том төслүүд ялангуяа таны ярьж байгаа энэ цахилгаан станцын асуудал. Тэгэхээр үндсэндээ “Эрдэнэс монгол” нэгдлийн харьяанд 3 нүүрсний уурхай байна. Шивээ-Овоо, Багануур. Бид бол ер нь энэ том төслүүдийг нэгдлийнхээ хүрээнд энэ 6 үйлдвэр технологийн паркийн чиглэлээр хөгжүүлэх ийм концепц гаргаад энэ дээрээ ажиллаад, бичиг цаасны ажлуудаа нэлээн явуулж байна. Ер нь нэгдлийн хүрээнд энэ том төслүүдийг явуулах бүрэн боломж байгаа юм байна лээ. Гэхдээ нэг проблем байгаа юм. Ер нь энэ Тавантолгойг ч гэсэн ийшээ ч ирсэн бид нар Хөгжлийн банк дээр ч гэсэн үүссэн асуудал бол эцсийн эцэст энэ ард иргэдээ болоод энэ Засгийн газар энэ том төслүүдээ санхүүжүүлэх санхүүгийн механизмын тогтолцоо бий болоогүй байхгүй юу. Тийм учраас бид нар баялгийн сан дээр яг энэ концепцыг оруулж өгч байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ уурхайн компаниуд энэ нэгдэлд бүгд нэгдсэн. Эд нар бол яг хэрэгжүүлэх төслөө хэрэгжүүлээд явдаг. Нийгэм, эдийн засагт ач холбогдол бүхий төслийг Засгийн газар, Их Хурал хэрэгжүүлдэг. Гэхдээ хэрэгжүүлдэг санхүүгийн механизмтай байх ёсто. Одоогийн энэ төсвийн механизм бүгдийг нь Ирээдүйн өв сан руу бас ингээд хураачихдаг. Ийм байгаа учраас л ганц мөнгө олж байгаа компани руугаа өөр механизмгүй учраас нууцад авч гарыг нь мушгиад л, тэгээд л ийм юм руу орсон. Тэгэхээр Баялгийн сангийн хуулийг бид нарын л боловсруулсан концепцоор батлаад өгөх юм бол энэ компанийн засаглал таны ярьж байгаа хувьцааны бенчмарк хийгддэг том төслүүд хөдөлдөг Засгийн газар, Их Хурал нийгэм, эдийн засгийнхаа төслийг хөгжүүлдэг бизнесийн төслүүдээ компаниуд нь өөрөө аваад явдаг ийм боломж бол бүрэн нээгдэнэ.

Бид нар бол энэ 2 парк дээр бол энэ цахилгаан станц болоод бусад төслүүдээ явуулах юм бол Монгол Улсын эрчим хүчний хамаарлаас бүрэн гарах боломжтой юм байна лээ. Бид нар энэ судалгаа юмнуудаа бол хийчихсэн байгаа. Одоо бол бид нарт энэ хууль, эрх зүйн хувьд энэ асуудлаа нэг мөр шийдээж гаргах ёстой. Тэгэх юм бол ингээд явчихна.

2 дахь асуудал бол ноогдол ашиг. Сая хэллээ нөгөө өр төлбөрөө барагдуулсан ноогдол ашиг хуваарилах Компанийн тухай хууль дээр нөхцөлүүд байгаа ноогдол ашиг хуваарилагдаад компани бол төлбөрийн чадвартай үйл ажиллагаа бол хэвийн явагдах ёстой. Яг энэ журмынхаа л дагуу бол 2 сарын 19-өөс өмнө ноогдол ашиг хуваарилах шийдвэрийг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нэмээд хариулчихъя. 1 минут.

**С.Наранцогт:** Тэгээд аудитлагдсан тайлан нь баталгаажсаад,

татварын дараах цэвэр ашигаас ноогдол ашиг хуваарилагддаг. Тэгэхээр компанийнхаа тухай хуульд заасан үйл ажиллагаа алдагдахгүй. Төлбөрийн чадвартай байх энэ нөхцөлөө хангаад одоо Компанийн тухай хуулиараа ТУЗ нь шийднэ. Тэгэхдээ ноогдол ашиг хуваарилагдах бас боломж нэлээн сайн ажиллаж байгаа учраас гарна гэж ингэж үзэж байгаа.

Энэ ер нь бол ийм. Өр, авлага барагдуулах дээр би сая танд хэлсэн. Ерөнхий том дүнгээрээ бол ингээд бид нар 1 жил ажиллахад 1 их наядаар бууруулж чадаж байна шүү дээ. Яг энэ жишгээ ер нь барих ийм төлөвлөгөөтэй байгаа. Жилдээ 1 их наяд бууруулаад. Зүгээр ер нь энэ компаниудын хооронд ингээд баахан өр шир үүсчихсэн байгаа юм. Таны түрүүн хэлдэг ингээд бүх л улсын болоод ТӨК дээр хүндрэл үүсвэл ганц мөнгө олж байгаа энэ Тавантолгойгоосоо л авчихдаг. Зээл болгоод биччихдэг хүүтэй хүү.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу. Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя.

**Т.Доржханд:** Наранцогт дарга аа, Ганбат дарга аа, одоо бүгдээрээ Сангийн яаманд ажиллаж байсан. Та бол Хөгжлийн эдийн засгийн дэд сайд байж байсан. Макрогоо сайн мэдэж байгаа. Энэ жилийн төсөв чинь бол асар их тэлчихсэн төсөв шүү дээ. Тэгээд төсөв хэзээ гарах юм гэхээр сонгуулийн өмнө л чихэж гаргана шүү дээ. Зах зээл рүү мөнгөө чихнэ. Ойлгомжтой. Эхний 6 сард. Одоо та нар дахиад энэ 2 сардаа ингээд ТУЗ шийдвэр гаргаад, ноогдол ашигаа тараана гэх юм бол энэ их хэмжээний мөнгө чинь дахиад л зах зээлд хаалт үүсгэнэ шүү дээ. Тэгээд инфляцаа яаж барих гээд байгаа юм. Дахиад л нөгөө сонгуульд ялж л байвал чухал юм гэсэн ийм бодлого руу орох гээд байгаа юм уу, аль эсвэл яг макро үзүүлэлтүүдээ



харж байгаад шийдэж байгаа юм уу. Энэ дээр нэг тодорхой хариулт өгмөөр байна.

2 дугаарт яах вэ, Баялгийн сангийн хууль орж ирж байна гээд яаралтай оруулж ирэх хэрэгтэй. Концепц бол зөв байна. Гэхдээ хоёрхон л асуудал байгаа шүү дээ. Хэрвээ төр өөрөө 51-ээс дээш хувьтай байх юм бол менежментийг нь бол төрийн албан хаагчид хийж болохгүй ээ. Менежментийн баг хийх ёстой энийг чинь тийм биз. Демосек эд нар шиг. Эсрэг тохиолдолд бол хувийн сектор дийлэнх нь байж байж л энэ үр өгөөж чинь дээшилж явна шүү дээ. Яг алинаар нь та нар явах гээд байгаа юм. Зарчим нь.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулъя. Наранцогт дарга уу. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**С.Наранцогт:** Доржханд гишүүний асуултын тодруулгад хариулъя. Макро эдийн засаг инфляцын асуудал бол яг миний хийж байгаа ажлын хүрээнд бас хариулт өгөхөд жоохон зохимжгүй байх. Тэр том төслийн хувьд бол тантай санал байна. Зүгээр Баялгийн сангийн хуулийн бид нарын төсөл дээр бол сайн засаглал, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эдгээрийн үйл ажиллагааг олон улсын энэ том групп компаниудын сайн засаглалын зарчмуудыг оруулах энэ зарчмаар хуулийн төсөл дээр явж байгаа. Ер нь хуульчлаад өгчих нь бол их зөв байгаа. Тэгэхээр энэ дээр Тимосевк болоод бусад энэ уур уурхайн том сайн засаглалтай компаниудын жишигийг бид нар сайн судалж байгаа л даа ер нь. Тэгэхээр энэ жишигээр явах ёстой гэдэг дээр тантай санал нэг байна. Төслийн менежментийн хувьд бол бид нар том төслийг энэ том төслүүдийг хөрөнгө оруулагчтай ер нь хамтарч хэрэгжүүлнэ. Тэрний менежментээр ер нь явах нь зүйтэй гэж ингэж харж байгаа юм. Ингэж байж үр дүн нь илүү сайн гарна. Тийм учраас энэ том төслүүдийг ер нь хэрэгжүүлэх санал

санаачилгууд ер нь бол гараад байгаа. Ер нь төслийг бол бид нар том төслүүдээ нэгдсэн стратегиар ер нь яг энэ аж үйлдвэрийн гинжин хэлхээ, том хөгжил, шинэ сэргэлт энэ яг том хөгжлийнхөө бодлоготой уялдуулж хэрэглэхгүй бол өмнө нь компаниуд жижиг жижиг, том, жижиг 1, 1 төсөл янз бүрийн байдлаар авч гүйгээд байсан. Энэ бол явахгүй байгаа. Ер нь хэцүү урт хугацаандаа. Тийм учраас бид нар нэгдсэн төлөвлөгөөнийхөө хүрээнд ер нь бол хамгийн зөв сайн технологитой төслүүдийг, сайн хөрөнгө оруулагчийг яг тухайн төслийг хэрэгжүүлэх чадамжгүй тэр тэгээд төслийн хэрэгжилтийн менежментээр нь явах нь бол зүйтэй. Бид нарт бол яг ний нуугүй хэлэхэд бас том төсөл хэрэгжүүлдэг туршилага бага байна шүү дээ. Механизм дээрээ ч гэсэн нэлээн их сул явчихсан юм байна лээ. Төслийн үнэлгээ, судалгааны тогтолцоог бас бид нар бага хэмжээгээр бүтэц үүсгээд энийгээ бас .../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

**Ц.Туваан:** Бид нар алийн болгон алтан дээр суусан гуйлгачин гээд ийм нэртэй улсаараа Монгол Улсаараа Монголчууд бүгдээрээ явах юм бэ. Монгол Улс өнөөдөр нөгөө яриад байдаг Голланд өвчин гэдэг юм чинь бол бүр хэтрээд, одоо бүр баялгийн өвчин тусаад, хэвтэрт ороод бүр сэхээнд орчихсон ингээд байж байна. Тэгэхээр энэ цаг үед Тавантолгойн хувьцааны асуудал яригдаж байна л даа. 2019 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг эрх баригчид яагаад хийхгүй 5 жил болж байна аа. Тавантолгойн хувьцааны өмнө Баялгийн сангийн тухай хууль орж ирэх байсан. Энэ яагаад орж ирэхгүй байгаа юм. Аргаа ядаад АН-ын бүлэг энэ Баялгийн сангийн тухай хуулийг чинь өөрсдийнхөөрөө боловсруулаад, хийгээд бүр маш их цаг зарцуулаад ингээд өргөн барьчихсан байгаа. Энэ яагаад хэлэлцэгдэхгүй байгаа юм. Одоо зүй ёсоороо бол энэ баялгийн сан дотор чинь

энэ Тавантолгой чинь нэлээн гол байр суурь эзлэх ёстой шүү дээ. Стратегийн ордуудаа бүгдийг нь оруулж байгаад энэ Баялгийн сангийнхаа юман дотор оруулаад ярих ёстой шүү дээ. Тэгэхээр ингээд урьдчилаад энэ асуудлыг ингээд оруулж ирж байгаа нь бол үнэхээр тийм хардлага төрүүлж байна.

Сая бид нар 27 их наядын төсөв батлаад хаясан. Сонгуулийн урд, сонгуулийн жилийн төсөв буюу сонгуулийн авлига байж болохуйц төсвийг батлаад хаясан. Одоо дахиад ард түмэндээ энэ “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа өгнө 34 хувьцаа өгнө гээд ингээд сайн хүн болох гээд сайн засаг болох гээд ингээд ажиллаж байна. Энэ бол эргээд мэргэн хүн шиг хэлье. Сонгуулийн өмнө ноогдол ашиг тараана. Ямар нэгэн байгууллагатай урьдчилсан гэрээ хийж байгаад, мөнгө олж байгаад ноогдол ашиг нэрээр сонгуулийн авлига тараах гэж байна гэж ингэж хардаж байна. Тэгэхээр ноогдол ашиг тараах уу гэдэг асуултыг би бас энэ дээр асуумаар байна.

Дараагаар нь яг энэ хувьцаа чинь өөрөө хувьцаа мөн юм уу. 1072 гээд энэ хувьцаа жишээлбэл иргэн Доржийн хувьцаа мөн бол энэ чинь бас зарж болдог, нэгэндээ шилжүүлж болдог баймаар байгаа юм. Тэгэхээр энэ яг хувьцаа мөн үү. Ноогдол ашиг олгогддоггүй, ингээд хувьцаа нэртэй арилжиж болдоггүй энэ хувьцаа яваад байдаг. Тэгээд яагаад энэ сонгууль дөхөх үед яригдаж эхлэв. Дээрээс нь энэ хувьцааг чинь олгож байгаа тэр Тавантолгой гээд компанийн чинь энэ хулгай зэлгий нүүрсний хулгай гэдэг юм чинь бүр хэлэлцэгдээд, бүр энэ сонсголын хүрээнд багтахгаа байлаа шүү дээ. Тэгэхээр яг энэ үед энэ хувьцааны асуудал бас яагаад ингээд орж ирэв. Энэ хувьцаа ноогдол ашигийг чинь ярих тэр байгууллага чинь энэ сонсголын гол сэдэв хулгай зэлгийн гол үүр уурхай болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ үеэр бас энэ асуудал яаж давхарлаж орж ирдэг нь

бас ямар учир шалтгаан байна. Яагаад баялгийн сангийнхаа хуулийн өмнө ороод ирчхэв ээ гэдэг энэ асуудлыг хэнээс ч асуух юм бэ дээ. Тэгээд энэ дээр яг энэ тэр хувьцаа мөн үү, яах вэ, ийх вэ гээд. Дээрээс нь яагаад 34% дээр тогтчихов. Тэгээд энэ бүх баялаг ард түмний өмч юм бол энэ яагаад 51, больё 40 хувь яагаад байж болохгүй 34 хувь дээр тогтчихов. Энэ дээр нэг хариулаад өгөөч. Засгийн газрынхан ч алга байна. Энэ ажлын хэсэг л хариулах байлгүй дээ. Энэ асуудал дээр хариулт авмаар байна. Тэгвэл хариулаарай. Мөнхбаатар дарга тэр Баялгийн сангийн тухай хууль хэзээ орж ирэх тал дээр бас.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Санжаагийн Наранцогт дарга хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофон. Дараа нь нэмээд Уул уурхайн сайд хариулна.

**С.Наранцогт:** Би дахиад хариулъя. Энэ хувьцаа мөн. Гэхдээ хаалттай хувьцаа. Яг 2 дахь зах зээл дээр худалдах бас боломжгүй. Тэгээд тухайн үед 2010 оноос хойш ингээд 16 Их Хурал, Засгийн газрын тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” дээр ард иргэдэд үнэгүй хувьцаа эзэмшүүлэх, буцааж зарах, үр ашиг хүртүүлэх нэрээр буцааж аваад, буцааж олгоод ингээд яваад ирсэн. Тэгэхээр энэ юмыг цэгцлэхгүй бол би түрүүний дахиад хэлье. Энэ 2016 оны 6 сард ингээд сайн хувьцаа тараагаад, хүмүүс буцаагаад хувьцаагаа өгчихсөн. Ингээд 1 сая 218 мянган иргэд бол 1072 хувьцаагүй болчихоод, энэ хувьцаагаа бид нар авна. Та нар тухайн үед бид нарыг хулхидсан, хуурсан. Бид нарыг хувьцаагүй болгосон гэдэг асуудал нэлээн хүчтэй яригдаад байгаа юм. Энэ 1072 хувьцаа гэдэг иргэний нийгмийн байгууллага ч яриад байгаа юм. Тэгэхээр Баялгийн сангийн хуулийн өмнө “Эрдэнэс Тавантолгой”-н энэ 1072 хувьцааг бол 1 талд нь яг нэг мөр шийдэхээс өөр аргагүй байгаа юм. Тийм учраас энэ баялгийн сангийн өмнө оруулж ирж байгаа юм. Баялгийн сангийн хуульд бол стратегийн

ч орно, төрийн өмчийн оролцоотой, давамгайлсан ААН-үүдийг үйл ажиллагаа засаглалын бүлэг оруулж байгаад үйл ажиллагааг нь зохицуулж байгаа. Тэгээд үр ашиг хүртэхийн хувьд бол хувийн компаниудын үйл ажиллагаанаас ч гэсэн ард иргэд үр ашиг хүртэнэ шүү дээ. Баялгийн сангаараа дамжуулаад. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа дэс дараагийн хувьд бол ийм учиртай гэдгийг ойлгох хэрэгтэй.

Дараагийн зүйл бол та 34 гэсэн. Яагаад 34 байна вэ гэхээр энэ компанийн иргэд 14%-ийг эзэмшээд, компани дээр нь өөрт нь халаасны 20%-ийн хувьцаа байгаа. Анх иргэдэд 20%-ийг гаргана гэдэг ийм тогтоол гарсан тийм билээ. Тэгээд хэрэгжүүлээд, буцааж худалдаж аваад, сайн хувьцаа тараагаад, ингээд 14 хувьтай болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ компанийн халаасны 24 хувийн хувьцааг нэмж гаргах замаар 34 хувьцаа ч болж хувь нь яг тэгж тулж ирж байгаа юм. Тийм учраас л энэ л байх.

Тэгээд 2-т бол 34 хувьцаа өөрөө хяналтын багцын хувьцаа. Тэгэхээр энэ логик бол бас ингэж таарч байгаа юм гэдэг зүйлийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу та. Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

**Ц.Туваан:** Яг 34% дээр хэдэн ширхэг хувьцаа болох вэ. Үнэлгээ 933 төгрөгөөрөө хэвээрээ юм шиг ярьж байна. Тийм ээ. Тэгээд иргэдэд тэр хувьцаагаа ахмадууд, оюутнууд зарчихсан асуудал байгаа байх. Тодорхой хэмжээнийх нь 300 мянган төгрөгийн хувьцааг авчихсан хүмүүс байгаа. Эд нар тэр үеийнх нь үнээр буцааж өгөх юм шиг байна. Энэ зөв үү. Яг асуух гээд байгаа нэг асуудал бол цэгцлэх гэж яриад байх юм. Цэгцлэх гэж байгаа юм бол нэмж байж бүр юу гэдэг юм 34% болгож байгаад цэгцлэхэд бүүр хүнд болчих юм биш үү. 1072-оо цэгцэлье гэж байгаа бол 1072 дотроо л эхний асуудлаа

ярьчихаад, энийгээ цэгцэлчхээд дараа нь 34% болгох асуудал чинь яригдвал дэс дарааллынхаа хувьд зөв биш юм уу. Энийг яаж тооцож оруулж ирсэн юм бэ. Цэгцлэх гэж ярьж байгаа бол.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм уу. Болсон уу. Одоо Уул уурхайн сайд нэмж хариулъя. Нөгөө Баялгийн сангийн хуулийг хэзээ оруулж ирэх вэ гэдэг асуулт асууж байна тийм ээ. Ганбаатар сайд ийм микрофон өгье.

**Ж.Ганбаатар:** Ер нь бол Баялгийн сангийн тухай хууль Эдийн засаг, хөгжлийн яаман дээр боловсруулагдаж байгаа. Тэгээд орж ирэх хугацаа нь ер нь бол бид энэ жилийг тийм нэлээн үр дүнтэй жил болохыг хүлээж харж байна гэсэн үг. Тоо баримт нь 2 сарын 10-нд гарч ирнэ л дээ. Бүх ТӨК-ууд болоод төрийн өмчийн оролцоотой компаниудын тайлан баланс нэгтгэгдэнэ. Энийг бол бид харж байна. Мэдээж 50 сая тонн гэж төлөвлөсөн орлого маань бараг 70 руу хүрэх нь байна. Зэс бас хангалттай хэмжээнд хүрнэ. Энэ бүх орлого зарлагаа харж байгаад хэдэн хувийг нь ер нь цаашидаа бид Эдийн засаг, хөгжлийн яамны төлөвлөж байгаа төлөвлөлт энэ тэрээр харж байгаад энэ Баялгийн сангийн тухай хууль орж ирнэ. Түүнээс биш ноднин, уржнангийн мэдээллээр Баялгийн сангийн тухай хуулийг төлөвлөх бол үнэхээр боломжгүй байгаа. Тэгээд энэ бол ямар ч шийдвэр байсан та Туваан гишүүн сайн мэдэж байгаа. Тэгэхээр бид бас тайлан балансаа хараад, тоо баримт дээр үндэслэж байж шийдвэрүүдээ гаргана. Өнөөдрийн энэ хувьцааны ажил ч гэсэн яагаад жилийн эцэст яригдаж байгаа гэдэг нь бас л энэ тоо баримтаа нэгтгэж үзээд, яагаад эхэнд яригдахгүй байгаа шалтгаан л тэр. Энэ тоо баримтаа харж байгаад бид нар хувьцаагаа яах вэ гэдэг. Үнэхээр ашигтай гарч байна уу. Энэ жилийн гүйцэтгэл бол “Эрдэнэс Тавантолгой” компани бараг 3 их наяд руу хүрэх байх. Ашигтай ажиллах төлөвтэй байна. Энэ их



боломж гарч ирж байгаа учраас хувьцааны асуудал яригдах, тэгээд энэ яригдаж байгаа он, сар, өдөр ингэж давхцаж байгаа шүү. Түүнээс биш тэгээд юу гэдэг юм жилийн дундуур ч юм уу, юу яаж ямар төлөвлөлттэй явах юм, цаашидаа БНХАУ-ын импортын бодлого ямар байх нь сая гарлаа энэ 2024 оных нь. Энэ бүхнийг чинь харж байгаад бид бас энэ төлөвлөлтүүдээ оруулж ирж байгаа. Өнөөдрийн яригдаж байгаа он, сар, өдөр ч гэсэн энэтэй таарч байгаа. Одоо энэ хажуу талын танхимд 80 доллар гээд яриад байгаа бол өнөөдөр уучлаарай.

Бид биржээрээ дамжуулаад нүүрсийг хэд болгож байгаа билээ. 400 доллар байхад нь 80 доллар гээд сонин сонин юм яригдаж байна шүү дээ. Бид өнөөдөр 240 байхад 180, 190 доллароор нүүрсээ зарж чадаж байгаа юм. Шууд 240-өөр нь зарж чадахгүй байна л даа. Тэр далайн боомт дээр нь аваачиж өгч чадахгүй байна. Энэ өөрөө тэнд очихын тулд тодорхой тээврүүдийн үнэ хэрэгтэй болно. Тэгэхдээ ямар ч байсан бид бүтээгдэхүүнээ тодорхой үнэд хүргэж чадаж байгаа. Энэ бол бас манай “Эрдэнэс Тавантолгой” компанийн амжилт. Тэгээд энийг давах гэж зөндөө л зүйл болсон шүү. Үнэхээр энэ Ганбаа байгаа тулдаа л үнэхээр ард нь гарсан. Энэ Ганбат. Ганбаа гэхээр би өөрийгөө хэлж байгаа юм ишг болчих байх. Тэгэхлээр Ганбат байгаа тулдаа л ард нь гарсан. Энэ хүнд дотоод, гадаадын ямар их олон даралтууд шахалтууд ирсэн. Ер нь бол Биржийн тухай хууль явахад бол ер нь бүгдээрээ л бүтэхгүй гэсэн шүү дээ. Бүгд бүтэхгүй гэсэн. Та санаж байгаа бол яг миний өөдөөс хараад сууж байсан хүмүүс над руу бүтэхгүй ээ, маргааш дампуурна аа л гэсэн. Хажууд бүр бүгдээрээ л тийм бодолтой байсан. Өнөөдөр харин худалдан авч байгаа тал ч гэсэн үнэхээр энэ соёлд суралцаж байна. Худалдан авч байгаа тал энэ соёлд суралцаж байна. Тэгээд Эрдэнэс баялгийн зүгээр Баялгийн сангийн тухай хууль бол бид бас энэ жилийнхээ үр дүнг хараад ер нь 33, 33-аар явах уу гэдгийг

та бас сонссон байх. 33-ыг нь хадгалъя, 33-ыг нь төсөв дээрээ хийе, 33-ыг нь өсгөж үржүүлъя. Иймэрхүү зүйлүүд бол байгаа. Яг үндсэн зүйл нь бол. Тэгэхдээ тэр тоонууд бол баталгаажуулаагүй байна. Тэгээд энэ дээр бол энэ жилийн үр дүнгүүдийг хараад бид бас боловсруулаад орж ирнэ гэдгийгээ хэлье. Баярлалаа. Дууслаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулъя. Санжаагийн Наранцогт дарга хариулах уу. Өөр хүн хариулах юм уу. Туваан гишүүний асуултыг ойлгосон тийм ээ. Наранцогт дарга хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**С.Наранцогт:** Энэ Тавантолгой дээр 12 тэрбум ширхэг хувьцаа байгаа юм. Эзэмшилд байгаа. 3 тэрбум нь нөгөө түрүүний хэлдэг 20%-ийн халаасны хувьцаа. 34 болохоор 5,1 тэрбум ширхэг хувьцаа л иргэдэд очихоор. Яг энийг бол ажлын хэсэг дээрээ энийг бид нар нэлээн нарийвчилж ярих зүйлүүд байгаа. Зүгээр нийт дүнгээр нь би хэлчихье. Танд 34%-ийн хувьцааны тоо бол 5,1 тэрбум болох юм л гэж хэлж байгаа юм. Энийг бас ажлын хэсэг дээр ярина. Юу гэдэг юм 34 хүртэлх гэдэг үг орж болох л байх л даа.

**Л.Мөнхбаатар:** Ер нь бол Туваан гишүүн ээ, одоо чинь хэлэлцэх эсэх шүү дээ тийм ээ. Хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа Эдийн засгийн байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдана. Тэр үед нь та бас ороод саяын таны тавьж байгаа асуудлуудыг бас тусгах боломжууд бас байгаа шүү. Сая Наранцогт дарга бас тийм боломжууд байгаа талаар хариулж байна шүү дээ.

Одоо Байнгын хорооны дарга Энхбаярын Батишугар асуултаа асууя.

**Э.Батишугар:** Баярлалаа. Энэ байгалийн баялаг ард түмний өмч байх ёстой концептоо дэмжиж байгаа юм. Байгалийн баялаг чинь ямар нэг хүн бүтээгээгүй. Байгаль дэлхийн

Монголчуудад заяасан. Тийм болохоор Монголчууд бүгдээрээ л жигд хүртэх ёстой өгөөжийг нь. Гэхдээ энэ дээр бол яг ямар концептоор хүртүүлэх вэ гэдэг нь бас асуудал байгаад байгаа юм. Яагаад гэвэл шууд 1072 гэхээр чинь хэлбэр төдий л ахиад болох гээд байгаа юм. Хойно нь үнэ цэн байхгүй. Тэгээд илүү бодитойгоор бол бусад улс орнуудын кэйсийг харахад давуу эрхтэй хувьцаа, өөр ангиллын хувьцаа, Голден шэйр гээд Монголд ч гэсэн тийм кэйсүүд байгаа. Зарим банкнууд бол Монголын банк, дотоодын банкнууд болохоор тодорхой хувьцаа нь алтан хувьцаа гэж ярьдаг. Тэр нь бол ямар ч нөхцөл байдалд ноогдол ашиг авдаг. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр байгалийн бэлэгт ноогдол ашиг авдаг болох нь хамгийн зөв байгаад байгаа юм. Гэхдээ бүгдийг нь биш, тодорхой хувийг нь. Магадгүй одоо тэр алтан хувьцаандаа бол 20%-ийн ч юм уу цэвэр ашигийнхаа татварын дараах байнгын л ноогдол ашгаа олгодог болгомоор байгаа юм.

Сая бас гишүүд ярьж байна. Байгалийн сантайгаа яаж уялдах вэ гээд. Тэгээд мэдээж энэ бол хэрвээ энэ Тавантолгойн уурхай чинь өөрөө юу гэдэг юм нөөц нь дуусчихна, аль эсвэл нүүрс худалдаж авахаа больчихвол энэ 1072 хувьцаа чинь ерөөсөө үнэ цэн нь уначихна шүү дээ. Хоосон цаас болчих гээд байгаа юм. Тэгэхээр байгалийн баялагтайгаа заавал уялдуулаад тэр нөгөө яриад байгаа тодорхой хувийг нь менежмент хийгээд, өгөөж өгөөд явдаг. Энэ хамгийн зөв концепт. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор жишээлбэл юу байгаа юм, Аляскийн Пэрнемонтфан гэж байдаг юм. 1976 онд байгуулагдсан. Энэ нөгөө газрын тосныхоо орлогоос тодорхой хувийг нь Аляскийн ард иргэддээ заавал ноогдол ашгаар өгдөг. Нөгөө хувийг нь баялгийн сандаа үржүүлээд явдаг. Жишээлбэл, 2023 онд энэ сан нь бол 1312 доллар өгч байгаа юм. 2005 онд бүр 2072 доллар өгч байсан. Тэгэхээр энэ концептоор явахад хамгийн зөв гэж бодоод байгаа юм. Тодорхой хувийн

ноогдол ашгийг ард иргэддээ өгнө. Тодорхой хувийг нь байгалийн сандаа үлдээгээд, тэрийгээ менежмент хийгээд үржүүлээд хойд үедээ үлдээхээр явах. Энэ нь бол хамгийн зөв юм болоод байгаа юм л даа.

2-т нь энэ үнэлгээний талаар яригдаж байна л даа. 1072 нь 1 сая төгрөг үү, үгүй юу гээд. Тэгэхээр нийт Тавантолгой гэдэг энэ компани “Эрдэнэс Тавантолгой” компанийн яг одоо зах зээлийн байдлыг үнэлмээр байгаа юм. Тэгээд миний хувьд бол би 2011 онд Жэй Пи Морганд ажилладаг байхдаа Тавантолгойн төсөл дээр ажиллаж байсан юм. Тухайн үед ч бас IPO яригдаад. Тэгээд манай баг бол тухайн үед 9 тэрбум доллароор үнэлж байсан. Тэгээд өнөөдөр эргээд харахад бол яг одоо 60-80 сая тонн олборлодог, 300-400 сая долларын цэвэр ашигтай нүүрсний компани бол зах зээлд байгаа үнэлгээ нь 10-30 тэрбум доллар байгаа юм. Тэгэхээр энийгээ Тавантолгой гэж бодоход энэ бол чинь ерөөсөө 15 тэрбум гэж бодохоор чинь 34%-ийг нь 5,16 тэрбум доллар. Энийгээ 3,4 сая хүндээ хуваахаар чинь 1.500 доллар. 1.500 доллар чинь өөрөө 5 сая 100 мянган төгрөг болж байгаа юм. Өнөөдрийн ханиаар. Тэгэхээр чинь яг бодит хани нь яг юу болоод явчхаж байгаа байхгүй юу. 5 сая төгрөг л хүргэхээр тийм концепт харагдаад байна л даа. Тэгээд яг энийг нь тэгэхээр яг бодит зах зээлийн ханиид хүрэхийн тулд юу хэрэгтэй вэ гэхээр нөгөө сая Тэмүүлэн гишүүний яриад байсан IPO л хийх гээд байна лээ л да. Энэ IPO хийж байж бид нар чинь Тавантолгойн цахилгаан станц санхүүжилтээр байна. Яагаад гэвэл экюти финанс гэдэг өөрийнхөө хөрөнгөөр том прожектыг санхүүжүүлэх чинь хамгийн үнэтэй санхүүжилт гэж олон улсын санхүүчдийн дүгнэлт байдаг. Тэгснээс прожект финанс хийх нь хамгийн зөв.

Тэгээд асуулт нь бол 1 дүгээрт үнэлгээгээ бид нар тодорхойлж чадсан уу. Энийгээ хөндлөнгийн үнэлгээгээ

компани ямар нэг дилойт юм уу аудитын компани хийж чаддаггүй шүү энийг. Илүү нөгөө хөрөнгө оруулалттай банкирууд хийдэг. Яагаад гэвэл энэ чинь юу байгаа байхгүй юу. DSF, Moltifly гээд янз янзын тийм тусгай аргачлалууд байгаа. Эд нарын дунджаас үндсэн нөгөө нэг юуг нь гаргадаг. Үнэлгээгээ гаргаж байгаа л даа.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Наранцогт дарга хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**С.Наранцогт:** Батиугар гишүүний асуултад хариулъя. Тэр Аляскийн кэйс нөгөө ард иргэддээ хуваарилдаг, шинэ Мексик мужид бас ийм хуваарилалт хийгддэг юм байна лээ. Ашигт малтмал. Энийг бол бид нар бас судлаад, тэгээд Баялгийн сангийн хуулийн концепцод бол таны ярьж байгаа тэр концепцууд нь өөрөө ороод ирж байгаа. Харин энэ Тавантолгойн хувьцааны талаар бол би түрүүнээс хойш яриад байгаа юм. Ингээд 2010 оноос хойш хувьцаа нэрээр гараад, тэгээд агуулга нь бол энэ ард иргэдэд л энэ Тавантолгойгоос олох үр ашгийг хуваарилах ийм зорилгоор ингээд яваад ирсэн. Хэрэгжиж байгаа агуулгыг нь харах юм бол саналын эрхгүй зэргийг нь харахаар давуу эрхийн хувьцаа шиг ингээд бас явдаг ч тал бай байгаа. Тэгээд яах вэ, ажлын хэсгийн хуралдааны үеэр бол бид нар яг энэ сая түрүүн хэлсэн үг үсгийн хувьд бас энэ заалтын хувьд бас нэлээн ярилцах шаардлагатай зүйлүүд байгаа. Бид нар бас нэлээдгүй ярьсан. Ийм зүйл байгаа. Мэдээж хувьцааны нэгж үнэлгээний тухай асуудал бол таны ярьж байгаа анх гарахдаа ч тэр нөөц баялаг дээрээ тулгуурлаж энэ компанийн үнэлгээ хийгдсэн. Энэнийхээ хүрээнд энэ хувьцааны тоо тодорхойлогдсон байгаа юм.

Тэгээд түрүүн бас Тэмүүлэн гишүүний ярьж байгаа тэр үнэн л дээ. Энэ хувьцааны үнэлгээ нь бол өөрөө

ингээд олон нийтэд гараад 2 дахь зах зээл дээр үнэлгээ нь яг хийгдээд үүгээрээ тогтоогдоод явна. Тэгэхээр дэс дарааллын хувьд бол нөгөө түрүүн хэлээд байгаа эхлээд энийг 1072-той холбоотой энэ их олон гарсан тогтоолынхоо хэрэгжилтүүдээр энэ нэг тогтоолоор цэгцлээд, өмнөх тогтоолуудаа хүчингүй болгод юм уу, яадаг юм. Ингээд бид Тавантолгойн 1072 иргэдийн энэ хувьцааны асуудлыг бол цэгцэлж аваад, тэгээд Баялгийн сангийн хуулийг ингээд батлахаар юмнууд бол их тодорхой болно. Энэ компанийн засаглал үйл ажиллагаа ноогдол ашиг энэ зүйлүүд нэлээн тодорхой болж байна. Тэгэхээр ярьж байгаа үнэлгээ 2019 онд энийг чинь бас олон нийтэд олон улсын зах зээлд гаргана гээд бөөн ажил хийгдээд, тэгээд хийж чадаагүй л дээ. Тэгэхээр тэр дээр авсан сургамжууд, хийгдсэн ажлын бас юмнууд ч байгаа. Тэгэхээр энэ дэс дарааллын хувьд бол Ашигт малтмалын хууль бас батлагдана. Тэр дээр стратегийн ордын 10 хувийг нийтэд гаргах ч заалт байгаа. Тэр хуулийн заалт бас хэрэгжих ёстой. Ингээд явахаар олон нийтэд гаргах тэр процедурынхаа дагуу компанийн үнэлгээ хийгдээд, нэгж хувьцааны тэр 10 хувийн хувьцаагаа гаргах энэ ажил бол хууль журмынхаа дагуу бол мэдээж хийгдээд явна. Тэр үед мэдээж таны ярьж байгаа энэ ямар үнэлгээний компаниар компанийн үнэлгээг яаж хэлэх вэ гэдэг асуудал бол тодорхой яригдана гэж ингэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Энхбаярын Батиугар гишүүн тодруулж асууя.

**Э.Батиугар:** Та 2019 онд IPO-г ерөнхийдөө хийх гэж концептыг нь тэгээд янз янзын ажиллагаа явуулсан гэж байна. Тэгээд тухайн үеийн ямар ямар үнэлгээний компаниудаар урьж авчирч үнэлүүлсэн бэ. 1-д.

2 -т нь хэдээр үнэлж байсан бэ тухайн үед. 2019 онд хэдэн доллар. Байхгүй юу. Тэгэхээр ер нь бол IPO л

хамгийн зөв л дөө. Тэгээд ТӨК-ууд IPO чинь зөндөө байдаг. Жишээлбэл, одоо хамгийн сайн менежменттэй кэйс гэж яривал Рио Тинто байгаа шүү дээ. Эцсийн үр дүндээ Рио Тинто чинь хамгийн том хувьцаа эзэмшигчид нь II хувийг эзэмшдэг нь Чайна Албуминийн Корпорц, Хятадын ТӨК. Гэхдээ бол менежментийг нь бид нар мэднэ. Хамгийн дэлхийн том уул уурхайн компанийн нэг болж чадсан. Би Эйч Би-ээс том болчихсон сүүлийн 10 жилд. Тэгэхээр ер нь IPO хийсэн компаниуд болон хөндлөнгийн хамгийн зөв менежменттэй баг авчирч байж л компанийн үнэ цэнийг бүрэн өгөөжийг нь хүртэж чадах л тийм концепц л доо.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулах юм уу. Болчихсон уу. Асуулт хариулчихсан. Байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой” 34 хувийг ард түмэндээ өгөх тухай л асуудал л яригдаад байна л даа. Тэгээд яах вэ, бид онолынх нь талаасаа яривал их олон юм ярьж болох байх. Ер нь бол татварын дараах цэвэр ашигийнхаа 34 хувийг нь ард түмэндээ өгье. Үлдсэнийг нь төр авъя л гэсэн ийм л санаа байгаад байгаа юм. Ер нь бол яг агуулга талаасаа харах юм бол. Тэгэхээр 34 хувьдаа ноогддог үр өгөөжөө дээшлүүлэхийн тулд ёстой нөгөө компанийн засаглал менежментийн чинь юм яригдана. Тэгэхээр энийг наад тогтоолоор чинь гэдэг юм уу, дан ганц Баялгийн сангийн хуулиар бид хийж чадахгүй. Тэгэхээр тэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай асуудал, тэр өмчит компаниудынхаа хуулийг бид боловсронгуй болгохгүйгээр энэ асуудлыг ярих боломжгүй. Тийм учраас үүнийгээ би харин Засгийн газрыг маш яаралтай оруулж ирэх ёстой гэж ингэж ойлгоод байгаа. Нэг ингээд харахаар зэрэг олон нийтийн засаглалтай болгоод байгаа юм шиг харагдаад байгаа боловч оролцоо хангагдах боломжгүй олон нийтийн

засаглал байгаад байгаа байхгүй юу. Наадах чинь. 3.0 хэдэн сая хүндээ 1072-оор төлөөлүүлсэн хувьцааны эрх олгохоод ч байгаа юм шиг ингэж харагдаад байдаг. Тэгээд тэр 3 мянга хэдэн хүнийг чинь ямар зарчмаар, хэчнээн хүн яаж шалгуур юм хангаж гарч ирж төлөөлөх юм гэдэг асуудлаа тодорхой болгоогүй учраас наад компанийн чинь засаглалын менежментэд оролцох боломжгүй, бас тодорхой хэмжээний үр өгөөжөө дээшлүүлэх чиглэл дээр оролцох боломж нь хязгаартай ийм болчихоод байгаа юм. Тийм учраас үүнийгээ их зөв харж хийх ёстой. Би бол харин тэр заяагдмал баялгийнхаа үр өгөөжөөс ард түмэн нь хүртэх ёстой гэдэг тэр үзэл номлол дээрээ тулгуурлаад энэ “Эрдэнэс Тавантолгой” хувьд 34%-ийг нь ард түмэн нь хүртдэг байх ийм боломжийг нь олгосон шийдвэрийн төслийг нь бол дэмжье. Энэ шийдвэрийн төслийг дэмжчихээр зэрэг цаана нь энэ үр өгөөжийг нэмэгдүүлж явахын тулд бид тэр компанийн засаглал сайжруулдаг иж бүрэн эрх зүйн зохицуулалтаа хийхгүйгээр энэ цаашаагаа явах боломж байхгүй. Энэ дээр та хэд ямар төсөөлөл, ямар ойлголт бариад байгаа юм бэ гэдэг нэг ийм асуудал байна.

2 дугаарт. Ер нь тэгээд хүмүүс хүртэх ёстой үр өгөөжөө хүртэж чадахгүй бол эргэлзээ үүсчхээд байгаа юм. Тийм учраас нэг тийм араншин муутай хүн шиг асуудал гаргаад байж боломгүй байна л даа. Нэг өдөр өгөхгүй гээд л, нэг өдөр өгнө гээд л ингээд л яриад байдаг. Ямар ч тохиолдолд өгөх юм гарсан юм бол өгдөг л байх ёстой. Тийм учраас энэ ноогдол ашигийн асуудлыг ингэж бөөгнүүлж өгдөг энэ тэр энэ юм руу оромгүй байгаа. Яг тодорхой тэр тайлант жилийнхээ цаглавраар юм чинь явдаг, тэрнийхээ үр дүн дээр тулгуурлаад өгдөг ёстой юмаа өгч чаддаг ийм баталгаатай эрх зүйн зохицуулалтыг хийж өгөхгүйгээр бид бас энэ үйл явц руу энэ олон нийтийн хяналт оролцоог хангах бололцоо боломж хязгаарлагдмал байгаад байгаа юм.



Үүнийг ер нь та нар юу гэж ойлгоод байна вэ. Уг нь энэ өмчийн хууль компанийн хуулиар чинь бол энэ чинь их л тодорхой л гэж ойлгоод байдаг юм шүү дээ. Тэгээд та хэд болохоор зэрэг гарч ирээд л энэ жил өгөхгүй ээ, шинэ том бүтээн байгуулалт хийх гэж байгаа энэ тэр гээд ярьдаг юм. Би ерөөсөө тэгж ойлгодоггүй шүү дээ. Тэр татварын дараах ашиг юмнууд нь орох ёстой газрууддаа орчхоод дахин хуваарилалтынхаа зарчмаар дараагийн бүтээн байгуулалтынхаа юм руу л чиглэгддэг л байх ёстой шүү дээ. Тэрнээс .../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Батжаргал даргын асуултад хэн хариулах вэ. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье. Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Таны хэлж байгаа тэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль давхар энэ Баялгийн сангийн хуультай бас өөрчлөлт орох шаардлага, ахиад бас шинэчилсэн хуулийн төсөл төслийн шатад явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр мэдээж уялдана. Ингээж уялдаж байж энэ ТӨК-уудын үйл ажиллагаа, засаглал бол сайжрах ийм учиртай. Ер нь яах вэ зүгээр Баялгийн сангийн хуульд яагаад тийм бүлэг оруулаад байна вэ гэхээр ер нь зүгээр энэ уул уурхайн компани ялангуяа энэ том хэмжээний үйл ажиллагаа явуулж байгаа стратегийн орд газар эзэмшиж байгаа компаниудын үйл ажиллагааг бол зайлиггүй энэ олон улсын энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг түрүүн тэр Батшугар гишүүний яриад байсан энэ Рио Тинто гэх мэтчилэн сайн засаглалтай групп компаниудын энэ засаглал руу оруулахаас өөр арга байхгүй. Тэгэхээр тэр зарчим руу л оруулсан тийм бүлэг орж ирж байгаа.

Түрүүний хэлдэг тэр ТУЗ дээр бол Компанийн тухай хууль дээр нь ч байж байгаа, төлөөлөл хэрэгжүүлэх журмын хувьд ч гэсэн Төрийн болоод орон нутгийн өмчийн тухай хуулийн

зохицуулалтаар явдаг ийм хязгаарлагдмал бас эрх зүйн харилцаа байгаа. Тэгээд мэдээж энэ хуулийн асуудлыг авч үзэхээр энэ асуудлууд нэг мөр яригдах учиртай. Яригдаж таараа.

Ноогдол ашиг гаргах шийдвэр бол бас Компанийн тухай хуулиар хуульчлагдсан. Хуульчлагдаад, ТУЗ шийдвэр гаргах эрхтэй. Тэгэхдээ ТУЗ шийдвэр гаргахдаа би бас тодорхой энэ удирдамж чиглэл авдаг хуулийн зохицуулалтыг би түрүүн асуултад хариулахдаа хариулсан байгаа. Тэгэхээр ер нь бол үндсэндээ таны тэр ноогдол ашигийг аль болох нэмэгдүүлдэг, ноогдол ашигаа бол яг хуулийн дагуу хуваарилдаг энэ тогтолцоог л бид нар хийхээр зорьж, нэлээдгүй 2022-2023 онд энэ “Эрдэнэс Монгол” нэгдлийн засаглалын шинэчлэлийн хүрээнд бол байнга л ийм зүйл яригдаж байгаа. Тодорхой ажлууд бас хийгдээд явж байна. Тэгэхээр ер нь түрүүн бас би Доржханд гишүүний асуултад хариулахдаа хариулсан. Нийгэм, эдийн засгийн чухал төслүүд бол энэ компанийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдэх чиглэлээр яг тодорхой ийм хууль, эрх зүйн тогтолцоог нь бий болгож өгөхгүй болохоор л энэ буруу зүйл рүү орчхоод байгаа юм. Ингээд л нэг удирдамж ирээд л энэ жил ноогдол ашиг хуваарилахгүй, ийм төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулна гэдэг. Тэгээд энэ бол өөрөө тогтолцоо өөрөө тийм сайн тодорхой болж өгөхгүй байгаа учраас л ийм зүйлүүд гараад байгаа учраас л бид нар энэ 1072 хувьцаагаа ингээд бас зэрэмдэглэчихсэн. Энийгээ цэгцлээд энэ компанийн засаглал юмаа сайжруулж үйл ажиллагаагаа.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Та тодруулах уу. Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

**Ж.Батжаргал:** Тэр энэ дэлхийн энэ заяагдмал баялаг дээр тулгуурлагдсан том компаниудын сайн засаглалын менежментийг бид

нэвтрүүлэх ёстой. Үүнийг одоо тэр шинэ бүрдүүлэх гээд байгаа эрх зүйн орчиндоо бид хийхээс өөр арга байхгүй. Гэхдээ энд нэг их том хөдлөл үүсэхгүй юм байна лээ. Одоо Монгол Улсын хүн амын өсөлт чинь 1,4-тэй л яваад байгаа шүү дээ. Энэ тэгээд цаашаа 1,4 нэмэгдэхгүй. Би бол ойлгож байна. Тэгэхээр зэрэг ер нь маш бага хөдлөл үүсэж байгаа байхгүй юу. Цэвэр өсөлтөөрөө л наад хувьцааны чинь дүн өөрчлөгдөх л асуудал байгаа. Тийм учраас энэ чинь бол бид нар энэ байгалийн баялгийнхаа үр өгөөжийг иргэддээ хүртээдэг арга механизмыг л ийм хэлбэрээр сонгосон болохоос биш яг нарийндаа тэр үнэт цаас гэдэг зах зээлийнхээ нийгмийн онолоор хийчхээгүй шүү дээ бид нар яг нарийндаа энийг чинь. Тэгэхээр үүнийгээ их зөв бодож, эрх зүйн зохицуулалт талдаа авч харах ёстой болов уу гэж. Би ингэж.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Үг хэлчэв үү та. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Өмнө нь бид нар “Эрдэнэт”-ээс л харахад зэс гээд л, алт гээд одоо бол нүүрс гээд нээрээ Монгол улс маань ямар ч их баялагтай юм. Харамсалтай нь тэр нь яаж, ямар схемээр гарын салаагаар урсдагийг нүүрсний сонсгол бол бас олон түмэнд ил харуулж өгч байна л даа. Гэтэл энэ баялгийн эзэн ард иргэд маань авах ёстой хувьцааныхаа ашигийг авч чадахгүй. Учир нь яасан нөгөө “Эрдэнэс Тавантолгой” маань ашиггүй ажиллаж байгаа юм уу, эсвэл алдагдалтай байгаа учраас энэ дараа нь ашигтай ажилласан тохиолдолд өгнө гэдэг юм уу, тэгээд иргэдэд өгөх хувьцаа нь ноогдол дээр нь болохлоор ингэчихдэг. Гэтэл тэр хуйвалдаан хулгай буруу гараар явж байгаа нүүрсний жишээлбэл зүгээр нүүрс дээр л харахад асар их байна шүү дээ. Энэ гол нь юу байна гэхээр нөгөө эрх мэдэлтэй эсвэл нэг бүлэг хүмүүс эсвэл мэдээлэлд ойрхон байдаг ч гэдэг юм уу нэг ийм зүйлүүд байна. Тийм учраас үүний крантыг хаахын тулд л өнөөдөр

бид нар бас энэ нүүрсний сонсгол, яг энэтэй бол тэмцэж байна. Түүрүүн Ганбаатар сайд бол бас үнэн хэлж байна. БЭТ томилогдсоноос хойш л зүгээр аваад үзэхэд “Эрдэнэс Тавантолгой” компани нь экспортлож байгаа нүүрсний орж ирж байгаа орлого нь валютын нөөцийг жишээлбэл өнөөдөр 4,5 тэрбум ам.доллар хүрэхэд хүргэж байна шүү дээ. Тэгэхээр яасан их юм бид хулгайд алдсан юм бэ гэдгийг зүгээр харж болно. Одоо тэгээд бид нар энэ “Эрдэнэс Тавантолгой” компаниас дандаа ингээд жишээлбэл, зүгээр л 2013 оноос хойш аваад үзэхэд дандаа ингээд сорчлоод л олборлолт явагдаад байна. Тэгээд тэр нь сорчлоод олборлолт явагдсан. Тэр “Эрдэнэс Тавантолгой”-н оруулж байгаа, санхүүжүүлж байгаа төслүүд нь ихэнх нь эдийн засагт ашиггүй, эдийн засгийн ашиггүй, эдийн засагт үр өгөөжөө ойрын хугацаанд, дунд хугацаанд л өгөх нь бараг баталгаагүй тийм юмнуудад санхүүжилт хийгээд явчихсан. Өчигдөр тэр Богд хаан төмөр замын тухай бид нар ярилаа. Нөгөө сайжруулах түлш дээр овоо гайгүй нийслэлийн 2019-2020 оны өвөл утаа 40% буурчихсан байсан чинь энэ бас гайгүй юм байна. Энийг сайжруулъя гээд баяжуулах үйлдвэр барья гээд өчнөөн тэрбум төгрөг их наядоор нь шүү. Нөгөө тэрбум гэдэг нь бараг доллароор яригдах хэмжээний санхүүжилт, дэмжлэг үзүүлье гэсэн яасан дундаас нь хулгайл лаад идчихсэн байх жишээтэй юмнууд байна шүү дээ. Эргээд нөгөө гайгүй болж байсан утаа буцаад бүр хоржоо чанартай болоод гараад ирдэг ийм зүйлүүд байгаад байна. Тийм учраас одоо Ганбат дарга аа, одоо яг “Эрдэнэс Тавантолгой”-н ТУЗ-д байгаа хүмүүс манай энэ салбарын сайд нар маань “Эрдэнэс Тавантолгой” дээр үнэхээр эдийн засгийн үр өгөөжтэй ашигтай төсөлд л хөрөнгө оруулалт хийх. Үүний нэг нь жишээ бол ДЦС байх боломж үнэхээр харагдаж байна лээ шүү дээ. Гэтэл яг энэ чухал улс орны эрчим хүчний аюулгүй байдалд хүртэл чухал энэ төсөлд болохоор хөрөнгө гаргахгүй

ингээд зогсоочихсон. Тэгсэн хэр нь огт эдийн засгийн үр өгөөжгүй юм уу, эсвэл буцаж ашиг нь орж ирээгүй зүйлд зүгээр 60, 70%-аар нь санхүүжилт урьдчилаад нүүрсээрээ болоод мөнгөөр өгчихсөн зүйлүүд байгаад байна шүү дээ. Одоо энийг зогсоох хэрэгтэй байна. Тэгээд би ТУЗ-ийн дарга Ганбат даргаас, Наранцогт даргаас асуумаар байна. Одоо энэ 34%-ийг 2012 оноос хойш төрсөн иргэдээ бас энд хувьцаа эзэмшүүлэх 34%-ийг ижил тэгш хүртээх асуудал орж ирж байна. Энэ зөв. Энийг дэмжиж байна. Үүнээс гадна 2021 он, 2022 он, мэдээж 2023 он гээд ноогдол ашгийг хуваарилах тал дээр та бүхэн маань тооцоо судалгаа яаж хийж байна вэ. Энийг бол өгөх хэрэгтэй гэж бодож байна. Яагаад гэвэл одоо “Эрдэнэс Тавантолгой” сүүлийн 1 жил хагаст ямар ч байсан нэг тодорхой хэмжээгээр ашигтай ажиллаж байна. Мэдээж алдагдалтай төслүүдээ зогсох энэ тэр арга хэмжээнүүд авч байна. Энэ сонсголын дараа нэлээд хариуцлага болоод үйл ажиллагаа нь явах байх гэж би бодож байгаа. Тэгэхээр энэ дээр ингээд иргэд маань хүлээж байна шүү дээ. Би ноогдол ашгаа хүртэх юм сан. Гэхдээ бэлэн мөнгө тараа гэсэн үг биш. Ямар нэгэн механизмаар тэр үнэ ханинд нөлөөлчихгүйгээр зохицуулалт хийгээд ингээд явах бол бололцоо байгаа гэж харж байгаа. Үнэ ханишийн өсөлтийг та бүхэн маань харж байгаа байх. Гэтэл яг хүртэх ёстой иргэд маань ноогдол ашгаа хүртэж чадахгүй байгаад байдаг. Гэтэл тэр буруу замаар гарын салаагаар яаж урсаж байгааг та бид бүгдээрээ харж байна л даа. Тэгээд энд би хариулт авахыг хүсэж байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах вэ. Санжаагийн Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ манай нэгдлийн стратегийн орд газрыг эзэмшиж байгаа “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт” зэрэг компаниуд бол үнэхээр улсын эдийн

засагт бол их чухал хүнд ачааг үүрч байгаа. 2022, 2023 онд нэгдлийн хэмжээний үйл ажиллагаа засаглалын шинэчлэлийн жил болсон. Энэ шинэчлэлийн хүрээнд бол бид нэгдлийн болоод компаниудынхаа дүрмийн хүрээнд засаглал, үйл ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааг уялдаа холбоог сайжруулах чиглэлээр бол нэлээдгүй ажлууд хийгдсэн. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг 49 хувь болгосон. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг яг хараат бус байдлаар ажиллаж болгохуйц аль болох тийм сайн хүмүүсийг сонгон шалгаруулж авахыг ингэж хичээсэн байгаа. Таны хэлж байгаачлан үр дүн бол гарсан. Ганц жишээ хэлэхэд бол бид нар ноднингийн өдийд 1 сая төгрөгийн доллар хүмүүст өгдөг валютын нөөцгүй болчихсон ийм л хүнд байсан. Одоо энэ жил 1 жилийн хугацаанд бүрэн эрхт төлөөлөгч томилогдлоо. Шинэ баг удирдлагууд ажиллалаа. Өнгөрсөн 2023 онд бид 3,2 тэрбум долларыг улсын нөөцөд төвлөрүүлсэн байна. Тэгээд улсын нөөц нэмэгдсэнээр бас ямархуу өөрчлөлт гарч байгааг бүгдээрээ ингээд ойлгож харж байгаа байх гэж ингэж бодож байна. Энэ том төсөл хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад энэ алдаа завхрал гарч байгаа асуудал бол яг цаад үндэс нь бол хууль, эрх зүй тогтолцооны асуудал. Энийгээ бид ерөөсөө шинэчлэхгүй бол ялангуяа бол уурхайн компанийн энэ үйл ажиллагаа удирдлагын тогтолцоог зүгээр ингээд төрийн өмчит жижиг жишээлбэл зам арчлалтын АЗЗА-ай адилхан хууль, эрх зүйн тогтолцоогоор явуулахаар бол ямар ч боломжгүй. Шал өөр. Тэгэхээр энийгээ бол бид ямар ч байсан Баялгийн сангийн хуулийнхаа бүлэгт бол оруулж байгаа. Тэгэхээр энийг бол та бүхэн маань бас сайжруулаад дэмжихэд бас нэлээдгүй өөрчлөлт гарна.

Тэр төсөл хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт чухал төсөл хөтөлбөрийг Засгийн газар хэрэгжүүлдэг бас санхүүгийн механизм бий болгох ёстой. Тэгээд төслийн үнэлгээ, судалгааны

бүтэц маш муу явж ирсэн юм билээ. Тэгэхээр бид нар энэ шинэ бүтцийг бий болгоод бэхжүүлэх, төсөл хөтөлбөрүүдээ ер нь яг аж үйлдвэрийн гинжин хэлхээ хэлбэрээр үйлдвэр технологийн паркийн загвараар хийх ёстой гэдэг энэ концепцыг зарлаад, үүгээрээ ингээд явж байгаа. Тэгэхээр төсөл хөтөлбөрийн менежментийг яаж хийх тухай түрүүн би бас Доржханд гишүүний асуултад хариулахдаа тайлбарласан. Ингээд явах юм бол энэ төсөл хөтөлбөрүүд яг хэрэгтэй төсөл.../минут дуусах/

**Л.Мөнхбаатар:** Гүйцээгээд хариулчихъя. Ажлын хэсэг.

**С.Наранцогт:** Тэгэхээр яг зөв төсөл нь зөв менежментээр, зөв зардал, мөнгө ТЭЗҮ-ээр хийгддэг. Сайн төлөвлөгдөж хийгддэг гэсэн ийм сайн зүйл рүү орох ёстой. Энэ ажлыг бол бид нар эхлүүлээд хийж байгаа. Тэгээд тэр засаглал үйл ажиллагааны хувьд хууль, эрх зүй тогтолцоо сайжирчих юм бол бас энэ юм бол хамаагүй сайн болно. Мэдээж бас энэ хувь хүмүүсийн хариуцлагаас хамаарч байгаа асуудлууд бас гарсан байхыг үгүйсгэхгүй.

Ноогдол ашигийн хувьд бол бид ерөөсөө л түрүүн хэлсэн. Яг компанийн тухай хуульд заасан тэр ноогдол ашиг хуваарилах нөхцөл, тэр журам, зохицуулалт байгаа юм. Тэр зохицуулалтын дагуу л ТУЗ дээрээ шийдэгдэнэ. Цаашидаа яг л тэр хууль, эрх зүйнхээ хүрээнд ноогдол ашигаа яг тэр хууль, эрх зүйн зохицуулалтынхаа хүрээнд хуваарилаад л явах ийм зарчим баримталж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асууя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асууя.

**М.Оюунчимэг:** Та бүхэн маань мэдээж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах, дээрээс нь саяын хэлээд байгаа тэр менежментийн юм уу буруу бодлогын үүднээс эдийн засгийн үр

ашиггүй зүйлүүдийг хаах тэр эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байгаа гэж байна. Тэр дээр бү бүгдээрээ хамтраад энэ өөрчлөлтийг нь нэн даруй хийцгээе. Нөгөө нэг зүйлээс энэ сая тэр бага орон нутгийн Тавантолгой, одоогийн “Эрдэнэс Тавантолгой” нүүрс тээвэрлэлт, экспортыг харж байхад Цагаан хадан дээр ер нь асуудал нэлээд их байгаа юм байна шүү дээ. Тээвэрлэлт тойрсон татвар, гааль, татвараас зугтах ч гэдэг юм уу, эсвэл хямд үнээр тэнд авчхаад, цаашаа гаргаад үнэтэй зарах гээд бүх хуйвалдаан ер нь Цагаан хадан дээр явагддаг юм байна шүү дээ. Олон жил ингээд явж ирсэн байна. Цаашидаа Цагаан хадан дээр ингээд байх уу, үгүй юу. Ер нь энэ байх шаардлагатай юу гэдэг асуудлууд ч байгаа юм байна лээ шүү. Тэгэхээр цаашидаа та нар маань энэ дээр бас анхаараарай. Шаардлагатай эрх зүйн орчин зүйл байвал Их Хурал та нарыг дэмжээд ажиллахад бэлэн байна.

Тэгээд иргэдийнхээ хувь ноогдол ашигийг хуваарилах дээр бол шударга шуурхай ажиллаарай гэж хэлье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** “Эрдэнэс Тавантолгой” 34 хувийг Монголын ард түмэнд эзэмшүүлэх саналыг бол дэмжиж байгаа. Энэ асуудлыг 2022 оны 12 сарын 10-ны өдөр өөрөөр хэлбэл 1 жилийн өмнө Улсын Их Хурлын 5 гишүүн санаачлаад, Улсын Их Хурлын даргад өргөн барьчихсан байгаа асуудал. Хэлэлцэгдэхгүй явсаар байгаад өнөөдөр ингээд Засгийн газар оруулж ирж байна. Би энийг бол ойлгохдоо Монгол Улсын Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлагчийн хувьд бол энэ 5 гишүүний санаачилсан хуулийг энэ хуультай хамтарч хэлэлцэх нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа.



Сая Дэлхийн банкны гаргасан судалгаа байгаа л даа. Гаргасан байна лээ. Монголын ард түмний хүн амын 904 мянган хүн ядуу байна. Эдийн засгийн эрх чөлөөгүй байна гээд гаргачихсан. Энэ бол даруухан гаргасан тоо шүү. Энэ бол 1 сая орчим байгаа. Дээрээс нь ядуурах магадлалтай 15-ыг хасахаар 400-500 мянга. Ингээд Монголын ард түмний 1,4 сая хүн 3,5-ын 1,4 сая нь бол ядуу байна. Эдийн засгийн эрх чөлөөгүй байна. Ийм байхад нэг их ардчилал гэж бид цээжээ дэлдээд, их мундаг яагаад байх юм байхгүй шүү дээ. Энэ 2 шалтгаантай.

1 дүгээрт нь юу вэ гэхээр, төр засгийн алдаатай бодлого. 1990 он хүртэлх Монголын ард түмний бүтээсэн баялгийг хүн амын тэр малыг нь оролцуулаад 20 орчим хувь нь бол баялгийн эзэд болсон. Үлдэж байгаа 80 нь бол гудамжинд гарсан. Үүнээс эхлээд л энэ ажилгүйдэл, ядуурал гэдэг юм үүссэн. Дээрээс нь байгалийн баялгийн энэ менежментийг цөөхөн хэдхэн хүн аваад, ингээд ард түмэн ядуурах ийм л үндэслэлийг бий болсон. Энэ уул уурхайн салбар чинь ерөөсөө Монгол Улсад ажлын байрны 5 хувийг бүрдүүлж байгаа шүү дээ. Эдийн засагт маш том үүрэг гүйцэтгэдэг мөртөө ийм бага ажлын байрыг бий болгодог. Тэгээд энэ бол ийм алдаатай бодлогуудаас ийм асуудал үүссэн юм гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

2 дахь асуудал нь бол энэ зах зээлийн нийгэмдээ бид хүнээ бэлдээгүй. Яаж амьдрах ёстой юм. Ажил, хөдөлмөр хийж амьдардаг. Энэ бол хүнээ бэлдээгүй төр засгийн алдаатай бодлогоос үүссэн гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Энэ “Эрдэнэс Тавантолгой”-н 34 хувь бол тэр Баялгийн сангийнхаа хуультай нягт уялдаж явах ёстой шүү. Бид нар тэр Норвегийн Сан, Тимосект ер нь тэгээд тэнд дахиж хүн очиход бараг ичмээр шахуу болчихсон. Маш олон мянган хүн очоод үзчихсэн байдаг юм гэнэ лээ шүү. Тэгээд хийсэн ажил байхгүй. Энэ Ирээдүйн өв сан дээр гарсан алдааг бол энэ дээр давтаж болохгүй шүү.

Ирээдүйн өв санд бол 2,7 их наяд төгрөг хуримтлуулж чадсан нь бол сайн хэрэг. Менежмент байхгүй. Тэр корпорацаа байгуулаагүй, тэр мандат гэдэг нь бол тэнгэрийн юм аваачаад тавьчихсан. Монголбанкандаа удирдуулаад явах боломж байтал энийг ашиглаагүй. Тэгээд одоо юу гэнэ ээ, 2025 он, 2030 он хүртэл хөдлөхгүй гэж. Зөвхөн 2020 онд ханишийн алдагдлаар 800-аад тэрбум төгрөг алдчихсан байгаа шүү дээ. Өнөөдөр нүүрсний хэдэн төгрөг орж ирээд, ханиш тогтвортой байна. Цаашидаа яах юм. Яг ханиш ингээд цаашаа унана шүү дээ мэдээж. Надад байж байгаа тооцооллоор бол ханиш цаашаа унана. Монгол төгрөгийн ханиш. Тэгэхээр ингээд л хадгалаад байх юм уу. Яагаад энийг эдийн засгийн эргэлтэд орж болдоггүй юм. Сая энэ Хаан банк ногоон бонд гаргаж байна шүү дээ. Энэ дээр бид нар бас оруулах боломжууд бол байна. Эндээс ганихан асуулт асууя. Энэ ер нь явж явж энэ компанийн засаглал. Сая энэ Тавантолгойн асуудлыг ярьж байхад л ерөөсөө л хулгай хийдэг хүмүүс л энд очдог юм байна. Тэгээд гөлөг төөрүүлэх үйл ажиллагаа гол хулгайчтайгаа ярьдаггүй. Тэгээд л нэг тийм жижиг сажиг юм яриад байгддаг. Энэ цаашидаа.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Багаагийн Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье. Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэн тэр баялгийн сан дээр Ирээдүй өв сантай холбоотой, тэрний удирдлагын асуудал гээд энэ бол Баялгийн сангийн хууль дээрээ таны ярьж байгаа концепцтой ер нь нийцэхүйцээр ингээд туссан явж байгаа. Түрүүн бас би олон удаа тайлбарлаад байгаа энэ уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмч давамгайлсан компаниудын засаглал, үйл ажиллагаа гэсэн бүлэг бол орж ирж байгаа. Энэ бол уурхайн компаниудын

засаглал, үйл ажиллагааг бол яг олон улсын энэ уурхайн болон энэ групп компаниудын сайн засаглал руу оруулахгүй л бол болохгүй юм байна лээ. Тэгэхээр энэ чиглэлээр бид нар бас судалгаанууд хийсэн. Энэ чиглэлээр ингээд хуулийн төсөлдөө тодорхой хуульчлахаар зааж өгч байгаа юм.

Тийм учраас энэ таны хэлж байгаа шиг янз бүрийн санамсаргүй хүмүүс орж ирэх боломжийг нь хаасан. Гүйцэтгэх удирдлага, ТУЗ, ер нь тэгээд компанийн үйл ажиллагаа засаглалыг бол ер нь яг тодорхой, ил тод олон улсад тавигддаг сайн засаглалын хэлбэрт шилжүүлэх ийм л хууль, эрх зүйн орчныг бий болгож байж энэ зүйл сайжирна. Тэгэхээр энэ чиглэл рүүгээ ажил бол явж байна. Одоо бол бид юу хийж байна вэ гэхээр “Эрдэнэс Монгол” нэгдлийн шинэчлэлийн хүрээнд бол толгой компанийн дүрмийг Засгийн газраас 3 удаа өөрчилсөн. Яг энэ өөрчлөлтийнхөө дагуу харьяа, охин 15 компанийн дүрэмд бол өөрчлөлт орсон. Баялгийн сангийн хуулийг дагалдуулаад бас манай нэгдэлд байгаа том компаниудыг бас нэг стандартад оруулах ийм тодорхой ажлууд бас хийх шаардлагатай. Хууль, эрх зүйн хувьд шийдвэр гаргах Их Хурал дээр ч шийдвэр гаргах ийм шаардлагатай зүйлүүд байгаа. Тэгээд энэ ажлууд цэгцлэгдэж байгаагийн л бас нэг хэсэг нь энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулахад энэ 1072 хувьцааг нэг мөр ингэж цэгцэлж авах ажил хийх шаардлагатай байгаа юм. Тийм учраас л өнөөдөр энэ тогтоол орж ирж байна. Энэ тогтоол бол энэ ажлын л нэг хэсэг нь гэж ингэж ойлгох ёстой. Баярлалаа

**Л.Мөнхбаатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор. Одоо Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Дараа нь Энхтүвшин гишүүн. Хассуурийн Ганхуяг гишүүний микрофоныг өгөөрэй.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд хүргэе ээ. Ямар ч байсан “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотойгоор бол энэ сүүлийн 1 жил Засгийн газар бол сайн ажилласан. Оюун-Эрдэнийн Засгийн газар. Бас мөн сайдууд нь сайн ажилласан. Хүрэлбаатар сайд, Ганбаатар сайд. Яах вэ, энэ дээр нүүрсний сонсголыг сонсоход бол бас хэд хэдэн асуултууд гарч ирчхээд байгаа юм л даа.

1 дүгээр асуулт болохоор ингээд 5,2 сая тонн нүүрс бүртгэлгүй гарчихсан гээд байгаа юм. Тэгээд энэ компаниас бүртгэлгүй гарчихсан юм уу, аль эсвэл хилээр бүртгэлгүй гарчихсан юм уу гэдгийг тодруулж авчихмаар байна.

2 дугаар асуудал бол ноогдол ашиг тараахыг бол дэмжиж байгаа юм. Би угаасаа 2021 онд ч байр сууриа илэрхийлж байсан, 2022 онд ч байр сууриа илэрхийлж байсан. Гэхдээ нэг асуудал юу байна гэхээр одоо нүүрсний сонсголттой холбоотойгоор ингээд хараад байхаар бид нар энэ засаглалын асуудлаа эргэж харахгүй бол яг одоогийнх шиг ийм хаалттай хэлбэрээр яваад байвал дараа дараагийн ямар ч гүйцэтгэх захирал томилогдсон бай энэ асуудал дахиад л гарч ирэхээр юм шиг харагдаад байгаа юм л даа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулахгүйгээр тийм том хэмжээний хөрөнгө оруулалтууд, тийм том хэмжээний худалдан авалтууд компанийн хуулиараа хориотой байхгүй юу. Тухайн компанийн дүрмийн сангаас 25-аас дээш хэмжээний худалдан авалт хийж байгаа тохиолдолд заавал ч үгүй Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ордог. Тэр хувьцаа нь давуу эрх байна уу, юу байна. Хамаагүй. Тэгэхдээ энэ чинь олон нийтэд нээлттэй байх ёстой. Тэгэхээр одоо тэр ярьж байгаа төмөр замын асуудал байдаг юм уу, эсвэл бусад энэ том том тендерүүд бүгдээрээ олон нийтэд нээлттэй явагдах ёстой байсан.

Тэр Үндэсний аюулгүйн зөвлөлөөс яасан ийсэн тэр ерөөсөө ямар ч хамаагүй. Энэ бол энэ компанийн хөрөнгөөр худалдан авалт хийж байгаа байхгүй юу. Энэ компанийн хөрөнгөөр. Тэгэхээр энэ асуудлаа эргэж харах ёстой байна. Тэрнээс ч биш одоо ингээд бид нар чинь ингээд БЭТ тавьж л тухайн компанийн засаглалыг ингээд өөрчлөөд байна л даа. Сайжруулаад. Цаашидаа бол ер нь яах юм. Одоо ингээд байнгын жил болоод л шинэ БЭТ тавиад л, жил болгоод л шинэ БЭТ тавиад яваад байх юм уу. Аль эсвэл одоо Удирдах зөвлөлөөс ТУЗ-өөс тухайн захирлыг нь нэг бол олон нийтэд нээлттэйгээр сонгон шалгаруулалтыг нь хийх юм уу, эсвэл одоо яг олон нийтийн парламент дээрээ сонсголд оруулж томилдог байх ийм зарчим хэрэгжүүлмээр байгаа юм.

3 дугаарт эрх зүйн орчин дээрээ Төрийн өмчит болон орон нутгийн өмчийн тухай хууль орж ирчихсэн, тэгээд ингээд гацчихсан. Хэлэлцэгддэггүй. Ерөөсөө л төрийн өмч байвал 1 дүгээрт бол төр бол ашгийн төлөө явдаг компанийнхаа тоог аль болох цөөлөх хэрэгтэй. Ашгийн төлөө явдаг хэрвээ компани байвал олон нийтийн хяналтад оруулах ёстой. Одоо ингээд давуу эрхийн хувьцаа ингээд бид нар өгчихлөө. 34% гээд өглөө гэж бодъё. Саналын эрхгүй шүү дээ. Саналын эрх байхгүй. Тэгэхээр бид нар энэ хүмүүсийн яриад байгаа о тэр хувьцаат болго, IPO хийе гэж яриад байгаа ерөөсөө шалтгаан нь юу вэ гэхээр тэр ТУЗ-ийн 3,2 буюу дийлэнхийг нь хараат бус гишүүдээр томилдог болох зарчим бид нар хэрэгжүүлмээр байгаа юм. Хэрэгжүүлмээр байгаа юм. Тэгээд гүйцэтгэх захирлын гүйцэтгэх удирдлагыг нь энэ парламентаар орж ирж хэлэлцдэг л байхгүй бол яг одоо манай Монголын эдийн засгийн 40-50 хувь яг л нүүрснээс хамааралтай. Энэ компаниас хамааралтай байхгүй юу. Тэгээд энэ компанийн засаглал өөрөө хаалттай, шилэн биш, аль нэг байгууллагын зөвлөмжөөр хөрөнгө

оруулалтын шийдвэрээ хийгээд, гаргаад яваад байвал энэ засаглалын асуудал ерөөсөө хэзээ ч шийдэгдэхгүй. Энэ хулгайн асуудал шийдэгдэхгүй.

2022, 2023 оны ашиг бол нэлээн сайн дүнтэй гарсан юм байна лээ. Тэгэхдээ одоо ингээд давуу эрхийн хувьцаа олгочихлоо гэж бодъё. Цаашидаа жил болгон ноогдол ашиг тараах юм уу.

2 дугаар асуудал. Яг ашгийнх нь хэдэн хувийг жил болгон ноогдол ашигт ер нь тараадаг болох юм.

**Л.Мөнхбаатар:** Хариултаа аваад, та тодруулчих. Санжаагийн Наранцогт дарга хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофон өгөөрэй.

**С.Наранцогт:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Тэр сонсгол дээр яригдаад байгаа гаалийн бүртгэлгүй гарсан 5,9 сая ч байна уу тонн нүүрсний асуудал яригдаад байна лээ. Тэрийг энэ компанийн түвшинд мэдэхгүй байгаа. Яагаад гэвэл тэр 1 дүгээрт хууль хяналтын байгууллага шалгагдаж байгаа. Тэр дүгнэлтийг бол тэр сонсголын шинжээчид гаргасан юм болов уу гэж ингэж ойлгосон. БЭТ томилогдохоос өмнө “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрс бол ер нь ам нөхцөлөөр зарагдаж байсан. Тэгэхээр компани дээрээ бол хэдэн тонн нүүрсийг ямар компанид амнаасаа ачуулсан гэсэн баримтууд нь бол мэдээж бүгдээрээ байж байгаа. Тоо хэмжээтэйгээ. Тэр нүүрс нь замдаа Цагаан хад дээр хэд нь буугаад, цаашаа хэд нь хилээр гарсан гэдэг асуудлын л тэр зөрүү юмнууд яригдаад байх шиг байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр тэр бол бид нарын хувьд мэдэхгүй байна.

Засаглалыг сайжруулах тал дээр бол тантай санал нэг байгаа. Тийм ч учраас би өглөөнөөс хойш дахин дахин ярьж байна. Энэ компанийн тухай төрийн өмчийн оролцоотой төрийн өмч

давамгайлсан энэ уул уурхайн компаниудын хувьд бол Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтын хүрээнд яваад байгаа. Тэгэхээр ер нь яах вэ, энэ уул уурхайн энэ стратегийн ач холбогдолтой том ордуудыг эзэмшиж байгаа томоохон хэмжээний үйл ажиллагаа явуулж байгаа, энэ үйл ажиллагаа нь баялгийн сантай холбогдож байгаа. Энэ үйл ажиллагаанаас орсон орлогын үр өгөөжийг Үндсэн хуулийн 6.2-т орсон өөрчлөлтийн дагуу одоо ирээдүйн иргэдийг тэгш шударга хүртээх энэ зарчмыг хэрэгжүүлэх гэсэн энэ утгаараа бол ингээд Баялгийн сангийн хууль дээр бүлэг болж оруулж ирэх нь зохимжтой байна гээд төсөлдөө бол бид оруулчихсан. Яг энэ дээр ил тод байдлыг хангах, таны ярьж байгаа энэ ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг яаж сонгон шалгаруулах, ямар шаардлага тавих, энэ зүйлүүдийг ингээд эрх зүйн орчныг бол тодорхой болгож өгье гэж байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл хэлэлцэгдэх үед бас та саналаа хэлээд, сайжруулах зүйлүүд бол гарах байх. Ийм байдлаар бид нар явж байгаа. Тэгэхээр мэдээж энэ Баялгийн сангийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, тэгээд Ашигт малтмалын хууль гээд энэ хуулиуд бол хоорондоо үйл ажиллагааны зохицуулалтын хувьд бол нийцэх ёстой. Тэгж нийцүүлэх байх гэж ингэж бодож байна.

Ноогдол ашигийн хувьд бол бид нар Компанийн тухай хуулийн зохицуулалтын хүрээнд л ноогдол ашиг хуваарилна. Та сая бас хэлсэн. Энэ 2023 оны хувьд бол бид нар үйл ажиллагааны хувьд нэлээдгүй сайжирсан учраас ноогдол ашиг хуваарилах бололцоо гарах байх. Тэгэхдээ энэ мэдээж Компанийн тухай хуульд заасан тэр хууль, эрх зүйн хүрээндээ тэр шаардлагыг нь биелүүлэх журмаар л хуваарилагдана.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу. Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Би хоёрхон асуулт л тодруулъя. 1 дүгээр асуулт болохоор төрийн өмчид оногдож байгаа ноогдол ашигаар ер нь юу хийгдэх вэ. Ямар хэмжээтэй ноогдол ашиг тараах тухай төсөвт суусан эсэх. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт болохоор ингээд өмнөх ерөнхийлөгч тэр Женко гээд нөхөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гаргасан юм байна. Хөрөнгө оруулалт хийгээч ээ гэдэг. Тэр нууцаар гарсан байж болно. Гэхдээ яагаад хувьцаа эзэмшигч нарт энэ талаар мэдээлэл өгөөгүй вэ. Ийм төсөл, ийм хэмжээний хөрөнгө оруулалтаар хийх гэж байна гэдэг. Энийг одоо компанийн хуулиар би хэлээд байна шүү дээ. 25%-аас хэтэрч л байвал хувьцаа эзэмшигч нар бүгдээрээ мэдэх ёстой юм. Бид нар бүгдээрээ хувьцаа эзэмшиж байгаа. Тэгээд энийг бүр ингээд өнгөрснийх нь дараа хэдэн жилийн дараа мэдэж байгаа байхгүй юу. Энэ 2 дээр хариулт авчихъя.

**Л.Мөнхбаатар:** Хассуурийн Ганхуяг гишүүний тавьсан 2 асуултад хариулъя. Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Ноогдол ашиг хуваарилах, яг ямар хэмжээгээр хуваарилах. Нэгдлийн компаниудын өөрсдийн үйл ажиллагаа, өөрсдийнхөө үйл ажиллагаа, өөрсдийнхөө нэгдсэн стратеги төлөвлөгөөг ямар байдлаар хэрэгжүүлэх вэ гээд энэ бүх заалтыг бол Баялгийн сангийн хуулийн төсөл дээр нарийвчлан тоо хэмжээтэй нь бид нар бүр оруулчихсан байгаа. Тэгэхээр энийг нөгөө Улсын Их Хуралд Засгийн газраас өргөн баригдах үед бол та бүхэнд тодорхой танилцуулагдаад, хэлэлцүүлгийн үед бол ингээд яригдаад явна гэж ойлгож байгаа юм.

Энэ дээр нэг зүйлийг онцолж хэлэхэд энэ хууль дээр ялгаагүй ингээд



ард иргэдэд баялгийн сангаар дамжих, хуваарилагдах хувь хэмжээ гарна. Дээр нь нэмээд Засгийн газарт хөгжлийн санд энэ нийгэм, эдийн засгийн том төслүүдээ хэрэгжүүлэх санхүүгийн механизмыг мөн энэ Баялгийн сангийн хуулиар бүрдүүлж өгөх юм. Өмнө бол ийм механизмгүй л байгаад байгаа учраас ганц мөнгө олж байгаа компани дээрээ нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолтой гээд ингээд бас төслийн судалгааны үнэлгээ, чадавх нэгж бас нэлээн сул байсан. Энэ үед бас янз бүрийн төслүүдийг ингээд жоохон мөнгө олж байгаа компани руугаа шахаад ийм алдаа завхралууд бол гарсан байна гэж дүгнэж байгаа. Тухайн үеийн тэр зөвлөмж юм нь бол мөн л ялгаагүй Компанийн тухай хуулиар 1 дүгээрт нууцын тухай хууль яригдах юм шиг байгаа юм. Тэгээд тухайн үед нөгөө хувьцааны эрхийг ер нь хувьцаа эзэмшигч Засгийн газар хувьцааны эзэмшлийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдээрээ дамжуулаад бас ТУЗ-д бол нууцын журмаар удирдамж өгч, ингээж хэрэгжсэн төслүүд гэж ингээж ойлгож байгаа.

**Л.Мөнхбаатар:** Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Энхтүвшин гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимд байраа эзэлье.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Засгийн газраас оруулж ирж байгаа энэ тогтоолын төслийг дэмжиж байна. Ялангуяа “Эрдэнэс Тавантолгой” компанийн 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр үнэ төлбөргүй эзэмшүүлэх тогтоолын төслийг бол дэмжиж байгаагаа хэлье.

Энэ 3 дахь заалт дээр бол байгаад байгаа нас барсан иргэний хувьцааг өвлүүлэх, үр хүүхдэд нь үлдээх ийм зүйл ер нь байж болдоггүй юм уу. Бид нар 10 гаруй жилийн өмнө л Монгол Улсын иргэн болгон 1072 хувьцаатай болсон. Үүнээс хойш ноогдол ашиг авахгүй байж байгаад хорвоогийн мөнх бусыг үзсэн

маш олон хүн байж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг өвлүүлэх ийм асуудал бас байж болдоггүй юм уу. Энэ дээр бас та бүхэн маань ямар бодолтой байдаг юм бэ гэдгийг асууя.

2 дахь асуудал бол энэ засаглалыг сайжруулах тал дээр гишүүд болгон л ярьж байна л даа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиа бид нар нэг эргэж харах ёстой юм байна. Төрийн өмчтэй компаниудынхаа тухай хуулийг шинээр яаралтай оруулж ирж, батлуулах ёстой юм байна гээд. Нүүрсний үнэ өндөр үнэтэй байж байна. Нүүрсний үнэ өндөр үнэтэй байж байхад бид нар уг нь болдог бол энэ “Эрдэнэс Тавантолгой”-нхоо 10 юм уу, 15 хувийг гадаадын бирж дээр өндөр үнээр зараад, мөнгө босгох л хэрэгтэй байна даа. Мөнгө босгоод энэ томоохон төслүүдээ эхлүүлэх, аль болохоор бид нар тэр оффтейк гэрээ хийж, нүүрсээ урьдчилж өгөхөөсөө илүүтэй 5 юм уу 10 хувийг нь гаднын бирж дээр босгоод, зараад, ингээд хөрөнгө оруулалтаа хийгээд явбал илүү их бололцоо боломж бас байгаад байгаа юм болов уу гэсэн ийм бодолтой байгаад байна.

Тэгээд 66% нь төрд байгаад, тэгээд ТУЗ нь өөрөө төрийн өмчөөс төрийн байгууллагаас томилогдсон ийм байх юм бол хэзээ ч олон нийтийн болж чадахгүй л дээ. Тэгээд энэ засаглал дээрээ бид нар нэг эргэж харвал яасан юм бэ гэдэг дээр. Тэгээд ард иргэд маань энэ хувьцаагаа зарж үрэх, борлуулах, хувьцаат компанийн чинь ерөөсөө л бүрэн эрх нь тэр шүү дээ. Тэр эрхийг нь нээж өгвөл яасан юм бэ. Тэгээд зарахгүй байсаар байгаад түрүүний миний хэлдгээр хорвоогийн мөнх бусыг үзэж байгаа хүмүүс зөндөө байна шүү. Тийм бололцоо боломжийг нь бид нар нээгээд өгвөл яасан юм бэ. Ингээж байж юу гэдэг юм хувьцаат компани үйл ажиллагаагаа бас явуулах нь зүйтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байж байна.

Тавантолгойн асуудал дээр түрүүн Наранцогт даргын хэлдэг бас зөв л дөө. Бид нар Үйлдвэр технологийн паркийн тухай хууль гаргасан. Аль болохоор бид нар энэ Тавантолгой тойрсон энэ эдэлбэр болон Тавантолгой газруудаа улсын тусгай хэрэгцээнд аваад, ингээд дэд бүтцийг нь хөгжүүлээд бүх үйлдвэрийг нь байгуулаад, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн боловсруулах ийм үйлдвэрүүдээ байгуулаад ингээд явбал илүү их бас үр дүнтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байж байна. Тэр хуулийн хэрэгжилтийг бас хангаж ажиллах талаар бас та бүхэн маань бас ямар бодолтой байгаа вэ гэдэг дээр бас хэлмээр байна.

Дараагийн асуудал бол БЭТ томилогдоод бас тодорхой юм сайжирсан. Үнэхээр бас сайжраад, ялангуяа энэ бичиг баримтын асуудал, ялангуяа энэ урд байсан өр, авлагын асуудал, урдах гэрээний асуудал гээд цэгцэлж байгаа юм зөндөө юм байж байгаа. Одоо бид нар юун дээр анхаарах ёстой вэ гэхээр ерөөсөө “Эрдэнэс Монгол” компани бол цаашидаа энэ олон компаниудыг ингэж нэгтгэж удирдаж явж байснаас Монгол Улсын Засгийн газар, Монгол улс өөрөө энэ цемент үйлдвэрлээд яах юм бэ. Цементийн зөндөө үйлдвэр байж байна. Хөтөлийн цемент шохойныхоо үйлдвэрийг бид нар IPO хийгээд яаралтай хувьцааг нь борлуулдаг юм уу, яадаг юм. Хөрөнгө босгох энэ ажлыг бас зохион байгуулах хэрэгтэй байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр гээд байж байна. Одоо төмөрлөгийн үйлдвэр бол ерөөсөө л ингээд л түүхийгээр нь зараад байж байгаа шүү дээ. Энийг IPO хийгээд, хувьцааг нь олон нийт ч юм уу гадаадын, дотоодын биржээр зараад ингээд тодорхой хэмжээний хөрөнгө босгоод тэр гангийн үйлдвэрийг нь баривал яасан юм бэ гэж. Монголросцветмент нэгдэл байж байна бид нарт. Маш олон Монгол жоншны баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүд байж байна. Энийг бас олон

нийтийн болгох энэ тал дээрээ л бид нар жосоохон ахь.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Санжаагийн Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ нас барсан иргэдийн хувьцааг өвлүүлэх, хувьцааг зарж борлуулах эрхийг нь хангавал яасан юм бэ гээд та ярьсан. Тэгэхээр энэ хувьцааг өөрөө анхнаасаа гарахдаа Тавантолгой компанийн үр ашгийг л ард иргэддээ эрх тэгш хүртээе гэсэн зорилгоор яг тэр сонгодог хувьцаа биш ийм хаалттай 1072 хувьцааг эзэмшүүлсэн юм билээ. Тэр утгаараа энэ ингээд хаалттай хязгаарлагдмал эрхтэй хувьцаа. Гол агуулга нь бол энэ Тавантолгойн ноогдол ашгаас л ард иргэддээ ингээд бэлэн мөнгөөр хүргээе гэсэн ийм агуулгатай гарсан. Тэр агуулгаараа яваад байгаа юм. Тэгээд би түрүүн хэлсэн. Ингээд 2010 оноос хойш 16 Засгийн газар, Их Хурлын тогтоол гараад ингээд 2 сая 500 иргэн хувьцаа эзэмшдэг 1072. 1 сая 218 мянган иргэн хувьцаа эзэмшдэггүй болчихсон ийм зэрэмдэг зүйл болчихсон байгаа учраас энийгээ ингээд цэгцлээд авъя. Энэ компанийн нөгөө үйл ажиллагаа, засаглал, таны ярьж байгаа зүйлийг сайжруулж явж байгаа ажлын нэг хэсэг. Ер нь бол компанийн үйл ажиллагаа, засаглалын талаар би бас нэлээдгүй ярилаа. Өглөөнөөс хойш. Энийг бол Баялгийн сангийн хууль дээр бүхэл бүтэн бүлэг болоод оруулаад, яг олон улсын тэр сайн засаглалын ийм хэлбэрт нь шилжүүлэх ийм зүйл хийгдээд явж байна.

Тэр боловсруулах үйлдвэр олон компанийн талаар бол та их зөв асуулт асууж байна. Тэгэхээр энэ харин ч энэ яг нэгдлийн хэлбэртэй төсөл хөтөлбөрийн менежмент, төслийн үнэлгээ судалгааг хийгээд ингэж хийхгүй бол тус тусдаа нэг төсөл хөтөлбөр ТЭЗҮ юм, аж үйлдвэрийн гинжин хэлхээгээ тооцолгүй ер нь олон юмыг тооцоогүй ингээд нэлээн төслүүд явсан учраас буруу ч төслүүд

хэрэгжсэн, сайн төслүүд ч хэрэгжээгүй юм байна лээ. Тийм учраас бид нар яаж явж байгаа вэ гэхээр Эрдэнэт, Дархан, Хөтөл, Багануур, Бор-Өндөр, Тавантолгой гэсэн 6 аж үйлдвэрийн паркийн загвараар энэ үйлдвэр технологийн цогцолборыг барих ийм чиглэлээр бодлого гараад явж байна. Энэ нь яах юм гэхээр ерөөсөө аж үйлдвэрийн үндсэн түүхий эдийг л ТӨК үйлдвэрлэнэ. Дэд бүтцийг тавьж өгнө. Үндсэн нөөц баялаг нь тэнд байгаа учраас. Тэгээд хувийн хэвшилд бүр талбайнуудын төлөвлөлтөд хийчихсэн. Хувийн хэвчлүүд энэ дээр ирж боловсруулах үйлдвэрүүдээ барина. Тухайлбал ган хайлгуулах, гангийн бэлдэц бол аж үйлдвэрийн үндсэн түүхий эд. Энийг зөвхөн Дархан төмөрлөг дээр зөвхөн ган бэлдцээ л бид нар үйлдвэрлэж өгнө. Тэгэхээр энийг бол эцсийн бүтээгдэхүүн хийдэг хувийн хэвчлүүд хөрөнгө оруулагчид орж ирээд, тэд нарт бол маш том боломж бий болно. Ган бэлдцээ бид нараас манай ТӨК-аасаа аваад дэд бүтэц, газраа ашиглаад үйлдвэрээ барих юм бол эцсийн бүтээгдэхүүнээ хийгээд явах ийм асар их олон боломж байгаа юм байна лээ. Бусад үйлдвэрүүдийн хувьд ч гэсэн энэ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Энэ оруулж ирж байгаа хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Гэхдээ бид нар бол энэ том орд баялгуудаа Монгол Улсынхаа эрх ашиг, ард түмний сайн сайхан аж байдлыг дээшлүүлэхэд яаж үр өгөөжийг нь ашиглах вэ, гаргах вэ гэдэг дээр л бид бүх бодлого, сэтгэл санаагаа зориулж ажиллах ёстой юм. Харамсалтай нь бид тэгж ажиллаж ирж чадсангүй л дээ. Үүний тодорхой жишээ бол 2008, 2009 онд яригдаж батлагдсан “Оюутолгой”-н ордод гаднын хөрөнгө оруулалттай ийм

төсөл ашиглах гэрээ. Энэ бол буруу замаар будаа тээж дээ гэдгийг нь эхнээс нь энэ асуудлыг тавьж, тэмцэж, харин энэ 2020 оноос үйл ажиллагаа явуулж байгаа энэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд тодорхой эхний алхмуудыг хийлээ.

Баялагтаа эзэн монголчууд 34%-ийг нь эзэмшиж байгаа нэртэй, тэгээд энд нийтдээ 2,3 тэрбум долларын өр үүсчихсэн. 34%-ийг эзэмшиж байгаа. Ямар ч ашиг байхгүй. Ирээдүйд энэ нь бол 22 тэрбум долларт хурч нэмэгдэхээр ийм аюулын харанга дэлдчихсэн байлаа шүү дээ. Тэгээд энийг бол ямар ч байсан үүсэж бий болчихсон 2,3 тэрбум долларын өрийг нь бол тэглээд, ирээдүйд үүсэж дарамт болох тэр 22 тэрбум долларын өрөөс бол сэргийлж чадсан. Энэ Тавантолгой бас мөн ялгаа байхгүй. Та бид нар сайн мэдэж байгаа. Энэ Их Хурал дээр хэдэн хэлдэг юмнууд байдаг. Үе үеийн парламент дээр л бид нар хэрүүл тэмцэл хийж, энэ Их Хурлын танхимын индрийн хажууд хүртэл сууж байсан ийм хүмүүс шүү дээ. Энэ Тавантолгойтой холбоотой юм байна. Эхнийхийг нь хамгийн өрөм тэр Ухаа худгийг хувийнханд өгчихсөн. Тэгээд үлдэгдэл дээр нь одоо ингээд л Монголчууд зодолдож байдаг. Тэгээд үүний хажуугаар энэ нүүрсний сонсгол явагдаж байна. Энэ хулгай худалдаа энэ юм бол нээрээ арай хэрээс хэтэрлээ шүү дээ. Энэ чинь 2014, 2015 оны үед Хятадын компанид тэр чигээр нь өгөх тухай ийм Их Хурлын тогтоолыг төслийг оруулж ирсэн шүү дээ. Тэгээд энд мөн эсэргүүцдэг, хаширдаг, тэмцдэг мань мэтийн хэдэн юмнууд тухайн үед харин Их Хурлыг даргалж байсан Зандаахүүгийн Энхболд хатуу байр суурьтай байж байж, тэгээд энийг нэг юм зогсоож авсан.

Дараа нь мөн энэ санаархал дахиад орж ирсэн. Намын бүлгийн хурал дээр 1, 2 хүний саналын зөрүүтэйгээр энийг авч үлдсэн шүү дээ. Тэгээд энэ аварга ордыг авч үлдсэний үр ашиг, үр

өгөөж бол өнөөдөр гарч байна. Ялангуяа энэ БЭТ томилогдож ажилласан. Энэ төрийн, ажил албанд мэргэшихсэн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат гэдэг хүн бол яг энэ ажлыг хариуцаад, үнэхээр менежментийг хийж байна. Үгүй ээ, нээрээ шүү. Та нар энэ ажлын хэсгийн залуучууд инээгээд, хөхрөлдөөд байх юм байхгүй. Та нар яасан доогтой. Юу нь би болохгүй юм хэлчхэв. Хуучин томилогдож байсан, энэ компанийг удирдаж байсан хүмүүс энэ хэмжээнд ажиллах бололцоо байсан уу гэвэл байсан шүү дээ. Үгүй ээ, мэдлэг, чадвар, туршлага бүх талаараа. Гэтэл нөгөө ашиг сонирхол, нөгөө сэтгэл гэдэг юм дутагдаад л. Тэгээд энэ томилогдсон хүмүүс бүгд хэл аманд орсон. Бүгд шоронгийн хаалга татсан. Олон 100 хоногоор хоригдсон, шалгагдсан. Ийм л байдалтай явж ирлээ шүү дээ.

Тэгэхээр би бол одоо энэ орж ирж байгаа ард түмэндээ хувьцааг нь эзэмшүүлэх энэ хуулийн төслийг бол бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ цаашидаа энэ том ордын менежментийн асуудлыг яаж авч явах юм бэ. Энэ БЭТ гээд томилогдоод ингээд энэ чинь байнга томилогдоод ажиллаад байх бололцоо байхгүй учраас энэ менежментийг нь хэн авч явах юм. Ямар хүн гаргах юм. Энэ эх орныхоо төлөө ард түмнийхээ төлөө хувийн эрх ашгаасаа ангид нэг ийм ажиллах хүн Монголд олдохгүй юу. Үгүй ээ, одоо бүр олддоггүй бол гаднаас тэр Норвег, бусад улс орнуудад сайн менежмент хийж байгаа тэр менежментийн багийг нь оруулж ирэх юм уу. Энийг менежментийг нь яг хуучин арга барилаараа бол явах ямар ч арга байхгүй шүү. Энийг хэлье.

Дараагийнх нь нэг хэлэх гээд байгаа юм бол БЭТ томилогдсон Ганбат энэ багийнхан сайн ажилласан.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** 5 минутаар цагийг нь өгсөн байгаа. Одоо Гонгорын Дамдинням гишүүн үг хэлье.

**Г.Дамдинням:** ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл орж ирж байна. Цагаа олоод орж ирж байна даа л гэж харж байна. Улс орон даяараа хулгай зэлгий, нүүрсний хулгайг яриад Улсын Их Хурал энэ дээр арга хэмжээ авч, олон нийтийн өргөн дэлгэр хэлэлцүүлэг хийж байгааг харж байгаа. Төрийн өмчийг хэрхэн хяналтгүй байлгавал хэрхэн хулгай хийж, идэж ууж дуусгагдийг Монголын ард түмэн бид бүхэн хараад сууж байна. Олон түмнээсээ нуугаад улсын нууцад авч байгаад хэдхэн хүн Улсын Их Хурлын хараа хяналтаас гадуур, ард түмний хараа хяналтаас гадуур хэрхэн асгаж цутгаж хагартлаа баяжицгаадаг харцгааж байна.

Тэгээд энэ үед бол ард иргэддээ 34%-ийг өгнө гэдэг бол олон нийтийн хяналтад оруулах эхний том алхам. Гэхдээ энэ ажил бол цаашаа үргэлжлэх ёстой гэж бодож байна. Нээлттэй, ил тод байж байж компанийн засаглал зөв явдаг. Компанийн хэдэн хувийг хэн эзэмших нь их чухал асуудал биш. Хэрхэн ил тод байж оролцогч талууд буюу ард иргэд, хөрөнгө оруулагчид, мэргэжлийнхнийг оруулж байж засаглалаа зөв явуулах тухай л асуудлыг бид нар ярих ёстой. Хувьцааг олон нийтэд өгнө гэдэг бол олон нийтийн хяналтыг оруулж ирж байгаа нэг том хэлбэр. Тэгээд энийгээ цаашаа яг цэвэр сонгодог нээлттэй хувьцаат компани болгох чиглэл рүү авч байгаа том алхам юм л гэж би бол харж байгаа учраас дэмжиж байна.

Гэхдээ ажлыг цааш нь гүйцэд хийх ёстой шүү. Хөрөнгийн бирж дээр гаргах ёстой энэ компанийг. Олон улсын хөрөнгө оруулагчдыг оруулж ирэх ёстой. Олон улсын хөрөнгө оруулагчдыг оруулж ирж байж бид нар энэ компанийнхаа хөрөнгө татах ажлыг сайн хийнэ. Тэгэхгүй 3,4 сая ард иргэддээ хувьцаа тараачхаад тэр хүмүүсээсээ хөрөнгө оруулалт



татах тухай асуудал яригдаж ерөөсөө болохгүй. Тэгээд ард иргэдийнхээ энэ байгалийн баялгийг эзэмшээд, цаашаа зөв мэдээлэлтэй байж, зөв захиран зарцуулахад нь хяналт тавьдаг эрхийг нь бүрэн нээнэ шүү. Дан ганц хувьцаа тараагаад, эсвэл ноогдол ашиг тараах тухай асуудал ярихаасаа гадна зөв хөрөнгө оруулалтыг татаж, зөв удирдаж, ил тод байх тухай асуудлыг нь бид нар дараа дараачийнхаа асуудлаар ярих ёстой.

Үүнтэй үргэлжлүүлээд Дархан Төмөрлөгийн үйлдвэр, Хөтөл цементийн үйлдвэр, Эрдэнэт үйлдвэр гээд энэ үйлдвэрүүдийг бид нар бас олон нийтийн хувьцаат компани болгож өөрчлөх ажлыг нь “Эрдэнэс Монгол” нэгдэл хийх ёстой. Тодорхой хувийг нь ард иргэддээ өгөөд олон нийтийн хяналтыг нь оруулаад, олон улсын хөрөнгө оруулалтыг нь татаад, хийх энэ ажлын шилжилтийн менежментийг энэ “Эрдэнэс Монгол” нэгдэл хийгээд явж байгаа гэж харж байгаа. Наранцогт захиралтай энэ хамт олон бол яг энэ чиглэл рүү нь хандуулаад сайн ажиллаад байгаа юм. Тэгэхээр энэ сонгодог загвартай яг энэ ХК болгож олон нийтийн хяналтад нь оруулаад, олон нийт өр ширийг нь ч хянадаг, орлого ашгийг нь ч хянадаг, Улсын Их Хурал дээр асуудлыг ч ярьдаг энэ зарчим руу нь оруулах тал дээр та бүхэн маань бас бодож оруулж ирээрэй.

Баялгийн сангийн хууль гээд сайхан хууль орж ирэх гээд байгаа юм шиг л яригдаад байгаа. Тэгэхдээ хамгийн чухал нь л энэ ил тод болгох л ёстой байхгүй юу. Хэнтэй ямар гэрээ байгуулаад байгаа юм, ямар хөнгөлөлт үзүүлээд байгаа юм, хэнд давуу тал олгоод байгаа юм, хэний ах дүү баяжаад байгаа юм. Шилэн толинд хийчихсэн юм шиг харагддаг л ийм л байдал руу бид нар оруулж байж энэ компанийг зөв явуулна. Би өөрөө энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж ажиллаж байсан хүн учраас хаана яаж болохгүй байгааг нь

өмнө зөндөө л хэлж байсан. Нээлттэй ил тод байж байж л энэ асуудал зөв болно. Тал талын хөрөнгө оруулалттай. Монгол Улсын төсвөөс давсан том хэмжээний мөнгийг улсын нууцад хамааруулаад, 100 төгрөгөөр авах юмыг 400 төгрөгөөр худалдаж аваад, тендергүйгээр идэж уусныг өнөөдөр Монголын ард түмэн бүтэн 2, 3 7 хоног явж байгаа Нүүрсний хулгайн сонсголоор харж байгаа. Тэгэхээр энийг л зогсоох алхам шүү дээ энэ бол. Тэгэхээр энэ компаниудын ашиг байдаг бол Улсын Их Хурлаар ярьж байж энэ стратегийн хөрөнгө оруулалтуудыг шийддэг баймаар байгаа юм. Муу ч гэсэн энэ Их Хурал чинь бас ард түмний төлөөлөл, олон нийтийн дунд яригддаг байгаа байхгүй юу. Хувьцаат компанийн ноогдол ашгийг ТҮЗ нь өөрийнхөө дотоод хөрөнгө оруулалтаа шийдээд, бусад илүү ашгаа Улсын Их Хурал руу оруулж ирэхгүй бол давхар улсын төсөв бий болоод хулгай хийдэг үүд хаалга нээгддэг. Бразилд ч ингэж хулгайлдаг, Чилид ч ингэж хулгайлдаг. Тэгэхээр олон нийтийн хяналт гэдэг бол ард иргэдийг хувьцаа эзэмшүүлж нийтийн хувьцаа гаргахаас гадна Улсын Их Хурал, ард түмний төлөөллөөрөө ярьдаг энэ зарчим руу оруулж байж бид нар зөв болох юм. Тэгэхээр “Эрдэнэс Монгол”-ын хамт олон энэн дээрээ бас анхаарч дараа дараагийн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Байнгын хороон дарга Баагаагийн Баттөмөр үг хэлье. Үүний дараа санал хураалт явагдана. Гишүүд байраа эзлээрэй.

**Б.Баттөмөр:** Энэ тогтоол ингээд яригдаад, батлагдаад явах нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа. Ноогдол ашиг хуваарилна гэдэг нь ард иргэдийн амьдрал дээшлэх нэг гол нөхцөл болно гэж ингэж үзэж байгаа. Ер нь энэ баялаг ихтэй улс ядуурах нь ийм парадокс маягийн үзэгдэл дэлхийд байдаг юм. Үүний сонгодог жишээ бол Монгол шүү дээ. Менделеевийн үелэх системийн 111 элементийн 80 нь Монголын хөрсөнд байдаг. Баялгаараа эхний 9-д ордог.

Тэгсэн мөртөө хүн амын 40-өөд хувь нь ядуурчихсан ийм л дүр зураг бидэнд байна л даа. Баялаг одоо хүссэн зүйл, хөгжил дэвшил авчирдаггүй. Буруу баялгийг удирдаж, менежментээ буруу хийвэл тэр нөгөө хулгай дээрэм, тэгээд хууль бус бүх зүйлүүд энэ баялгийг дагаж явдаг. Ийм л жишээ дэлхийд бол байдаг юм байна л даа. Ер нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид нар энэ баялгийн менежментээ зөв хийсэн бол Кувейт шиг хөгждөггүй ч гэсэн Казахстаны хэмжээнд хүрчих ийм боломж бол байлаа. Казахстаны баялгийн 2 сан өнөөдөр 128 тэрбум долларын хөрөнгөтэй болсон байна. Тийм учраас бол ямар их боломж алдав, ямар их алдагдсан боломжийн өртөг ямар өндөр байна гэдгийг л өнөөдөр бид нар энд ярьж байна л даа.

Энэ Тавантолгойн сонсгол явж байна. Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн санаачлагчид нь би юм байгаа юм. Тэгээд энэ нүүрсний сонсголыг санаачлагч нь би бас юм байгаа юм. Энд бол сайн зүйл маш их байна. Саар зүйл ч энд бас зөндөө байна. Энэ болгоныгоо засаж барьж үзэж энийг улам сайн болгох ийм шаардлага бол байна гэж ингэж үзэж байна. Энэ баялгийг бол хүссэн хүн болгонд өгдөггүй юм. Мэргэжлийн, хөрөнгийн биржид бүртгэлтэй, санхүүгийн чадавхтай ийм компанид өгдөг. Гэтэл Монгол 6200-аад лицензийг хүнд өгөөд, тэр нь шилжээд наймааны хэрэгсэл болчихсон явж байгаа шүү дээ. Үүний нэг үр дүн нь энэ Улаанбаатар хотын талбай тойрсон хэдэн том өндөр барилгууд лицензтэй холбогдож байгаа. Биржийн хууль Монголын эдийн засагт том өөрчлөлтийг авчирсан шүү. Тэр бүх данснууд нь ашигтай. Тэгээд эндээс үндэслээд төлбөрийн тэнцэл нь ашигтай гарч байгаа. Үүний 60-70 хувь нь юу вэ гэхээр биржийн хуультай холбоотой ийм байгаа юм.

Энэ баялгийн төрийн бодлого, баялаг ашиглах төрийн бодлого

хэрэгтэй. Цөөхөн хэдэн хүн аваад зөвхөн гэр бүлийнхээ эрх ашиг, хувь хүнийхээ эрх ашигийн төлөө баялгаа худалддаг. 1 жишээ сая Дэлхийн банк гаргасан. Дэлхийн хамгийн том нүүрсний хэрэглэгч Хятад Монгол Улсын коксжих нүүрс ОХУ-ын коксжих нүүрснээс 18 хувиар бага. Дэлхийн дунджаас 50 хувиар бага худалдагдаж байна шүү дээ. Худалдаа хийж чадахгүй байна. Худалдааны хуулийг ярья, баталъя гээд л яриад байдаг, яриад байдаг. Байдаггүй. Энэ баялаг эзэмшиж байгаа компаниуд бол энэ үйл ажиллагааныхаа орлогыг ил тод тайлагнах ёстой. Тэр сорсын уриалга байгаа шүү дээ. Дэлхийн 130 гаруй улсууд нэгдчихсэн. Баялаг эзэмшигч нар биржээр бүтээгдэхүүнээ худалдах ёстой. Тэр хувийн ч бай, юуны ч бай компаниуд бүгд биржээр худалдах ёстой. Ялангуяа энэ зэсийг худалдах ёстой. Зэс тойрсон шимэгч нараас салах ёстой Монголчууд. Хөрөнгийн бирж дээр энэ баялаг эзэмшиж байгаа компаниуд хувьцаагаа гаргах ёстой. Тэгж байж ил тод болно гэх мэтийн олон асуудлууд энд тулгарчихсан ийм байна л даа. Төрийн өмчтэй компаниудыг л ер нь хамгийн муу муухай л гээд л төрийн өмч рүү, төрийн өмчийг хэрэгжүүлж байгаа тэр цүнх баригч нарын л хийж байгаа хулгай шүү дээ. Одоо энэ нүүрсний хулгайг хар л даа. Ярьж байгаа юм тэр чигээрээ хулгай. Тэнд тээвэр хийж байгаа нэг жолооч, тэнд нэг туслан гүйцэтгэгч бол тэнд хулгай хийхгүй шүү дээ. Эрх мэдэлтэй хүмүүс хулгай хийж байгаа шүү дээ.

Тийм учраас Монгол Улсын хамгийн том тулгамдсан асуудал бол юу гэхээр төрийн өмчтэй компаниудынхаа засаглалыг сайжруулах шаардлагатай. Өнөөдөр төрийн өмч муу муухай л гэж байна. Өнөөдөр “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” 2 Монголыг авч явж байна шүү дээ. Энэ баялгийн төлбөрийг ил тод болгох ёстой. Энэ дэлхийн санаачилга. Энийг бас дэлхийн 150-аад орон хүлээн зөвшөөрчихсөн явж байгаа гэх мэтийн маш олон асуудлууд байгаа. Баялгийнхаа

менежментийг зөв хийж байж Монгол Улс хөгжинө. Өөр зам байхгүй.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд байраа эзэлье. Байнгын хороо, нам, эвслийн бүлгүүд ирцээ бүртгэе.

Санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах арга зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

Горимын санал гаргах уу. Цогтгэрэл дарга аа, та гаргачих уу. Жавхлан гишүүн горимын санал гаргая. Жавхлан гишүүн горимын санал гаргая.

**Б.Жавхлан:** Хурал даргалагчаас уучлалт хүсэж байна. Сая би жоохон хоцорч орж ирээд санал хураалтад орж амжсангүй. Тэгээд санал хураалтад орчихмоор байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч уучлаарай.

Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 52,4 хувиар санал дэмжигдлээ.

Уг санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд ээ. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийнхаа асуудалд оръё. Гишүүд сууж байгаарай.

**Дараагийнхаа асуудалд орно.**  
**“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ.**

Өчигдөр буюу 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр уг асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл 1 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан үг хэлэх үү. Одонгийн Цогтгэрэл даргын микрофон өгье.

**О.Цогтгэрэл:** Ардчилсан намын бүлгээс сонгуулийн санал хураах өдөр буюу товлон зарлахтай холбоотой асуудлаар завсарлага авсан. Гол учир нь яагаад вэ гэвэл санал хураах өдөр 5 дахь өдөр, Баасан гарагт таарч байгаа нь өөрөө саналын сонгуулийн ирцэд нөлөөлөх вий. Олон хоногийн үргэлжилсэн амралт давхацсан байдлаар 3 хоног гарч байгаа учраас ирцэд муугаар нөлөөлөх вий. Би энийг ажлын аль нэг өдөр лүү шилжүүлж өгөөч гэдэг саналыг гаргасан. Тэгээд өнгөрсөн хоногийн хугацаанд бас ярилцаад тодорхой бас шийдэл, ойлголцолд бас хүрч чадаагүй ээ. Ер нь өнгөрсөн хугацаанд улс орны эрх ашигтай холбоотой сонгуулийн тогтолцоотой холбоотой улс төрийн нөхцөл байдалтай холбоотойгоор Үндсэн хуулийн өөрчлөлт, Сонгуулийн хууль, Сонгуулийн бүсчилсэн тойргийн тогтолцоо олон зүйлүүд дээр Ардчилсан нам болоод Ардчилсан намын бүлгийн зүгээс аль бол болох улс орны эрх ашгийн талд гэдэг шийдвэрийг эргэлзээгүйгээр гаргаж ирсэн. Өнгөрсөн хугацаануудад харин яг энэ үзэл санаанууд, энэ том бодлогууд хэрэгжихэд үндсэндээ бүсчилсэн тойргийн тогтолцоо гэдэг чинь өөрөө урьд өмнө 8 удаагийн сонгууль

32 жилд хэрэглээгүй ийм замаар бид нар явах гэж байна.

Энэ том тогтолцоо болоод энэ өөрчлөлтийн асуудлууд гарахад бас олон олон зүйлүүд үүний цаана залгагдаж явах ёстой. Энд хамгийн гол нь сонгууль шударга, маргаангүй, олон нийт ард иргэд хүлээн зөвшөөрсөн нөхцөл байдлаар явах ёстой. Мөн үүний бас нэг том хүчин зүйл нь сонгуулийн ирц. Ард иргэд нь төрөө байгуулахдаа өндөр ирцтэйгээр, боломжит өндөр ирцтэйгээр оролцох болоод энэ оролцохыг хангуулах нь өөрөө бас энэ хууль болоод хууль тогтоох байгууллагын сонгуулийг товлон зарлах эрх бүхий байгууллагын бас үүрэг. Ийм учраас сонгуулийн ирцэд нөлөөлж болох аливаа зүйлийг боломжит өдөр судар, боломжит байдлаар нь хийе гэдэг саналыг л бид нар гаргасан. Тэгээд энийг өнгөрсөн 1 хоногийн хугацаанд энэ дээр бас тодорхой хэмжээний ойлголцолд хүрээгүй. Тийм болохоор бид нар энэ байр суурь дээрээ байна. Энэ сонгууль өндөр ирцтэй болох ёстой биш шударга, маргаангүй иргэд итгэлцэлтэй иргэд сонгуулийн дараа олон. Магадгүй энэ чинь шинэ замаар явж байгаа учраас олон мандаттай тойргийн асуудал гарч байгаа учраас сонгуулийн дараа маргаан янз бүрийн олон зүйлүүд гарахыг бас үгүйсгэхгүй. Тэгэхээр иргэд оролцчихсон, оролцож саналаа өгчихсөн байх нь хамгийн чухал гэдэг л ийм шаардлагыг бид нар тавьж байгаа.

Ийм учраас Их Хурлын дэд дарга аа, бид бүгд бас Дэгийн тухай хуулийн дагуу Ардчилсан намын бүлэгт энэ тухайн завсарлага авсан асуудлаар үргэлжлүүлэн ажлын 3 хоногийг нь завсарлага өгөхийг хүсье ээ.

**Л.Мөнхбаатар:** Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр товлон явуулахаар тогтоож байгаа. Тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн байгаа. Улсын Их Хурлын чуулганы

хуралдаанаар хэлэлцэх явцад Ардчилсан намын бүлэг 1 хоногийн завсарлага авсан. Үргэлжлүүлэн намын бүлгүүд бас ярилцах бас шаардлага байна гэж үзэж байгаа учраас Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу 3 хоногийн завсарлага өглөө.

Ирэх 7 хоногт хэлэлцэж эцэслэн батална. Хуулийн хугацаатай асуудал байгаа.

13.25 цаг.

Дараагийнхаа асуудалд орёе. Өмнөх ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг олонх нь дэмжсэн учраас анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

**Дараагийн асуудалдаа орёе. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Х.Болорчулуун:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.10-д хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж заасан ба Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын асуудал нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол үйл ажиллагаа юм. Монгол Улсын хүнсний гол нэрийн 16 нэр төрлийн бүтээгдэхүүний 65 хувийг ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн эзэлдэг тул ургамлын



эрүүл мэндийн асуудал нэн чухал асуудал юм.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 2022 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан юм.

Монгол Улс Ургамал хамгааллын тухай хуулийг анх 1996 онд баталж, 2007 онд шинэчлэн найруулж өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байна. Энэхүү хүчин төгөлдөр үйлчилж буй Ургамал хамгааллын тухай хуульд ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг голлон зохицуулсан ба ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаа руу чиглэсэн зохицуулалт нь хангалтгүй байгаа юм.

Иймээс Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2007 онд батлагдсанаас хойш 1 жилийн дараа буюу 2008 онд Монгол Улс Ургамал хамгааллын олон улсын конвенцод нэгдэн орсон. Энэхүү конвенцын стратегийн зорилт хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөдөө аж ахуйг дэмжиж, дэлхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах гэж заасан юм. Иймээс Монгол Улс гишүүн орны хувьд ургамлын хамгааллын салбарын хууль тогтоомжийг тус конвенцын зарчим үйл ажиллагаанд нийцүүлэх үүрэгтэй юм. Түүнчлэн Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойших хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил,

дутагдлыг арилгах, нөгөө талаар байгаль орчин нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан хөдөө аж ахуйн салбарын хамрах хүрээ тэлж ургамал түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, хэрэглээ, олон улсын хандлага, худалдаа нэмэгдсэнтэй холбоотойгоор ургамал хамгааллын үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд юуны түрүүнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага үүсэж байна.

Иймээс Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийг батлагдсан үзэл үзэл баримтлалын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн дэмжихийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Болорчулуун сайдад баярлалаа. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Идэрбат гишүүн танилцуулъя.

**Ц.Идэрбат:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улс ургамал хамгааллын олон улсын конвенцод нэгдсэний дагуу хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, таримал ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний

аюулгүй байдлыг хангах, эрсдэл үүсээж болзошгүй шат дамжлага, цэгүүдийг зөв тодорхойлж, тандалт судалгаанд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна аа. Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын Ди, Парламент цэг мн сайтад цахим сайтад байршуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Дамдинням малын тоо толгойг бууруулах, чанаржуулах, бэлчээр хамгаалах, уламжлалт мал аж ахуйтай, ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрхэн уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн өвс ургамлыг доройтуулж байгаа гол хүчин зүйлсийн талаар 2024 онд улсын төсөв батлагдсан үед шинэ агентлаг байгуулахыг Засгийн газар дэмжиж байгаа эсэх, ургамал хамгааллын салбарын боловсон хүчин хүрэлцээтэй эсэх, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар шинээр байгуулагдах агентлагийн бүтэц орон тоо, төсвийн талаар, төрийн хэмнэлтийн тухай болон холбогдох бусад хуультай зөрчил үүсэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Бейсен устаж байгаа ургамлын төрөл зүйлийн талаар бэлчээрийн даац хэтэрсэн газарт ямар зохицуулалт хийх, эмийн ургамлын тариалалт, хамгаалалтын асуудлаар арга хэмжээ авч байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Дамдинням төсвийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, бэлчээртэй холбоотой зохицуулалтыг тусгах ажлын хэсэгт холбогдох салбарын яамдын төлөөллийг оруулах, хуулийн төслийн талаарх тооцоо судалгааг дахин нягталж танилцуулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны салбарын хуулиудын давхардал, хийдлийг арилгах хуулийн төслүүдийг хамтад нь хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн газар тариалан, мал аж

ахуйг уялдуулах, холбогдох бусад хуулиудын уялдаа холбоо нийцлийг хангах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал бэлчээрийн ургамлын хамгаалалт, хөнөөлт ургамлын тандан судалгаа, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдалтай хэрхэн тэмцэх, таримал ургамлын өвчлөл аж ахуйн нэгжүүдийн мэргэжлийн удирдлага эрх, үүргийг тодорхой болгох, ойг хортон мэргэчтэй тэмцэх хөрөнгийн талаар болон хууль хоорондын нийцлийг цогцоор нь авч үзэх талаар саналаа илэрхийлсэн болно.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 69,2% нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ургамал хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт

шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

**Л.Мөнхбаатар:** Идэрбат гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, тус яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, тус яамны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Нофын Оюунсувд, тус яамны Газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Базаррагчаагийн Уранчимэг нар оролцож байна. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Асуулт асуух гишүүн алга байна. Үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Байнгын хорооны саналаар санал хураалтыг үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулна.

13 цаг өнгөрсөн байна. Чуулганы үдээс өмнөх хуралдааныг өндөрлүүлж байна. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар 14 цагаас эхэлнэ.

**ЗАВСАРЛАГА.**

**Г.Занданишатар:** Өдрийн амгаланг айлтгая 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонсоно. Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы танхимд цугларч Ерөнхий сайдын асуулгын хариуг сонсоход оролцохыг хүсье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Ерөнхий сайдад хандаж тавьсан Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.

Сайд, ажлын хэсгийг оруулъя. Дэгээрээ асуулга 2 цагаас тэгээд асуулгын дараа л бусад асуудал үргэлжилнэ. Унших уу?

**Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.**

Асуулгад Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн хариулна. Индэрт урьж байна.

**Ц.Даваасүрэн:** Эрхэм Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас баталсан Алсын хараа-2050, шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичигт туссан гэр хорооллын газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр туссан зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна аа.

Үүнд Хот байгуулалтын тухай хууль, нийслэлийн Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулж, өргөн барих шатанд ороод байна аа. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу 2040 онд Улаанбаатар хотын суурьшлын хувьд орон сууцын хороололд хүн амын 84 хувь, гэр хорооллын бүс дэх хүн амын 16 хувь нь оршин суухаар төлөвлөж байгаа болно. Гэр хорооллын газрын дахин төлөвлөх харилцааг Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу зохион байгуулж байгаа бөгөөд 2013 оноос 2023 оны хооронд НИТХ-ын 10 удаагийн шийдвэрээр гэр хорооллын 31 байршил, 88 хэсэгчилсэн талбай, 1967.1 га газар, 23096 нэгж талбарыг хамруулсан байна. Тус байршлуудад батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 143323 айлын орон сууц, 60 сургууль, 92 цэцэрлэг, 14 эмнэлгийг барьж ашиглалтад оруулахаас гадна бусад төрийн болон хувийн хэвилийн үйлчилгээг иргэдэд хүргэхээр төлөвлөсөн болно. Наад захын үйлчилгээгээ дэд төвдөө авдаг байхаар ингэж төлөвлөж зохион байгуулж байна аа.

Одоогийн байдлаар төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт 20 байршил, 58 хэсэгчилсэн талбай, 45 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд 23 оны байдлаар 17984 айлын орон сууц ашиглалтад оруулсан байна. 3135 нэгж талбарын газраас чөлөөлөлт хийгдсэн. Мөн өнгөрсөн хугацаанд гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний ажилд 179.7 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Цаашид одоо хэрэгжүүлж буй төслүүдийн дэд бүтцийг бүрэн шийдвэрлэхэд 617.9 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан бөгөөд 2024 онд улсын болон нийслэлийн төсвөөс 45.6 тэрбум төгрөгийг шийдвэрлээд байна аа. Түүнчлэн 2017 онд хэрэгжиж эхэлсэн Улаанбаатар хотын

гэр хорооллын хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд 193 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дэд бүтэц нь бүрэн хийгдсэн Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд дээрх барилга угсралтын ажлыг 2024 оноос эхлүүлэхээр нийслэлийн төсвөөс газар чөлөөлөлтийн ажлыг эхлүүлсэн. Ингэснээр уг 2 байршилд 5127 өрхийн нягтарилыг нэмэгдүүлж, 13213 өрхийн орон сууцын цогцолбор хорооллыг барьж байгуулахаас гадна иргэд хотын төв рүү оролгүйгээр төрийн үйлчилгээг болон бизнес ахуйн үйлчилгээгээ тухайн төвөөсөө авах боломжийг бүрдүүлэх юм аа.

Энэхүү бүтээн байгуулалтын эхний ээлжийн орон сууцын санхүүжилтийг Уур амьсгалын ногоон сан Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны зээл тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууцын төслийг эхлүүлж байгаа бөгөөд 2024 оны 1 дүгээр улиралд эхний ээлжийн 220 айлын орон сууцыг барьж эхэлнэ ээ.

Цаашид тус төслийн хүрээнд 10 мянган өрхийн орон сууцын төслийг хэрэгжүүлэхээр зорьж байна. Зураг төслийн ажил хийгдээд явж байна аа. Гэр хорооллын дахин төлөвлөлт, газар чөлөөлөлтийн ажлыг эрчимжүүлэхэд төрийн өмчийн түрээсийн орон сууцын санг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газраас улс, нийслэлийн төсөв, гадаадын хөнгөлөлттэй зээл тусламж, төр, хувийн хэвилийн түншлэлийн хөрөнгөөр Ногоон нуур-1008, Залуус-1, Солонго 1, 2, Баянголын ам зэрэг орлогод нийцсэн орон сууцын хороолол барих төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг төслүүдийг 2028 он хүртэл үе шаттайгаар ашиглалтад оруулснаар нийт 200 гаруй га талбайд нийт 18 мянган айлын орон сууцыг бий болгохоор төлөвлөж байна аа. Үүнтэй уялдуулан түрээслүүлэх, газар чөлөөлөх, түр



суурьшуулах үйл ажиллагаануудыг ашиглахаар төлөвлөж байна аа. Зөвхөн гэр хорооллыг дахин төлөвлөж бариулж байгаагаас гадна Сэлбэ, Дунд голын дагуу үерийн хамгаалалтаас сэргийлэх албан байгууллага, Сэлбэ сэргэлт авто зам барьж байгуулах, Улаанбаатар хотын төлөвлөлт болон авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж түгжрэлийг бууруулах зорилгоор эдгээр ажлыг хийж байгаа болно. Уг зураг төслийн дагуу нийслэлийн хэмжээнд Сонсголонгоос Дамбадаржаа хүртэлх чиглэлийн Сэлбэ сэргэлтийн 21.6 км 6 эгнээ бүхий автомашин, нийтийн тээврийн үйлчилгээнд зориулсан замыг 32 том, жижиг гүүр, 9 туннел, 48.6 км явган хүний зам, 21.6 км унадаг дугуйн зам, 44 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийг шинээр байгуулснаар Улаанбаатар хотын түгжрэлийн асуудлыг 6-аас 8 хувиар бууруулна гэж тооцож байгаа болно. Мөн инженерийн төвлөрсөн сүлжээнд холбогдох боломжгүй газар оршин суугчдыг хэсэгчилсэн болон бие даасан эх үүсвэртэй амины орон сууцаар хангах хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийн журамд амины орон сууцын болон зээл олгож болох зориулалтыг 2020 онд оруулж Барилгын хөгжлийн төвийн даргын 2021 оны А-238 дугаар тушаалаар амины орон сууцын барилгын ажил захиалагчийн техникийн хяналтын үйл ажиллагааг зохицуулах журмыг батлуулж мөрдүүлээд байна аа.

Ингэснээр нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын бүсээр төлөвлөгдсөн хэсэгт иргэд амины орон сууцыг зээлээр бариулах боломжийг бүрдүүлж өгч байна аа. Түүнчлэн санхүүжилтийн эх үүсвэрийг Монголын ногоон санхүүгийн корпорацитай хамтран уур амьсгалын ногоон сангийн хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлэхээр ажиллаж байна аа. Дээрх төсөл хөтөлбөрүүд бүрэн хэрэгжиж дууссанаар 2040 он гэхэд Улаанбаатар хотын агаар орчны бохирдлыг

мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах юм аа.

Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн. БХБЯ-ны Хөгжлийн бодлого, газрын харилцаа хот байгуулалтын газрын дарга Эрдэнэбатын Батболд, Нийслэлийн ерөнхий архитектор, Хот байгуулалт хөгжлийн газрын дарга Доржбатын Хан-Уул, Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга Ганбатын Ганхүү, Нийслэлийн орон сууцын корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал Маньбазарын Говьсайхан, Улаанбаатар хотын гэр хорооллын хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Дангаагийн Авирмэд, Нийслэлийн хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын дарга Галсантогоогийн Баттулга, Нийслэлийн хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын ерөнхий инженер Гомбожавын Одончойжоо нар оролцож байна аа.

Асуулгын хариулттай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй алга байна. Булгантуяа гишүүнээр тасаллаа. Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Маш чухал сэдэв хөндөж байна аа. Яах вэ Баянгол дүүрэг бол нийтдээ 7 гэр хороотой юм. Нэг гэр хороо буюу Гандангийн орчим дахин төлөвлөлт хийгдээд явагдаж байгаа, амжилттай явагдаж байгаа. Үлдсэн 6 хороон дээр нэг асуудал байгаад байгаа юм Даваасүрэн сайд аа. Энэ дээр 5 компани дахин төлөвлөлтийн ажил хийж

байгаа. Нэлээн удаашралтай байгаа. Орон сууцнууд барьдаг. Нөгөө бохирын дулааны шугамтай холбогдож чадахгүй байгаад байгаа. Саппорогийн уулзвараас дээшээ нэг шугам явах ёстой гээд нийслэл дээр мөнгө төгрөг нь тавигдсан л гээд байдаг. Тэр нь ингээд ажил явахгүй удаашралтай яваад байна. Тэрнээс болоод иргэд нөгөө 3 талт хэлэлцээрт итгэл алдаад ингээд суугаад байдаг. 7, 8 жил хүлээсэн иргэд хүртэл байгаад байгаа юм. Тэгээд энэ ажил дээр нь та нэг анхаарал тавиад өгөөч ээ. Шаардлагатай төсөв мөнгийг нь шийдэх талаас нь нэг анхаарал тавиад өгмөөр байна.

Хоёрдугаарт манай энэ гэр хороодуудаар ер нь бол яах вэ цаашидаа бид нар энэ янданг нэмэхгүй байх тал дээр ер нь ямар бодлого барьж явах вэ? Бид нар ингээд хотоос, нийслэлээс тодорхой тооны давхар шатлалдаа зуух тараана гэж байгаа. Зарим айлуудыг цахилгааны эх үүсвэрт холбоно гэж байгаа юм. Тэгээд бид нар бол нөгөө ТЭЦ-5 буюу Улаанбаатар хот орчимд шинэ цахилгаан болон дулааны эх үүсвэрийг нь шийдэхгүйгээр ингээд цаашаа ингээд яг гагцхиаад байна л даа. Яг нэг цэг дээр очоод л гагцхиаад байгаа. Яндан хөөлөх м гээд л олон ажлууд хийгддэг л юм шиг байгаа юм. Тэгэхдээ энэ бол яг өнөөдрийн энэ гарчхаад байгаа үр дагавартай буюу энэ утаатай тэмцэх боломж нь харьцангуй хомс гэж яриад байгаа юм л даа. Тэгээд энэ дээр нэг танаас нэг санал сонсчихмоор байгаа юм. Ямар бодлоготой байгааг сонсчихмоор байна аа.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн сайд хариулъя. Даваасүрэн сайдын микрофоныг өгөөрэй.

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид нар гэр хорооллын дахин төлөвлөлттэй тулгараад байгаа нэг бэрхшээлтэй асуудал бол инженерийн

дэд бүтцийн асуудал болчихоод байгаа юм аа. Ер нь Улаанбаатарын хэмжээнд дулааны хангамжийн асуудал бол байгаа хэрэгцээ нь бараг хүчин чадлаасаа 30, 40 хувиар хэтэрчихсэн ийм болчихсон. Тийм учраас дулааны шинэ эх үүсвэр бол шаардлагатай. Шинээр барилга байгууламж ашиглалтад оруулах ийм боломжгүй болчихсон. Энэ нь гэр хорооллын дахин л төлөвлөлтөд нөлөөлөөд байгаа юм.

Тийм учраас бид нар нэгдсэн халаалтаас татгалзаад дэд төвүүд байгуулаад дэд төвүүд дээр энэ дулааны эх үүсвэрүүдийг бий болгох ийм л төлөвлөлтийг цаашидаа хийж явахаар явж байгаа. Зүгээр асуугаад байгаа тэр Саппорогийн тэр чиглэлд бол уг нь нэг шугамын ажил хийгдээд явж байгаа юм. Тэр 1 дүгээр хорооллын араар явж байгаа шугамыг бол би хийгээд дуусчихсан байх гэж бодож байна. Дулааны шугам. Гол гацаа юун дээр үүссэн гээд тэгэхээр бүүр 2012, 2013 оны үед эхэлсэн нэг төсөл байгаа. Тэр Тэц-4-өөс гараад тэгээд тэр 1 дүгээр хорооллын шугамтай холбогдох. Энийг хийнэ гэж авчхаад тэр компани нь өнөөдрийг хүртэл хийгээгүй. Намайг сайд байж байхад бас хийгээгүй. Одоо ч гэсэн ингээд хийгээгүй л яваа юм билээ. Тэгээд 1 компаниас болоод ингээд нэг гагцхисан ажил байдаг юм. Зүгээр энэ нь юу болсон юм манай эрчим хүчнийхэн хотынхон бас энэ дээр нэмж хариулна биз. Энэ шугам холбогдчих юм бол уг нь бас тэр 4 дүгээр хороолол 3 дугаар хороолол чиглэл рүү явах дулаан хангамжийн асуудал бас харьцангуй зүгээр шугамын хувьд сайжирна. Гэхдээ дулааны эх үүсвэрийн хувьд нөгөө хүрэлцээний асуудал бол хүндрэлтэй.

Янданг нэмэхгүй байх ёстой. Тэгэхдээ энийг бол өнөөдөр цахилгааны эх үүсвэрээр шийднэ гэвэл боломжгүй болчихсон. Бид нар нэг 40 гаруй мянган боломжтой айлуудад нь өнгөрсөн хугацаанд хүргээд өгчихсөн юм. Цахилгааны эх үүсвэр нэмэх боломжийг.

Тэрнээс цааш нэмэх гэхээр нөгөө цахилгааны эх үүсвэр нь хүрэлцэхгүй байгаа юм. Зуух бол нэг их том сайн шийдэл биш юм байгаа юм тэрийг ингээд л бүрэн шатаана гэдэг тэр үлгэрийг одоо хэдэн жил ярих гэсэн юм мэдэхгүй. Яриад л байх юм, яриад л байх юм зүгээр. Миний хувьд бол одоо байгаа боломжтой богино хугацаанд хийх гарц бол өнөөдрийн бас тодорхой амжилтад хүрчхээд байгаа энэ нэг мананг арилгачхаад байгаа юм энэ чинь. Манан дунд л бид нар байсан шүү дээ. Зүгээр мартчихаад л өнөөдөр утаа гэж яриад байгаа болохоос биш манан дунд л байсан. Өдийд манан дунд л байдаг байсан. Одоо манан дунд биш л байна шүү дээ. Энэ амжилтаа ахиулахын тулд өмнө нь хийсэн шахмал түлшээ сайжруулах ёстой юм аа.

Энэ төслийг би Германуудтай хамтраад хэрэгжүүлээд эхлэх гэж байсан боловч миний бүрэн эрхийн хугацаа дууссан. 200 мянган евро шаардлагатай байхгүй юу. Тэр юун 175 мянган тэрбум төгрөг. Ингээд л хийчих юм бол тэр түлшийг нь сайжруулаад ингээд явах бүрэн бололцоотой. Би ингэж эхний алхмаа хийх ёстой. Тэгээд дараа нь бол харин одоо сэргээгдэх ч юм уу янз бүрийн энэ нүүрс хүчлийн хий ялгардаггүй ийм эх үүсвэрүүдийг ашиглах чиглэл рүү л явах ёстой байх метан, газ энэ тэр гээд энэ бололцоонуудаа судлаад явах байх. Өнөөдөртөө бол бид нар яалт ч байхгүй л шахмал түлжээ сайжруулаад л технологийг нь сайжруулаад л явах ийм л шаардлагатай.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах уу? Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

**Г.Ганхүү:** Байна уу? Нийслэлийн Орон сууцын бодлогын газар Ганхүү байна. Ганхуяг гишүүний асуултад тодруулга хариулъя.

БГД-ийн хувьд гэр хорооллын дахин төлөвлөлтийн 3 байршил дээр Грийн ресурс, Очирням проперти, Скай вишин гэсэн 3 компани үйл ажиллагаа явуулж байгаа. 2019 онд 970 метр бохирын шугамын ажил хийгдсэн байдаг. Мөн зайлиггүй шаардлагаар траст өөрчлөлт орох үлдэгдэл ажлыг дуусгах зайлиггүй ажлын хүрээнд магадлалаар оруулаад өнөөдрийн байдлаар 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилт дутуу байгаа. Энийг бид нар нийслэлийн 2024 оны төсөвт тусгаж шийдвэрлэсэн байгаа. Тэгэхээр энэ үлдэгдэл бохирын шугамын ажлыг энэ 2024 ондоо багтааж хийж дуусгана аа. Тэгсэн тохиолдолд энэ 3 байршил дээрх бохирын шугамын ажил бүрэн шийдэгдэнэ ээ гэсэн үг. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хороон дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Улаанбаатар хотод хүн амын яг статистикаар 45, 46 хувь байдаг гээд ингээд хар даа. Яг бодит байдал дээр жараад хувь нь байгаа шүү дээ үндсэндээ. Оюутан, сурагчид тэгээд одоо ирж явж байгаа янз бүрийн юм ирж явж байгаа улсуудыг тооцох юм бол ер нь тэгээд бас нэлээн том тоо гарах байх л даа. Тэгээд энэ төвлөрөл гэдэг юм бол юутай холбоотой вэ гэхээр төрийн бодлогын алдаатай төрийн бодлогоос л болж байгаа шүү дээ тийм ээ. Хөдөөгийнхөө хөгжлийг хаячихсан, малчид болон хөдөө амьдардаг хүмүүсийн ажиллах амьдрах аятай тухтай нөхцөлийг төрөөс бүрдүүлж өгөөгүй төвлөрлийг сааруулах бодлогыг барьж ажиллаагүй гэх мэтийн олон асуудлууд бас энэ төвлөрөл бий болчихсон. Одоо яах вэ ер нь бол энэ Дамбадаржаа ч гэдэг юм уу, Хайлааст ч гэдэг юм уу 100 айл ч юм уу ингээд нэг төвлөрсөн энэ нэг ийм газрууд руу инженерийн шугам сүлжээ бол татах нь зүйтэй. Татаж шийдэхээс өөр арга байхгүй. Ер нь зүгээр 21 дүгээр зуунд өнөөдөр шийдэл нэг инженерийн шугам сүлжээ татаж байна шүү дээ. Хаа хаагүй л татаж байгаа. Тэгэхээр

шинжлэх ухаан технологийн ололтыг ашиглаад энийг тэр сая сайдын үгэнд ч бас гарч ирж байна. Тэр хэсэгчилж шийдэх аргууд.

Ялангуяа энэ Хайлааст тэр Долоон буудлын тэр уулын орой дээр гарчихсан байгаа айлуудыг яаж шийдэх юм вэ? Тус тусад нь шийдэх тийм арга замууд ер нь юу байдаг юм бэ? Энэ хамгийн аюултай нь сая нэг эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар энэ Монгол манай Улаанбаатар хотын чинь ундны ус чинь тэр нөгөө нолын жорлонгийн тэр нян, тэр ялгадасны нян илэрсэн гэсэн ийм мэдээлэл гарсан шүү дээ. Тэгээд энэ чинь бол хамгийн аюултай байхгүй юу. Нөгөө нэг өвчлөл чинь дэлхийд олон өвчлөлөөр тэргүүлсэн байж байдаг. Гэтэл дээрээс нь ялгадасны нян нь ундны усанд нь илрээд байдаг.

Тэгэхээр энэ ер нь Улаанбаатар хотын асуудлыг яах вэ ингээд нэг тэр Сэлбэ, Баянхошуу өртөө, дэд өртөө гээд л юм хийх л юм байна л даа. Тэгэхдээ яг орчин үеийн өнөөдрийн шийдлүүд ямар шийдлүүд байж болох вэ? Жоохон тийм урагшаа харсан юм ярьцаага яах вэ ийм асуулт байна, нэг дэх нь.

Хоёр дахь нь орон нутгийн асуудлыг зүгээр хаяж болохгүй. Тухайлбал Дархан-Уул аймагт манай тухайн үеийн удирдлагууд бидэнд асуудал тавиад Дарханы хойд талын тэр хуучин Дарханы 5, 6, 7, 8 дугаар багууд руу 19 км инженерийн шугам сүлжээ татагдсан байгаа юм. Тэгээд энийг одоо манай яамны удирдлагууд мэдэж байгаа байх. Дархан хот бол бас тулгуур төв болж байгаа. Энэ утаа бас агаарын бохирдол бас нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ шугам сүлжээнүүдийг ашиглаад Дархан чиглэлд ямар бодлогууд байна. Би яамныхнаас асууж байгаа юм. Энэ чиглэлд бодлогоо ярьж хэлж өгөөч ээ гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр даргын асуултад хэн хариулах вэ? Сайд хариулъя. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно шүү.

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсэг дээр Дархан-Уулын юун дээр нь тодруулчхаарай. Энэ нөгөө нэг Улаанбаатар хотын гэр хорооллын асуудал гэсэн учраас бид нар бас тэр чиглэлээр мэдээлэл бэлдэж өгөөгүй байгаа. Зүгээр холбогдох улсууд нь хариулчихъя. Өндөр газар яах вэ гэж одоо энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн хувьд инженерийн шугам сүлжээг гэж байгаа юм байна. Тэр өндөр газар бол дулааны шугамын хувьд бол хүндрэлтэй. Нэгдсэн дулаанаар халаахад.

Тийм учраас өндөр газрууд дээр бол сэргээгдэх эрчим хүчийг ашиглах энэ талыг л бид нар барих боломжтой. Өөрөөр хэлэх юм бол нар хит памп гэдэг ч юм уу одоогийн хамгийн сүүлийн үед хэрэглэгдэж байгаа энэ технологиудыг ашиглах боломжуудыг бид судалж байна. Тэгээд усыг нь нараар халаадаг мөн тэр хит пампаар халаадаг энэ хосолмол технологийг өндөр газруудад хэрэглэх бүрэн боломжтой юм гэж ингэж үзэж байгаа. Ялангуяа ууланд өндөрлөг газар байрласан айлуудын хувьд дулааны шугам сүлжээ очиж болохгүй байгаа газруудын хувьд ингэж шийд мэднэ ээ.

Цэвэрлэх байгууламжийн хувьд бол тэр мини цэвэрлэх байгууламж энэ тэр байгуулаад шийдээд явах бүрэн боломжтой. Уулын өндөрлөг газруудын хувьд бол. Дархан-Уул аймгийн хувьд бол ер нь энэ гэр хорооллын төлөвлөлт орон сууцуудын асуудал бол сайн явж байгаа юм байна лээ. Ер нь инженерийн дэд бүтцүүд ер нь харьцангуй сайн шийдсэн ийм дүр төрх ажиглагдаж байна лээ. Цэвэрлэх байгууламжийг бид нар өргөтгөж өгч байгаа тэр ингээд ашиглалтад орох гэж байна.



Шугам сүлжээний хувьд бол ажлууд хийгдээд явж байгаа. Энэ талаар одоо бас тодорхой мэдээллийг манай яг холбогдох мэргэжилтэн өгөх байх. Энд нь ажлын хэсгээс хариулчих, Дархан-Уул шүү.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн хэд вэ? 87 дугаар микрофоныг өгье. Асуултад хариулъя.

**Д.Хан-Уул:** Өдрийн мэнд хүргэе ээ та бүхэнд нэмэлт тайлбар өгье. Нийслэлийн Ерөнхий архитектор Хан-Уул байна. Улаанбаатар хотын суурьшлын 6 бүс бол нийтдээ 35206 га талбайд байгаа. Үүний бол 66 хувь нь буюу 23 мянган га нь бол гэр хорооллын нутаг дэвсгэр байгаа. Энэ дээр 23 мянган га нутаг дэвсгэрийн нийт 9 мянган га нь бол инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох бүрэн боломжтой. Энэ дээр нөгөө гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа ийм байршил байгаа. Энэ нь бол гэр хорооллыг хөгжүүлэх энэ 23 мянган га нутаг дэвсгэрийг хөгжүүлэх 5 төрлийн төсөл хэрэгжиж байгаа. Гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр барилгажуулах, дэд төвүүдийг хөгжүүлэх, олон нийтийг төвийг хөгжүүлэх гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах, сервис центр гэсэн ийм төслүүд хэрэгжиж байгаа. 9 мянган га нутаг дэвсгэрийн маань 4 мянган га дээр энэ 5 төсөл маань төлөвлөлт зураг төсөл нь батлагдчихсан хэрэгжиж байдаг.

Хоёр дахь бүсчлэл буюу яг 10 мянган га дээр бол инженерийн хэсэгчилсэн төлөлтийг бол илүү түлхүү хөгжүүлнэ. Нийтдээ 2017 онд Засгийн газрын 179 дүгээр тогтоолоор Бүгд Найрамдах Хятад ард улсын буцалтгүй тусламжаар одоо 50 байршил дээр ийм сервис центр байгуулах тогтоол шийдвэр гарч байсан. Үүний дараа бол НИТХ хурлаас эхний 16 байршилыг тогтоосон. Энэ 16 байршил дээр хамгийн сайн хэрэгжиж байгаа байршил нь бол

энэ ЧД-ийн 7 дугаар хороон дээр бол хэрэгжиж байгаа. Нийтдээ 220 нэгж талбар айлийг шугам сүлжээнд холбож шийдвэрлэсэн ийм асуудал байгаа.

Тэгэхээр энэ цаашидаа яг энэ төслийг үлдсэн 2 дугаар бүсчлэл буюу гэр хорооллын 10 мянган га талбай дээр хэрэгжүүлээд явах бүрэн боломжтой.

**Л.Мөнхбаатар:** Сая Хан-Уул дарга хариулчав уу тэ? Манай ажлын хэсгийнхэн бас албан тушаал нэрээ хэлээд яваад байгаарай. Тэгэхгүй протоколд хэн асуугаад хэн хариулсан нь их тодорхой үлддэг учиртай шүү. 82 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсэг нэмж хариулъя. 83 дугаар микрофоныг өгье.

**Э.Батболд:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

БХБЯ-ны хөгжлийн бодлого Газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Батболд байна аа. Дархан-Уул аймаг дээр 2 мянга нийтдээ 100 орчим тэрбум төгрөгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг залуус орон сууцын хорооллыг дэмжих хүрээнд дэмжигдээд зураг төсөл нь батлагдаад магадлал нь гараад явсан байгаа. Тэгээд үүнээс бол 2024 онд 42 тэрбум төгрөгийн санхүүжилттэй ажлыг эхлүүлэхээр төсөвт тусгагдаад энэнийх нь дагуу холбогдох ажлыг зохион байгуулаад ингээд явж байгаа.

Нөгөө улсын төсвөөр энэ дээр нөгөө энэ залуус хороололтой холбоотойгоор дэд бүтцийг нь тавихаараа гэр хороололтой уялдуулах байдлаар энийг залуусыг хорооллыг орон сууцжуулна гээд дахин төлөвлөлтийн хүрээнд энэ явагдаж байгаа төсөл нь юм байна лээ.

**Л.Мөнхбаатар:** Асуулт хариулт болчихсон уу? Тодруулах юм уу та? Нэг удаа тодруулж асууж болно. Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулъя.

**Б.Баттөмөр:** Яах вэ тэгээд ер нь Улаанбаатар хоттой холбоотой асуудал ярьж байна. Би Дарханы тэр Монгол Улсын төсвийн хориод тэрбум төгрөгөөр хийчихсэн 19 км шугам л асуугаад байгаа шүү дээ. Яамны энэ залуучууд, газрын дарга нар хариулахгүй шал өөр юм яриад. Тэр залуус-1, залуус-2 хороолол тэртээ тэргүй орон сууцын хороолол зуугаад тэрбум төгрөгийн ажил төсөвт өртөгтэй 2024 онд 42 тэрбум төгрөгөөр хийгдээд явна. Тэр гэр хороолол руу татчихсан 19 км шугам танай яамны бодлого, танай яамны бүртгэлд танай яамны бодлогод байна уу үгүй юу? Сая бид нар хөөцөлдөж байгаад 400-аад 475 тэрбум төгрөг олоод ерөнхий төлөвлөгөөг нь хийсэн. Харьцангуй Монгол төгрөгийн хани чанга байх үед хямд үнээр хийчихсэн ийм шугам сүлжээ байгаа юм аа.

Тэгээд та нарт тийм мэдээлэл байдаг бол энэ мэдээллийг аваад яам салбарын яам байна. Энэ дээрээ бодлогоо явуулж байна.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хороон дарга Энхбаярын Батшугар асуултаа асууя.

**Э.Батшугар:** Баярлалаа тийм. Ер нь нийслэлийн энэ агаарын бохирдол, хөрсний бохирдлыг шийдэх хамгийн зөв арга бол орон сууцжуулах л даа. Гэхдээ бол тодорхой манай улсын төсөв манай эдийн засгийн хязгаарыг бид нар ойлгож байна. Нийтдээ 150 мянган орон сууц барих гэхэд л дор хаяж 30 их наяд төгрөг хэрэгтэй гэх мэтчилэн тооцоонууд байгаа.

Тэгэхээр одоо бусад эх үүсвэр ялангуяа ногоон хөгжлийг дэмжих сан, аль эсвэл өөр хямдхан эх үүсвэр эсвэл хувийн хэвшилтэйгээ хамтарч яаж 100, 150 мянган орон сууцыг барих вэ гэдэг тийм юман дээр тод судалгаа байна уу? Миний бодлоор бас нүүрс хүчлийг бууруулахтай холбоотойгоор нөгөө нэг карбон кредитээ авч тодорхой

хэмжээгээр бас эх үүсвэр татаж болдог л юм байна лээ л дээ. Тэгэхдээ тэр нь яах вэ Парисын протокол, Токио протокол эд нараас судалж байж яг ямар гарц байна гэдгийг нь харж байгаа. Харах нь зөв л бодож байна. Тэгээд энүүн дээр судалсан ямар нэгэн тооцоо судалгаа байна уу гэж асууя.

Хоёрт нь бол дулааны эх үүсвэрийн талаар бас Баттөмөр гишүүн хэлж байна. Энэ инноватик лог дэлхийд бас гараад ирчихсэн байна. Тэгээд нэгдсэн сүлжээ гэхээс илүүтэй тийм дэд бүтцүүдээр хөгжүүлэх нь хамгийн зөв гэж харагдаж байна. Ялангуяа сүүлд харахад Вен улс, Мюнхен улс гэх мэтчилэн улсууд бол тийм нэгдсэн дэд бүтцээсээ салаад энэ газрын дулааныг ашиглаж гео термилээр дэд бүтцээ хийгээд байна л даа дулааны эх үүсвэрээ. Тэгээд өнөөдөр технологи сайжирчхаад нөгөө тэр нь нэлээн хямд эх үүсвэртэй болчихсон. Тэгээд Мюнхен хотыг харахад судлахад уншихад бол ерөнхийдөө 1.7 сая доллароор 4 мянган айлын өрхийг халаах тийм дэд бүтэц бүрэн хэрэгжүүлээд байна л даа.

Тэгэхээр энийгээ Монголд нэвтрүүлэх бололцоотой аль эсвэл хийсэн судалгаа байна уу? Өнөөдрийн хувьд ялангуяа нөгөө нэг өрөмдөхөөр нэг метр өрөмдөхөд 7-гоос 4 градусаар хэрвээ газрын доодох гүн нь нэмэгдвэл тэр нь бүрэн эдийн засгийн хувьд ашигтай гэж гардаг. Тэгэхэд бол Монголд яг харьцуулж харахад бол өнөөдөр үйлдвэрлэж байгаа дулаан нэг кило жулиар нь бодвол өнөөдрөөс бараг 8 дахин хямдхан Герман улсад, Австри улсад хэрэгжүүлээд үйлдвэрлээд байгаа дулаан нэг кил гэж үлгэрээр нь бодоход тэгэхээр энэ дээр судалгаа хийсэн тал байдаг уу гэж асууя. Хоёр асуулт байна. Баярлалаа

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн сайд хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Ялангуяа гэр хорооллын хувьд нөгөө орлогод нийцсэн орон сууц гэдэг юм чинь л хэрэгжихээс өөр аргагүй болчихоод байгаа юм. Одоогийн энэ ипотекийн зээлийн санхүүжилтийг авч байгаа байдлыг ингээд судлаад үзэхэд дийлэнх нь орлогын боломжтой 2-оос дээш сая төгрөгийн орлоготой иргэд л байгаа байхгүй юу. Тэгээд гэр хорооллынхон маань дийлэнх нь бага орлоготой. Тэгэхээр энийгээ яах юм бэ гэж. Тэгэхээр энүүгээр бид нар Засгийн газарт ойрын хугацаанд бол энэ оны ер нь яг төгсгөлөөр энэ орон сууцын санхүүжилтийн ерөнхий концепцыг бол Засгийн газраас батлах байх. Бид нар бол энэ орлого багатай иргэдэд бол аль болох хямд орон сууцыг барих тэгэхдээ мөн түрээсийн орон сууцын тогтолцоог л хэрэгжүүлж гэж бодож байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад олон жилээр түрээсэлдэг тэр орон сууцын тогтолцоонуудыг хэрэгжүүлнэ ээ гэж ингэж төлөвлөж байна аа. Энэ бол дэлхий нийтийн бас нэг чиг хандлага.

Тэгээд ер нь хямд орон сууцыг төрөөс барилддаг тогтолцоо руу нэг хэсэг одоо тэгээд л шуугиан гарах л байх л даа. Төр хувьтай зэрэгцлээ гээд л. Арилжааны маягаар орон сууц барилдаад явах юм бол тэр гэр хорооллын иргэд худалдаж авч чадахгүй ээ. Тийм учраас Төрийн орон сууцын корпорац нь захиалаад аль хямд байдлаар барих асуудлыг анхаарна гэж. Дулаан хангамжийн асуудал дээр бол ер нь янз бүрийн эх үүсвэрээс гадна бас нэг анхаарах ёстой юм бол дулаан алдагдалгүй орон сууц хамгийн чухал байхгүй юу. Одоо бид нар бүх байрныхаа дулаан алдагдлыг шийдэж чадах юм бол ахиад нэг дулааны станц гаргаад ирж чадна. Бид нар зүгээр үйлдвэрлэсэн дулааныг салхинд хийсгээд сууж байгаа ард түмэн байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дулаан алдагдалгүй орон сууцжуулах, дулаан

алдагдалгүй болгох чиглэлд нэн тэргүүнд бид нар анхаарах шаардлага байна гэж.

Хоёр дугаарт бид нар тэр янз бүрийн юмнуудыг судалж үзэж байгаа. Жишээлбэл Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банк, тэгээд НҮБ-ын байгууллагуудтай хамтраад бас энэ сэргээгдэх эрчим хүчийг ашиглах энэ бололцоонуудыг нэлээн судалж байна. Тэр газрын гүний дулаан бол өртөг өндөртэй болно. Тэр бас жоохон төвөгтэй. Манайх бол маш их нартай нарлаг орон байхгүй юу.

Тийм учраас нарыг л ашиглах боломж харьцангуй илүү. Тэгээд өдөр нь нарыг усаар халаагаад тэрийгээ нөгөө газрын хөрсөнд булчихсан нөөцийн саванд хадгалчихдаг. Тэгээд тэрийгээ ингээд эргэлдүүлээд халаагаад л шөнөдөө эргэлдүүлээд л өдөр халаагаад байдаг энэ технологийг бид нар хит памп гээд мөн бас ингэж хосолмол технологитой хамтруулаад туршиж үзье гэдэг энэ саналыг бид нар олон улсын байгууллагуудтай нэлээн яриад явж байна аа. Энэ бол хамгийн боломжтой хэрэглэж болох ийм технологи. Бид нар СХД-ийн арын бас нэг яг I дүгээр хорооллын ард талд тодорхой хэсэг айлууд дээр бас ийм зураг төсөв хийчхээд ингээд явж байна. Энэ хэрвээ ингээд амжилттай болоод явах юм бол бид нар түрүүний миний хэлсэн өндөрлөг газрууд дээр дулааны шугам очих бололцоогүй газрууд дээр бол бид нар энэ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нарыг ашигласан энэ технологиудыг нэвтрүүлэх чиглэлд туршилтууд хийж үзнэ. Би энийг бүрэн боломжтой хамгийн байж болох ийм зүйл гэж бодож байна. Ялангуяа манай сумуудын дулааны асуудлыг бид нар ингэж л шийдэх ёстой. Маш өндөр зардлаар шийдэж байгаа шүү дээ одоо. Ийм нартай орон мөртөө бид нар тэрийг ашиглаж чадахгүй байгаа юм.

Хэрвээ нараар бид нар шийдэх юм бол бүх сумдын дулааны асуудлыг маш

хямдханаар шийдэх ийм бололцоо өнөөдөр дэлхийд технологийн хувьд шийдэл нь гарчихсан юм байгаа юм. Энийг л ашиглана гэсэн ийм бодолтой байгаад байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулъя. Говьсайхан дарга байгаа. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

**Говьсайхан:** Нийслэлийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирал Говьсайхан Батиугар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Нийслэлийн хувьд олон улсад хэрэгжиж байгаа ногоон орон сууцны чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг бас судалж үзэж байгаа. Ингээд нийслэлд орлогод нийцсэн ногоон орон сууц төслийг бас БЗД-ийн 19 дүгээр хороо, СХД-ийн 9 дүгээр хороон дээр бас Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй 114 сая төгрөгийн 1500 айлын орон сууцны төслийг бас эхний ээлжийн 880 айлын төслийг бас эхлүүлээд явж байгаа. Энэ төсөл маань эрчим хүчний хэмнэлттэй сэргээгдэх эрчим хүч ашигласан цэвэр, бохир усны хэмнэлттэй ийм бас ийм жишиг ногоон орон сууцыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжиж байгаа төсөл байгаа. Мөн одоо бид цаашилаад энэ дэд төвүүдийг түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах энэ төслийн хүрээнд бас уур амьсгалын ногоон сангаас 95 сая долларын санхүүжилтийг бас энэ дэд төвийг хөгжүүлэх орон сууцны төсөлд оруулахаар энэ дэд төвийг түшиглэсэн төслийн хэмжээнд хийгдэх нийт 12 мянган айлын орон сууцны 30-аас доошгүй хувьд нь бас ийм ногоон орон сууцны технологийг хэрэгжүүлсэн ийм орон сууцны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр явж байгаа.

Одоо ингээд төвлөрсөн дэд бүтцийн хангамж хүрэлцээгүй байгаа ийм нөхцөлд бид хэсэгчилсэн сан болон бие даасан инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх ийм зайлиггүй шаардлага

байгаа. Нийслэлийн орон сууцны корпорацийн хувьд бас төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бид Хайбрид хаус компанитай хамтарч нийслэлийн хэмжээнд БЗД-т, мөн СХД-ийн 31 дүгээр хороон дээр нарны эрчим хүчийг ашигласан эрчим хүчний хэмнэлттэй ийм хайбрид хаусыг 2 айлын газар чөлөөлөөд 8 айлын орон сууц хэлбэрээр 2 байриилд нийт 16 айлын орон сууцны төслийг жишиг загвар маягаар туршилтын байдлаар хэрэгжүүлээд орон сууц бүрэн ашиглалтад орсон. Эхнээсээ хүмүүс нь орж байгаа. Энийг бас бид энэ өвлийн яг хүйтэнд бас туршиж үзэх үнэхээр энэ нарны эрчим хүчээр бас халж байна уу, яг одоо шаардлага хангаж байна уу гэдгийг бид хэд бие даасан байдлаар бас шийдвэрлэж ингээж үзээд явж байгаа.

Мөн одоо Нийслэлд дэд бүтцийн төвүүдийг 16 ширхэг дэд бүтцийн төвийн байриил, хэмжээ хязгаарыг ингээд тогтоогоод хэсэгчилсэн байдлаар энэ дэд бүтцийн хангамжийг бий болгох зорилгоор энэ дэд төвүүдийн ажлыг хийж хэрэгжүүлэхээр зорьж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодорхой хариулчихлаа тийм ээ. Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Энэ асуулгын хариултыг өнөөдөр сонсож байгаад талархаж байна. Яг үнэнийг хэлэхэд энэ 2020 оноос хойш ялангуяа нөгөө ковидын үе ковидоос хойш, нийслэл Улаанбаатар хотод хамгийн орхигдсон бараг тэг зогсолт хэмжээнд байгаад байгаа асуудал бол энэ гэр хорооллыг орон сууцжуулах дэд бүтэцжүүлэх энэ асуудал байгаа юм. Тэгээд учир шалтгаан нь юунаас байна гээд л БХБЯ-ны тухайн үеийн 2020, 2021 онд алба хашиж байсан хүмүүс нийслэлийнхнээс асуухаар төсөвт мөнгө суулгасан. Гэхдээ татагдчихсан. Мөнгө нь өөр тийшээ шилжчихсэн гэх мэтээр энэ ажил дэндүү удааширалтай байгаа юм. Ялангуяа уг нь энэ орон сууцжуулах дэд бүтэцжүүлэх



ажил БХБЯ-ан дээр байхад шугам хоолой татах энэ тэр ажил бол нэлээд хурдацтай явж байсан. Гэтэл нийслэл дээр зарим нь хариуцаад эхлэнгүүт ингээд үнэнийг хэлэхэд маш удаа удааширалтай байгаа. Жишээ нь 2013 онд шүү дээ. Дахин төлөвлөх барилгажуулах ажлын хүрээнд Чингэлтэй дүүрэгт төсөл хэрэгжүүлэх, сонгон шалгаруулах шаардлагатай 4 хэсэгчилсэн талбай бий болсон. Одоо энэ дээр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо 8, 9, 10, 11, 12 гээд энэ дээр 8 хэсэг талбай байгаа. Газар заримыг нь чөлөөлөөд тэгээд иргэдийг түр орон сууцанд оруулаад удахгүй энэ чөлөөлсөн газар дээр чинь байшин барилга барина гээд баахан компаниуд шалгаруулсан. Энэ Бат-Үүл даргын үед. Дараа нь солигдчихсон. Яг энэ төслүүд зогсчихсон. Одоо айлууд хохирсон. Ёстой нэг цөөн хэдийг нь бид нар 2016-аас 2020 оны үед хөөцөлдөж гүйж БХБЯ-ныхантайгаа ярьж байж төсөвт хөрөнгө мөнгө суулгаж байж 7-оос энэ 11, 12 дугаар хороодод 40 гаруй тэрбум төгрөгийн харин шугам хоолой татсан. Өөрсдөө хөөцөлдөж байж яг бараг л нөгөө барилгын ажилтан шиг л хөөцөлдсөн. Ингэж нийслэлийг ч шахсан. Одоо тэгээд энэ дээрээ барилга байшин барья ямар ч байсан шугам хоолой маань бэлэн болчихлоо гэсэн.

Гэтэл өнөөдөр энэ дээр барилга байшин баригдахгүй байгаад байна аа. Ялангуяа нөгөө нийслэл маань энийгээ шалгаруулаад тэр хүчингүй болсон компанийг нь болиулаад шүүх дээр маргалдаад удсан л даа. Босманаас өгсүүлээд л тэд нар нь бүгд ингээд больсон гэсэн. Эрэл мэт гээд эхлүүлэх үү? Яах вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч ээ. Яагаад гэвэл тэнд дэд бүтэц нь татагдчихсан. Миний нэг энэ асуултыг би нийслэлийнхнээсээ хариултыг авъя.

Хоёр дахь асуулт нь Даваасүрэн сайдаас сая бид нар нөгөө нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулж гэр хорооллыг орон сууцжуулах

хууль гаргасан. Энэ хуулийг дагалдаад гэр хорооллыг орон сууцжуулахад оролцож байгаа компаниудыг гааль, НӨАТ-аас чөлөөлөх ийм заалт оруулсан. Энэ нь өөрөө том компаниудыг хүчтэй, мөнгөтэй, хүний нөөцтэй компаниуд гэр хор хорооллын орон сууц руу орох сонирхлыг бас татаж байгаа. Тэгэхээр энэ ажлыг бид нар бас түргэтгээд ингээд явчихвал гэр хорооллоо нийслэлийнхээ гэр хорооллуудыг орон сууцжуулах бололцоо уг нь эрх зүйн хувьд бүрдэж байна. Санхүүжилтийн хувьд сая нийслэл бас газар чөлөөлөлтийн хөрөнгө мөнгөнүүдийг суулгасан гэж хэлж байсан.

Тэгэхээр энэ 2 дээр би эхлээд тодорхой хариулт авчхаад дараа нь тодотгож асууя гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Хэддүгээр микрофон билээ. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

**Г.Ганхүү:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Нийслэлийн орон сууцын бодлогын газар Ганхүү байна. Чингэлтэй дүүргийн хувьд нийтдээ дахин төлөвлөлтийн 8, 9 талбай байдаг. Үүнээс 4, 9 гэсэн талбай нь бол төсөл хэрэгжүүлэгчгүй байгаа. Энэний үндсэн шалтгаан нөхцөл гэх юм бол бас урьд нь төсөл хэрэгжүүлж байсан компаниуд маань нийслэлийн зүгээс эрхийг нь үйл ажиллагааны хувьд доголдолтой байна гэдэг талаар нь хяналтын хороогоор оруулаад үйл ажиллагааг нь цуцалсан. Гэвч дээрх компаниуд маань шүүхийн маргаан үүсээд хяналтын шатны шүүх хүртэл яваад энэ 2023 оны 6 сард шүүхийн маргаанууд маань эцэслэгдэн дууссан байгаа. Одоо бид нар 2024 ондоо энэ дахин төлөвлөлтийг эрчимжүүлэх тал дээр ажлаа төлөвлөөд явж байна. 2024 онд бид нар үлдсэн 4 байриил дээрээ сонгон шалгаруулалтаа зарлаад төсөл хэрэгжүүлэгч нарыг шалгаруулж оруулах

ажил бэлтгэл ажил хангагдаад явж байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Та яах юм нэмэх юм уу сайд? Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, сайд нэмж хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Тэр Оюунчимэг гишүүний асуугаад байгаа гэр хорооллын дахин төлөвлөлтөд оролцож байгаа компаниудыг гааль, НӨАТ-аас чөлөөлөх тухай асуудал саяхан хэлэлцэгдэж шийдэгдсэн, тийм ээ. Тэгэхдээ энэ бол мэдээж хэрэг том төлөх зүг нь байх. Хуулийн хэрэгжих хугацаа эхэлснээс хойш яг тодорхой ахиц дэвшил гарна гэдэгт эргэлзэхгүй байна. Ер нь бол бид нар цаашид нэг энэ дээр бас судалж байгаа юм нь гааль, НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг хийхэд жоохон төвөгшилтэй байж магадгүй гэж би зүгээр бодож байгаа. Тийм учраас бол уг нь бусад оронд түгээмэл хэрэг гэдгийг орлогын албан татвараас нь чөлөөлчихсөн байдаг. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтийг харж байгаад бид нар бас энэ ер нь цаашид аль татвар нь оновчтой байх нь вэ гэдгийг бас судалж үзэж эргэж бас Их Хуралд оруулж ирнэ ээ гэж ингэж бодож байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу тэ? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя. Нэг минут.

**М.Оюунчимэг:** Энэ гэр хорооллыг орон сууцжуулах, дэд бүтчүүлэх гэдэг нь өөрөө 1 дүгээрт яндангаас салгаж байгаа тийм ээ. Ингээд яндангүй болж байна энэ чинь утаагүй болж байна гэсэн үг. Нөгөө талаасаа нүхэн жорлонгуудаас салгах гол бодлого явж байгаа. Яагаад гэвэл одоо нийслэл Улаанбаатар хотын хувьд энэ гэр хорооллын газар нутгийн 85-аас илүү бараг ер орчим хувь нь хамгийн дээд зэргээр бохирдсон бүр үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид хүрээд энэ цаашаа явбал нөгөө өвчлөл бүүр хүний эрүүл мэндийн хувьд бараг л хамгийн ноцтой түвшинд хүрчихсэн. Бид нар бүүр зургийг нь энд агаараас авсан,

сансраас авсан зургийг нь ингээд харахад тэр чигээрээ ингээд ногоон болчихсон ийм байгаад байгаа.

Тиймээс бид нар энэ дэд бүтэцжүүлэх орон сууцжуулах гэдэг нь нөгөө талаасаа нүхэн жорлонгоос салах бодлого байгаад байгаа юм. Бид нар овоо төсөв дээр нөгөө эко 0, шинэ хороо төсөл гээд хэрэгжүүлээд явсан. Маш олон иргэд нүхэн жорлонгоосоо салж орчин үеийн эко 0-той болох сонирхол ингээд байгаад байгаа. Тэгээд энэ тал дээр Даваасүрэн сайд ер нь энэ бодлогууд цаашаа яаж явах бол оо?

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн сайд хариулах уу? Барилга, хот байгуулалтын сайд Даваасүрэн хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Ер нь бол энэ нүхэн жорлонгуудыг багасгах энэ хөрсний бохирдлыг бууруулах асуудал зайлиггүй хийгдэх ёстой ийм ажил. Тэгээд энэ хүрээнд хийгдээд явж байгаа ажлууд бол байгаа. Гэхдээ энэ том өргөн хүрээг хамарсан гэр хорооллын юуг шийднэ гэдэг бол асар их хэмжээний хөрөнгө мөнгө шаардагдах ийм ажил юм байна лээ. Тийм учраас бид нар ингээд хэсэгчилсэн инженерийн дэд бүтцүүдийг л байгуулаад л тэгээд тэр төвлөрсөн цэвэрлэх байгууламж руу холбох, мөн хэсэгчилсэн цэвэрлэх байгууламжууд руу холбох ийм ажлуудыг л цаашид ингээд эрчимжүүлээд хийгээд явах ёстой. Тэгээд энэ хашаандаа сайхан амьдаръя, жорлонгоо шинэчилъе, жорлонгоо өөрчилъе гээд л ингээд яваад байгаа энэ санаачилгууд би маш зүйтэй гэж ингэж бодож байгаа. Ер нь одоогийн байдлаар 3700 нүхэн жорлонг шийдэж шийдвэрлэсэн гэсэн ийм.

**Л.Мөнхбаатар:** Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууя.

**Ж.Батсуурь:** Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулах асуудал бол маш олон зүйлийг шийдвэрлэх ийм цөм асуудал. Тэгээд та бүхэн маань дэд төв,

хэсэгчилсэн төв, бүсчилсэн нар салхи тэрийг туршиж байна. Туршиж байна гэж олон зүйлийг ярьж байгаа, мэдээж хичээж байгаа байх. Гэхдээ энэ ярьж байгаа зүйлээр бол бидний өмнө бөөгнөхөөд байгаа асуудлууд шийдэгдэхгүй байх л даа.

Тэгэхээр ер нь яг алсыг харсан бүр их наядаар хэмжигдэх том төлөвлөлт байна уу? Тэгэхээс бид нар ингээд бие биеэ хуураад л нэг нь асуугаад л нэг нь хэлээд л. Би ойлгохдоо юу гэдэг юм жишээлэх юм бол Багануур хүртэлх замыг 6 эгнээтэй болгох, 6 эгнээтэй болгож байхад зам нь баригдаад дуусаж байхад тэнд 100 мянган айлын орон сууц барьж байх жишээний ч гэдэг юм уу. Төв аймагт 20 мянган айлын орон сууц баригдаж байхад уулаар тойроод очих зам нь 6 эгнээ болох юм уу уулаа нүхлээд очих хэмжээний ч гэдэг юм уу ийм том төлөвлөлт ер нь байна уу, байдаггүй. Жишээлэх юм бол боломж байдаг шүү дээ. 20 их наядыг ковид гэж хөөрөөд л сая энэ 3 жилд хусчихсан шүү дээ. Эзэн биет байхгүй 20 их наяд шүү дээ. 20 их наяд гэдэг бол нэг айлд 100 сая төгрөгийн дэмжлэг өгөхөд 200 мянган айл яндангаас салчих. 200 мянган айл яндангаас сална гэдэг чинь 500, 600 мянган айл ингээд босож байгаа. Тэгээд нүүрсний их наяд. Би ямар нэгэн улс төрийн өнгө аясаар хармааргүй байна л даа. Тэгээд энэ бас олон удаа Их Хуралд сонгогдсон энэ зангаргатай сайд байгаад байна.

Тэр 2025 он хүртэл гэдэг юм уу 2030 он хүртэл бид нар бол нэг ийм төслийн ард гарахад бол энд явж байгаа энэ та нарын ярьж байгаа зүйлүүд бол хэзээ нэгэн цагт хэн нэгэн сайдын үед бол байнга л яригдана. Нэг дэд төв бүсчилсэн явж байна, явахгүй байна нэг нэр өгөөд. Тэгээд энүүгээр бол бид нар бидний нарын нас гүйцэхгүй ээ.

Тийм учраас ийм том бүтээн байгуулалт 10 их наядыг ингэж эхлүүлнэ ээ. Зураг нь хийгдэж байгаа ч гэдэг юм

уу. Бүүр энэ зураг нь хийгдээд дууссан Дэлхийн банк гадна, дотнын донор орнуудын мөнгө төгрөгийг авъя ч гэдэг юм уу ийм байдлаар асуудалд л хандмаар санагдаад байх юм.

Дээр нь Улаанбаатарын төвлөрөл чинь утаа униар саяын энэ бохирдол гээд бүх юмнууд байж байна. Хүмүүсийн амьдралын чанартай л холбоотой байгаа байхгүй юу. Ядуурал. Тийм учраас би энэ аймгуудад амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар, сумдад амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар эдгээр зүйлийг шийдэхэд би бол энэ түгжрэлийн яг энэ түгжрэлтэйгээ л ноцолдоод байх юм. Энэ яг байгаад нэг тэр хатгитайгаа л ноцолдоод. Тэр хатги яаж үүсэж байна вэ гэдэг тэрийг яаж эдгээх вэ гэж одоо 2030 он хүртэл 2040 он хүртэл гэсэн ийм том төсөл байна уу, эхлүүлсэн юм байна уу? Мөрөөдөж байгаа юм байна уу? Мөнгөнийх нь хэмжээг тооцсон юм байна уу л гэсэн зүйлийг асуумаар байна. Тийм тодруулъя.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулах уу? Даваасүрэн сайд хариулъя.

**Ж.Батсуурь:** Батсуурь гишүүн чухал асуудал хөндлөө. Тийм л дээ ер нь бол нийслэл хот сүүлийн 2 жил төлөвлөлтгүйгээр явж байна. 2020 онд төлөвлөгөө нь дуусчихсан. Тийм учраас ажил аваад миний нэг анхаарсан юм бол энэ Нийслэл хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гэж байгаа юм байна лээ. Тэр дээр ажиллаж байна. Тэгээд өмнөх төлөвлөгөөний төслийг сайжруулах шаардлага байгаа учраас энэ дээр нэлээн нарийвчилъя аа. Тухайлах юм бол Улаанбаатар хотын шинэчилсэн энэ төлөвлөлтөөр аль чиглэлдээ илүү хөгжих юм, шинэ суурьшлын бүсүүд нь хаагуураа байх юм гэдэг ч юм уу, Хөшигтийн хөндийг дагаж наашаа хотын энэ баруун урд талын хэсгийг ингэж хөгжүүлээд явах төлөвлөлтүүдийг бүүр нарийн хийж өгье гэж.

Тийм учраас энэ 2040 гэдэг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө оруулж ирэх гэж байсныг хойшлуулчихсан байгаа. Энэ дээр бас бид нар гаднын нэлээн энэ дээр туршилага хуримтлуулсан экспертний баг, зөвлөх компаниудыг бас авч ажиллуулаад тэгээд ингээж байгаад нэлээн бодитой бас нэг хэрэгжихээр төлөвлөлтийг оруулж ирье гэж ингээж бодож байгаа.

Хэрвээ ингээж чадах юм бол яах вэ тэр төлөвлөж байгаагаар бол 2040 он гэхэд Улаанбаатарын гэр хорооллын орон сууцын 80 хувийг барилгажуулна гэж байгаа юм байна лээ. Тийм ингээж чадвал гэхдээ манайд ингээж төлөвлөдөг баримт бичгүүд хангалттай л байгаад байх шиг байгаа юм л даа. Гол нь нөгөө төлөвлөсөн баримт бичгүүд дээрээ яг хөрөнгийг нь тавиад хэрэгжүүлээд явах гэдэг дээрээ л байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас хэрвээ ингээд одоо 2040 он хүртэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөө оруулж ирлээ гэхэд яг тэр тухайн жилд нь байх хөрөнгийн асуудлуудыг нь нийслэлийн, орон нутгийн, улсын төсвөөр ингээд хэрэгжүүлээд явчих юм бол энэ хэрэгжинэ. Төлөвлөлтийнх нэг өөр тэрийгээ хэрэгжүүлэх тэр санхүүгийн эх үүсвэрийг нь тавиад явах 2 бас өөр болчихоод байгаа байхгүй юу. Гол алдаа гарч байгаа юм нь тэр хөрөнгө санхүү, гүйцэтгэл дээрээ байгаад байгаа юм. Хөрөнгө санхүүг нь шийдэж өгөхгүйгээс. Тэгээд энэ яг нийтдээ одоогоор эцэслээгүй. Зүгээр нэг төсөл хийсэн юм байна лээ. Манай энэ хотын төлөвлөлтийн институт. Яг ямар өртөгтэй болсныг нэг хэлээд өг. Нэмээд хэлээд өгчих тэрийг.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 87 дугаар микрофоныг. Нэмж хариулья.

**Д.Хан-Уул:** Нэмж хариулья аа. Энэ Нийслэлийн Ерөнхий архитектор Хан-Уул байна. Сая Даваасүрэн сайд дурдсанчлан 2040 он хүртэлх хөгжүүлэх

ерөнхий төлөвлөгөөний суурь судалгаа боловсруулагдах ажил нэлээд цэцэрчихсэн байж байгаа. Энэ өмнөх ерөнхий төлөвлөгөөнүүд хэрэгжээгүй шалтгааныг ч гэсэн бас сая ер нь тайлбарлачихлаа. Тэгэхээр одоо 2040-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр бол байгаль орчинд, нийгэм эдийн засагт, орон зайн зохион байгуулалтад зам тээврийн бүтцэд инженерийн дэд бүтцэд инженерийн бэлтгэл арга хэмжээнд хэчнээн хөрөнгө оруулалт шаардлагатайг нарийвчлаад тооцчихсон байгаа. Одоогийн гаргасан судалгаагаар нийт төсөв нь 141.7 их наядаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Улаанбаатар хотыг хөгжүүлэхэд энэ хэмжээний бүтээн байгуулалт хийхэд 141.7 их наяд хэрэгтэй гэсэн ийм нэгдсэн тоо байгаа.

Энэ дээр бол зам тээврийн бүтцийг шинэчлэн сайжруулахад түгжрэлгүй болгоход 13.3 их наяд инженерийн дэд бүтцийн эх үүсвэрийг сайжруулах, шугам сүлжээг нэмэгдүүлэх энэ ажил дээр 19.1 их наядын санхүүжилт хэрэгтэй гэсэн ийм тооцоолол байгаа. Мөн энэ онд Улаанбаатар хотод анх удаагаа инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө батлагдсан. Энэ инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөгөөр Улаанбаатар хотын бүх үер усны хамгаалалтын далан сувгийг шинэчлэн барилгажуулах 4 үе шаттай барилгажуулах үүнтэй зэрэгцээд Туул усан цогцолборыг барьж байгуулах энэ төсөв тооцоо мөн батлагдчихсан. Төсөв нь байвал л хэрэгжүүлэхэд бэлэн болсон байгаа.

Инженерийн арга хэмжээний мастер төлөвлөгөөг иж бүрэн хөгжүүлэхэд бол 4.2 их наяд төгрөгийн ийм санхүүжилт шаардлагатай байгаа.

**Л.Мөнхбаатар:** Жамбын Батсуурь гишүүн юу тодруулж асууя. Дэгээрээ нэг л минут байна. Тийм нэг минут угаасаа дэгээрээ ийм. 3 минут нэг



минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж тайлбар авах түүнд хариулах нь бас нэг минутаас илүүгүй байна гэсэн дэгтэй. Дэг зөрчихгүй. Та яах юм, нэг минутаа авах юм уу Батсуурь гишүүн ээ?

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Батсуурь гишүүн тодруулж асууя.

**Ж.Батсуурь:** Би ингэж л боддог л доо. Нийслэлийн нэг хэсэг бол Багануур дүүрэг. Тэгээд Багануур руу энэ чинь нөгөө хотоо барихад чинь нүүрс рүүгээ л ойртох ёстой. Тэгээд л Хөшигтийн хөндий гээд л ингээд л явснаас нүүрс дээрээ дөхүүлээд л жишээлэх юм Багануурт тэр гоё газар гэр хорооллыг нь өгөөд байдаг байхгүй юу. Тэрийг жишээлэх юм бол надад хамааралгүй л дээ. Тэгэхдээ хажуугаар нь гарч явахдаа л хардаг байхгүй юу. Бүтэн хот барьчих газарт ахиад л уулан дээр байгаа байшингууд чинь тэнд баригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр эндээс гэхэд л 6 зам очлоо. Багануур руу яах вэ цаг л явдаг шүү дээ. Тэгэхэд бид нар уулын ам руу 3 цаг түгжирч байгаа байхгүй юу. Тэгэхэд үнэхээр нийслэлийн том бодлого байдаг бол тэр сайхан байгууламж, тэр сайхан нүүрсний уурхай, дулааны станц, цахилгааны станцынхаа тэнд гэр хорооллыг өгөхгүйгээр тэнд орон сууцнууд бариад тэр рүүгээ зам татлаа л гэх гээд л нэг хэсэг хүн гээд л хэдэн зуун мянган айл ингээд л явах ёстой.

**Л.Мөнхбаатар:** Жамбын Батсуурь гишүүн их чухал санал хэллээ. Нэг минутад багтааж их чухал санал хэллээ. Саналыг Барилга, хот байгуулалтын яамныхан тусгаж хүлээж авах нь зүйтэй. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя.

**Х.Булгантуяа:** Манай Баянзүрх дүүрэг дээр бас их олон дахин төлөвлөлт явж байгаа. Хоёр дугаар хороо 8, 12, 13,

14, 16 дугаар хороод дээр. Ерөөсөө ганцхан том асуудал, дэд бүтэц байхгүй. Зарим нь ашиглалтад орчихсон нөгөө байр нь. Ашиглалтад орчихсон мөртөө дэд бүтэц байхгүйгээс болоод барилгын ажил нь дуусчихсан ч гэсэндээ ингээд айл өрх орж чадахгүй. Ингээд нөгөө компани ч хохироод, дахин төлөвлөлтөд орсон иргэд нь ч хохироод сууж байна аа. Тэгээд энэ жишээлбэл манай Баянзүрх дүүргийн 12 дугаар хороон дээр 6 компани дахин төлөвлөлт хийсэн. Амгалан ДЦС-ын өргөтгөлийн ажил нь ингээд ашиглалтад орсон мөртөө орж байгаа мөртөө тэрүүнд хүрэлцэхээргүй хэмжээний тийм олон барилга байгууламж баригдчихсан.

Тэгэхээр энэ дэд бүтцийнхээ асуудлыг ер нь цаашидаа та бүхэн яая гэж бодож байгаа юм бэ? Бид нар ийм болчихоод байна. Иргэд олон нийт ойлгохгүй байж магадгүй. Төрийн нөгөө нэг Төсвийн хуулиар, дээрээс нь нэмээд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар ер нь энэ Улаанбаатар хотын зарим дэд бүтцүүд тохижилтын ажлуудыг зөвхөн нийслэл юм уу, дүүргийн төсвөөр хийхээр болсон. Ингээд далан жишээлбэл манай сая БЗД-ийн даланг нийслэл юм уу дүүргийн төсвөөр хийнэ. Тэгсэн мөртөө нийслэл, дүүргийн төсөв дээр бид нар санал өгөх эрх байхгүй. Зөвхөн нийслэл юм уу дүүргийн төлөөлөгч л санал өгнө. Ингээд энэ ажлуудаа хийхгүй баахан хүмүүс бухимдаад эхлэхээрээ ингээд нийгмийн бухимдал болохоороо төр засаг яаж байна гээд л ингээд л Улсын Их Хурлын гишүүд улсын төсвөөр энийг шийдэх ёстой гэдэг асуудал үүсээд байх юм аа.

Ер нь цаашид энэ дэд бүтцийнхээ асуудлыг яах юм бэ? Энэ олон хороодын иргэдийн асуудлыг. Дээрээс нь нэмээд нийслэл рүү энэ юунуудыг нь өгчихнө. 2014 оноос хойш явж байгаад жишээлбэл манай 12 дугаар хорооны зарим ажлууд нь дэд бүтцийнх нь ажлууд нь одоо хүртэл ашиглалтад ороогүй. Төсөв нь хүрэлцдэггүй л гэнэ.

Одоо тэгээд сүүлдээ шүүх дээр очоод ингээд маргаантай асуудал болоод явж байна аа. Бүүр болохгүй бол үүнийг хувийн хэвшил нь өөрөө шийдчих боломж байдаггүй юм уу? Бие даагаад энийгээ бие даасан шийдлээ өөрөө хийгээд өөрснөө санхүүжүүлчих бас барилгын компаниуд бяртай компаниуд бас байна аа. Тэр өөрөө хийхгүй өөр хүмүүсээр хийлгэхгүй. Ингээд дунд нь компани нь ч хохироод иргэд нь ч хохироод байх юм аа. Ингэж бас болдоггүй юм уу? Зарим дэд бүтцийг нь Хятадын компаниудаар хийлгэнэ гэж явж байгаад тэгээд явахаа больсон. 2024 оны төсвийг харахад Сэлбэ сэргэлт л явах юм шиг байна. Тэгэхээр бусад нь яана гэсэн үг вэ, нэгд.

Хоёрдугаарт, дээрээс нь нэмээд Шар хад Монелын хэсэг, Дарь эхийн хэсэг гээд Шархадны дэд төвийн төсөл гэж байхад зураг төсөв нь хийгдсэн бас мөнгө байхгүй. Яг 2 адилхан дэд төв эхлүүлчээд нэг дэд төвийнх нь бүх мөнгийг нь тавьж өгчхөөд нөгөөдхийг нь тавьж өгөхгүй. Хэрвээ ийм байх юм бол ер нь энэ гэр хорооллууд чинь яаж хөгжих юм бэ? Хэрвээ өөрснөө хийхгүй юм бол өөр хүнээр концессын гэрээгээр ч бай хамаагүй байгуулаад хийлгэж болдоггүй юм уу? Эндээс холбосон бүх компаниуд нь эндээсээ ашиглалтын зардал өгч байгаа.

**Л.Мөнхбаатар:** Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Даваасүрэн сайд.

**Ц.Даваасүрэн:** Түрүүн нөгөө байхгүй байсан болохоор би дахиад давтаад л хэлье. Ер нь энэ гэр хорооллын дахин төлөвлөлт дээр тулгараад байгаа асуудал бол эрчим хүчний эх үүсвэрээс шалтгаалчхаад байна аа. Дулааны эх үүсвэрээс. Дулааны эх үүсвэрийг хувийн компани хөөрхий бариад явж чадахгүй л дээ. Тэр чинь асар их хэмжээний мөнгө шаардах учраас. Тийм учраас дулааны станц барих асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ хөрөнгийг л уг нь төсвөө 2 дахин нэмж байхын оронд бид нар энэ нэг дутаад байгаа эрчим хүчний эх

үүсвэрийнхээ асуудлыг энэ Монголын Их Хурал нэг яриад шийдчих хэрэгтэй байгаа байхгүй юу. Тойрог тойргийнхоо төсвийг нэмэхийг л бодоод байгаа болохоос биш Монгол Улс эрчим хүчний дутагдалд орж байна гэдгийг ерөөсөө ойлгож өгөхгүй байна шүү дээ.

2024 онд орно оо гэдгийг аль 2017, 2018 оноос хойш л бид ярьсан, байхгүй. Тэгээд эх үүсвэргүй юм чинь хувийн компани яах юм бэ яаж ч чадахгүй шүү дээ. Тэр дулааны станц барьж чадахгүй шүү дээ. Тийм учраас өнөөдрийн гэр хорооллын дахин төлөвлөлт дээр гацаанд орчихсон юм дулаан. Дулааны эх үүсвэр авъя гэхээр байхгүй. Цахилгаан бас байхгүй. Техникийн нөхцөл авъя хүчин чадал хүрэлцэхгүй. Ингээд суучихсан учраас хөөрхий хувийн компаниудыг концессоор байна уу, юугаар байна уу тэрийг чинь шийдэх боломжгүй болгочихсон байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар ер нь нэг ирэх жилийн төсөв дээр манай Их Хурал бүүр ярьж байгаад энэ нэг ДЦС-ын асуудлыг Улаанбаатарт шийдэж өгөх хэрэгтэй. Тэгж байж энэ гэр хорооллын дахин төлөвлөлт энэ орон сууцжуулалт чинь явна аа. Дулааны эх үүсвэргүйгээр эрчим хүчний эх үүсвэргүйгээр энэ явахад хүндрэлтэй. Тэгээд манайхан дээр нь тодруулах юмнууд байвал нэмээд тодруулчих.

**Л.Мөнхбаатар:** Сайдын хэлснээр нэмж тодруулах уу? 82 дугаар микрофоныг өгье ажлын хэсэг хариулъя.

**Г.Ганхүү:** Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Баянзүрх дүүргийн хувьд нийтдээ 5 байршил 23 хэсэгчилсэн талбай байдаг. Өнөөдрийн байдлаар 19 ихэсгэсэн талбай дээр 19 төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж байгаа. Дахин төлөвлөлтийн ерөнхийдөө бас эрчимтэй явж байгаа гол 2 байршил энэ БЗД-ийн нутаг дэвсгэр дээр байна. Энэ нэг нь 12 дугаар хорооны буюу Чулуун овоо орчмын хэсэг, нөгөөх нь 13,

14 дүгээр хороо буюу орон сууцын 14 дүгээр нэгж хорооллын хэсэг байгаа. Бид нар нийслэлийн зүгээс барьж байгаа гол бодлого маань өнгөрсөн хугацаанд эхлүүлчихсэн байгаа байршлууд эхлүүлчихсэн дэд бүтцийн ажлуудыг бүгдийг нь дуусгая аа. Шинээр төсөл эхлүүлэхгүйгээр эхлүүлсэн байгаа ажлуудаа бүх инженерийн, гаднын инженерийн шугам сүлжээний дэд бүтцийн асуудлуудыг дуусгая гэдэг дээр анхаарлаа төвлөрүүлээд ажиллаж байна.

2024 онд нийслэлийн төсөв дээр яг дахин гэр хорооллын дахин төлөвлөлтийн хувьд 17.3 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан. Үүний 60-аад орчим хувь нь буюу 10 орчим тэрбум төгрөг нь зөвхөн БЗД-ийн энэ 13, 14, 12 дугаар хорооны дахин төлөвлөлтийн байршлууд дээр тавигдаж байгаа. Өнөөдрийн байдлаар нийтдээ дахин төлөвлөлтөд нийт 18 мянга орчим айлын орон сууц ашиглалтад орсон байдаг 3100 нэгж талбарт чөлөөлөөд. Бид бүхэн баригдаад явж байгаа орон сууцуудынхаа цахилгаан болон дулааны техникийн нөхцөлүүдийг Эрчим хүчний яамтай зөвшилцөөд энэ ажлуудыг саадгүйгээр ямар ч байсан баригдаж байгаа блокуудаа техникийн нөхцөлүүдийг нь хангаад ашиглалтад оруулаад явж байгаа. Мэдээж бас яг эх үүсвэрийн дутагдалтай байдлаас шалтгаалж байгаа асуудлууд байгаа.

Эрчим хүчний яам нийслэл дээр өнөөдрийн байдлаар бие даасан дулааны эх үүсвэрийн 8 төсөл хэрэгжих гээд ТЭЗҮ хийгдчихсэн. Зураг төсвийн ажил нь хийгдээд явж байгаа ийм 8 төсөл байгаа. Эрчим хүчний яаман дээр 4 төсөл нь хамаарагдаж байгаа. Нийслэл дээр 4 төсөл нь хамаарагдаж байгаа. Эдгээр маань өөрөө хатуу түлшээр болон хийн түлшээр холимог маягаар ажиллах ийм дулааны станцуудын төслүүд явж байгаа. Энэ төслүүдэд урьдчилсан байдлаар нийтдээ нэг 877 тэрбум төгрөгийн санхүүжилт бас

шаардлагатай байгаа гэсэн урьдчилсан тооцоолол нотолгоо байгаа. Баярлалаа.

Амгалангийн дулааны станц маань энэ он гараад 1, 2 дугаар сард ашиглалтад орно. Тэгэхээр Баянзүрх орчмын техникийн нөхцөл дулааны техникийн нөхцөлүүд бас харьцангуй сайжирна гэсэн ийм тооцоо байгаа. Шар хад дэд төвийн хүрээнд нийтдээ Улаанбаатар хотын хувьд 2040 он хүртэл ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэл хөгжүүлэх бодлогын бичиг баримт дээр 6 дэд төвтэй байна гэж тусгасан. Энэ 6 дэд төвийн хүрээнд өнөөдөр Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд бүрэн дууссан байгаа. Үлдсэн 4 дэд төвийн ажлууд бол эхлээд явж байгаа. Бүх зураг төсвүүдийг ТЭЗҮ-үүд бүрэн гараад дуусчихсан. Дамбадаржаа, Толгойт дэд төвүүдийн ажлууд 50 орчим хувьтай явж байна. Үлдсэн Шар хад, Дэнжийн мянга дэд төвүүдийн санхүүжилтийн асуудлыг бид бүхэн бас шийдвэрлэх шаардлагатай энэ нь ойролцоогоор бас 210 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэл санхүүжилт байгаа. Шар хад дэд төвийн хувьд энэ санхүүжилтийн асуудлыг шийдэхэд бүх ТЭЗҮ, зураг төсөв бүх юм бичиг баримтууд батлагдчихсан. Бүрэн бэлэн болчихсон байгаа. Тэгэх юм бол Шар хад дэд төв ашиглалтад орсноор ер нь нийтдээ 6 дэд төв маань ашиглалтад орсноор бид нар 40-өөс 50 мянган айлын орон сууцыг дэд бүтцээр хангах ийм бүрэн боломжтой болж байгаа юм аа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Булгантуяа гишүүн тодруулж асууя.

**Х.Булгантуяа:** Амгалан ДЦС-ын өргөтгөлийн бараг нэмэлт юуг бол техникийн нөхцөлийг бараг аваад дуусчихсан юм байна лээ дээ. 12 дугаар хороонд уг нь энэ бас ч гэж энэ дахин төлөвлөлтөөр орж байгаа компаниуд зарим нь сайн ажиллаж байгаа компаниуд байна. Батхэрээд, Баганат

өргөө, Жигүүр гранд гээд манай Баянзүрх дээр бүтэн байгуулалт хийгээд явж байгаа хүн сайн ажиллаж байгаа компаниуд байна. Тэгэхдээ техникийн нөхцөлөө авч чадахгүй байна. Амгалан дулааны өргөтгөлийг аль хэдийн ашиглалтад орохоос нь өмнө бараг өгөөд дуусчихсан юм шиг байна лээ.

Тэгэхээр цахилгаан станц компаниуд барьж чадахгүй биш уг нь барьж чадна л даа. Гол нь өгдөггүй байхгүй юу. Төр өөрөө л барина гээд, тэгээд өөрөө барьдаггүй өөр хүнд өгдөггүй. Тэгэхээр уг нь бол энэ дахин төлөвлөлттэй шүү дээ. Хэрвээ тийм байсан бол өнөөдөр бид нар эрчим хүчний эх үүсвэртэй болчихгүй байсан юм. Одоо хэн ч нүүрсний цахилгаан станц санхүүжүүлэхгүй болсны дараагаар төр ч өөрөө санхүүжүүлж чадахаараа зарлаж байгаа байхгүй юу. Тэрүүний өмнө 10 жилийн өмнө.

**Л.Мөнхбаатар:** Яах юм тодруулгад хариулах юм уу? Барилга, хот байгуулалтын сайд Даваасүрэн хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ, Монголд дулааны станц хөрөнгөө гаргаад барьчих компани Эм Си Эс-ээс өөр байхгүй ээ. Харин яах вэ Голомт банк нэг Хятадтай хамтраад тэр Бөөрөлжүүт дээр нэг санхүүжилт хийгээд явж байгаа. Өөр лав би станц барья гэж орж ирсэн компани мэдэхгүй юм байна. Юу нөгөө Ньюком чинь нэг Мичигуши гээд гаднын 2 компанитай хамтраад тэгэхдээ нөгөө гаднын хөрөнгө оруулалттай байсан байхгүй юу. Нэг станц барья гэж тэр нөгөө 5 дугаар станц гэдгийг нь будаа болгоод хаячихсан. Тэр нэг байсан юм. Тэрнээс Монголын компани өөрөө хөрөнгөө гаргаад гэдэг юм байхгүй. Гаднаас хөрөнгө босгоё гэхээр нүүрсний санхүүжилт байхгүй. Тийм учраас энийг бол улсаас л анхаарч өгч, гаднын зээл тусламжийн хөрөнгө, мөрөнгөөр хэсэгчилсэн дэд бүтэцтэй байдлаар хэсэгчилсэн инженерийн дэд бүтэц

хэсэгчилсэн дулааны төвүүд байгуулах маягаар л хийхгүй бол дулааны том станцыг нэг компани хийнэ гэдэг тэр чинь байж чадахгүй шүү дээ. 200 сая доллар, 300 сая доллар шаардана. Манайд өнөөдөртөө тийм компаниуд алга байна.

**Л.Мөнхбаатар:** Тодруулга байхгүй ээ нэг удаа л тодруулна, нэг минутаар. Хариулт нэг минутад багтана. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг үг хэлнэ.

**М.Оюунчимэг:** Энэ гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх, гэр хорооллыг орон сууцжуулах эко 0 жорлон гээд л дандаа гэр хороолол ярих юм гээд л намайг тэгээд байдаг юм. Гэхдээ одоо бүгдээрээ ойлгож байна л даа. Яагаад гэвэл энэ ганц гэр хорооллын асуудал биш. Нийслэл Улаанбаатар хотын 1 сая 600 мянга орчим хүний асуудал болчихсон учир энэ утаа, түгжрэл, хөрсний бохирдол, өвчлөл бүгд нотлоод өглөө. Тийм учраас өнөөдөр бүгд анхаарал хандуулж байгаа.

Сая Даваасүрэн сайд яг хэлж байна. ДЦС-ыг барихад 300 сая ам долларын асуудал хэрэгтэй гээд өчигдөр Эрдэнэс Тавантолгой бас Оюу Толгой ингээд хамтраад энийг барьчихъя гэж байсан юм байна шүү дээ. Гэсэн чинь яасан Эрдэнэс Тавантолгой Үг нь энд зарцуулах мөнгө нь байсан боловч нөгөө нэг өөр юм руу санхүүжилтүүд нь ингээд урсаад явчихсан. Үг нь бол хэд хэдэн дулааны цахилгаан станц дэд барьчих мөнгө. Хэдэн тэрбум доллароороо бол үнэнийг хэлэхэд зүгээр гарын салаагаар урсчихсан байна лээ. Тэгээд бид мөнгийг зөв юманд зарцуулж чадвал өнөөдөр энд яригдаж байна шүү дээ. Та түрүүн хэлж байна. Шахмал түлшээ сайжруулахад 200 мянган евро л шаардлагатай. Одоо 2024 онд манай нийслэлийнхэн маань энд суугаад ярьж байна. Энэ гэр хорооллын газар чөлөөлөх, шугам хоолой ингээд бүх



ажлыг хийхэд ойролцоогоор наад тал нь 617 тэрбум төгрөг нийлээд ингээд бодоход 700 орчим тэрбум төгрөг шаардлагатай байна.

Гэтэл өнөөдөр өглөө л гэхэд яригдаж байгаа нүүрсний хулгайд энэ 700 тэрбум төгрөг зүгээр 7 хоног сарын хулгайн мөнгө л байна шүү дээ. Тэгэхээр би Даваасүрэн сайд бас зарчимтай байна. Таныг бас Барилга, хот байгуулалтын сайдаар өнөөдөр ажиллаж байгаа үед энэ үргүй зардлууд, эдийн засгийн үр ашиггүй энэ буруу замаар орсон энэ мөнгөнүүдийг эргүүлэн төлүүлэх ажлуудыг хийж болох бололцоо харагдаж байна лээ шүү дээ. Өчигдөр гэхэд Богд хаан төмөр замын тэр 88 тэрбум төгрөгийн зөрүүгээ гаргаад үлдэгдлийг нь би төлье гээд төр надаас нэхвэл би төлөхөд бэлэн гээд жишээ нь Баясгалан захирал хэлж байх жишээ байна л даа. Тэгэхээр ийм бололцоонуудыг хангая аа. Би энд голд сууж байгаа манай нийслэлийн гэр хорооллын яг энд дэд бүтэц хариуцсан хүмүүсийг бүгд мэдэж байгаа. Үнэхээр хичээж ажилладаг юм. Би эд нартай 2016 оноос хойш гэр хорооллоор мөн ч их явж, мөн ч олон иргэдтэй уулздаг. Эд нар хичээгээд л байдаг. Гэхдээ эд нарт сая яг хэлж байгаа шиг санхүүгийн эрх мэдэл байдаггүй. Гүйцэтгэл хяналтад нь хэрэгжилт тавиад байгаа ч гэсэн нөгөө газар чөлөөлөлт дээр нь очоод гагцхихдаг. Компанийг та нар хурдлуулаач ээ гээд л тэгдэг. Эд нар бид нар нийлж байгаад л компанийг нь шүүхэд ийм шүүх дээр очоод нөгөө компаниуд нь заргалдаад ингээд явчихдаг.

Тэгээд энэ нь өөрөө эцсийн эцэст бид нарын энд ингээд л ухамдана гэж бараг хэлж болох байх. Ингэсээр байтал нөгөө нийслэлийн гэр хорооллын иргэд маань бүүр итгэл алдарч дуусаж байгаа байхгүй юу. Чингэлтэй дүүргийн гэр хороолол үнэндээ дэд бүтэц хамгийн сайн ирчихсэн байгаад байгаа. Хэсэгчилсэн дэд төвүүд, дулааны станц КТП гээд нэлээн сайн юмнууд яваад одоо зөвхөн орон сууц

барих компаниуд орох ийм юм үлдчихсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бас Даваасүрэн сайд минь та анхаараад энэ хотынхонтойгоо нийлж байгаад энэ рүү орох компаниудыг урамшуулаад оруулах ажлыг эрчимтэй хийх хэрэгтэй байна. Хэрвээ Чингэлтэйн гэр хороолол ингээд энэ дэд бүтцээ түшиглээд орон сууцжуулаад явчихвал замын урд талын Сүхбаатар дүүргийн гэр хороолол ч маш богино хугацаанд орон сууцжих, дэд бүтэцжих бололцоо байгаад байгаа юм. Харин одоо нэг ганц таатай мэдээ нь саяын хууль гарсны үр дүнд энэ Сэлбэ дэд төвийг ашиглаад Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүргийн 16 мянга орчим айл өрх орон сууцжуулах ажлыг 2 жилийн дотор хийнэ ээ гэдгийг бол сая бүгд амласан. Энэ бол хийгдэнэ. Яагаад гэвэл Сэлбэ дэд төв маань бэл бэлэн байгаа. Энэнтэй уялдаад харин газар чөлөөлөлттэй холбоотой зардал санхүүжилтүүд бас сууж байгаа юм байна лээ. Эд нар маань тэр уур амьсгалын Ногоон сан гэдгээс 95 сая ам.доллар-ын энэ асуудлуудыг ерөнхийдөө би шийдэж байгаа гэж саяын ярианаас чинь ойлголоо. Өмнө нь бас Сайнзориг дарга, Нямбаатар сайд, хотын дарга эд нар хотын гишүүдтэй уулзахдаа хэлж байсан.

Тэгэхээр одоо хамгийн гол нь ингээд хэд хэдэн газруудын бололцоо байгаад байна. Та бүхэн маань санхүүгийн эх үүсвэрүүдийг улсын төсөвт, нийслэлийн төсөвт, дүүргийн төсөвт, орон нутгийн төсөвт яг ингээд нэг бүрчлэн суулгаад өгөх ажлуудыг бид анхааръя сайд аа. Бид бүгд нийлж байгаад ингээд хийчихвэл бололцоо байгааг бид харж байна шүү дээ. Эрдэнэс Тавантолгойг ашигтай ийм санхүүжүүлдэг болгочихъя. Өнөөдөр хүртэл бид нар тэр хувьцаа ярьж байхад нь хэллээ шүү дээ. Бололцоо байгаа юм байна аа. Өнөөдөр валютын нөөцийг 4 тэрбум ам.долларын түвшинд буюу бараг 4, 5 их наяд хүрчихлээ. Тэгвэл бид энэ мөнгийг зөв юманд нь зарцуулчихъя. Одоо нийслэлийн утаа, түгжрэл, хөрсний

бохирдлоос салах ажлыг хийчихвэл, эмнэлгүүд ингэж өвчтөнөөр дүүрэхгүй. Хүүхдүүд ингэж өвчлөл сургууль хаахад хүрэхгүй. Энэ нь өөрөө нийгмийн эрүүл мэндийн бүх асуудал шийдэгдэнэ. Энийг том түвшиндээ л хийхгүй болохгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ асуулгыг би уг нь 2022 оны 5 сарын 30-нд тавьсан.

Өнөөдөр ингээд жилийн дараа орж ирж байгаа гэхдээ орж ирж байгаа нь чухал. Яагаад гэвэл энэ хугацаанд бид нар бас төсөвтэй уях ажлуудыг бас хийсэн. Нийслэлийн төсөв ингээд ярьж байна. Одоо 2040 хотын төлөвлөгөө орж ирэх гэж байгаа. Түрүүн сайд хэлж байна. Хот одоо төлөвлөгөөгүй явж байгаа шүү дээ гээд. Яг үнэн энэ асуудлыг ч өнөөдөр энд хөндье гэж бодож байсан. Харин та бүхэн маань төлөвлөгөө орж ирэх гэж байгаа юм байна. Яаралтай оруулж ирээд хамтдаа хурдан шийд.

**Л.Мөнхбаатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Монгол Улсын ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

15.18 цаг.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг хэлэлцэх эсэх санал хураалтыг ирэх 7 хоногийн 4 дэх өдөр буюу 28-ны өдрийн 10 цагаас санал хураалтыг явуулна аа.

Эцсийн найруулга сонсох уу?

**Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсьё.**

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан:

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгын саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцъё.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга дээр санал байвал хэлээрэй. Манай Даваасүрэн сайд, Оюунчимэг гишүүн эцсийн найруулга дээр санал байвал хэлнэ шүү.

*Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.*

*Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.*

*Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй*

*байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.*

*Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Ул хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн даргаас сонссонд тооцлоо.*

*Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.*

*Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна*

уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгат дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хянан шалгах түр хорооны ажиллах хугацаа сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хууль тогтоолын эцсийн найруулгыг сонслоо.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

15.25 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ